

"НЭЭЛТТЭЙ СТАНДАРТ" БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ

ХУВИЛБАР 4.0 /2020

DIANE DETOULF / WILDLIFE CONSERVATION SOCIETY



Conservation
Measures
Partnership

ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүйн 4.0 хувилбар нь нээлттэй стандарт аргачлалыг илүү баяжуулан, туршигдаж, Conservation Measures Partnership (CMP)-ийн гишүүдээр хэлэлцэгдэн баталгаажсан хувилбар бөгөөд Байгаль хамгааллын төлөвлөлтийн ах сургагч багш нарын сүлжээ (CCNet) болон CMP-ийн бусад хамтран ажилладаг байгууллагууд өөрсдийн хувь нэмрийг оруулсан бүтээл болсон.

Conservation Measures Partnership (CMP) гэж хэн бэ?

CMP (Байгаль хамгаалах арга хэмжээний түншлэл) нь илүү үр дүнд хүрэхийн тулд хамтран ажиллаж буй Засгийн газрын агентлагууд, санхүүжүүлэгчид болон байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-үүдүн түншлэл юм. Бид сурсан мэдсэнээ сайжруулах, хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгаль хамгаалах ажлаа төлөвлөх, зохион байгуулах үйл ажиллагааны үр дүнгээ хэмжих сайн арга замуудыг эрэлхийлж байдаг.

CMP-ийн одоогийн гишүүд:

African Wildlife Foundation; Bush Heritage Australia; Conservation International; The David and Lucile Packard Foundation; Disney's Animals, Science, and Environment; Durrell Wildlife Conservation Trust; Foundations of Success; The Gordon and Betty Moore Foundation; International Crane Foundation; International Fund for Animal Welfare; Jane Goodall Institute; Keith Campbell Foundation for the

Environment; Margaret A. Cargill Foundation; National Fish and Wildlife Foundation; The Nature Conservancy; Канадын Nature Conservancy; Nature Serve; Puget Sound-ийн Түншлэл; Rare; The Summit Foundation; АНУ-ын хөгжлийн агентлаг USAID; US Fish and Wildlife Service; Walton Family Foundation; Wildlife Conservation Network; WCS;WWF.

Засварлах, шинэчлэх:

CMP нь энэхүү гарын авлагыг баталгаажуулсан ч, цаашид CMP-ийн гишүүд үүнийг өөрсдийн төлөвлөлтийн ажилд ашиглахаа хэсэгчлэн болон бүтнээр нь засварлан, сайжруулж болно. Шинэчлэгдсэн хувилбар, удирдамж материал, CMP-ийн талаарх нэмэлт мэдээллийг CMP-ийн <https://conservationstandards.org/> болон Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын вэбсайтууд www.conservationmeasures.org аас авна уу. Энэхүү стандарт аргачлалын талаарх санал хүсэлт байвал бидэнтэй CMPIinfo@conservationmeasures.org цахим хаягаар холбогдоно уу.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт 4.0 -ийн Хяналтын хороо:

Дараах хувь хүмүүс энэхүү хувилбарыг боловсруулах, сайжруулахад хувь нэмрээ оруулсан бөгөөд цаг зав, оюун ухаанаа зарцуулан ажилласан эдгээр хүмүүст CMP байгууллагын зүгээс талархалаа илэрхийлж байна.


Annette Stewart (Bush Heritage Australia), Ari Cornman (California Fish and Game Commission), Arlyne Johnson (Foundations of Success), Ashleigh Baker (Foundations of Success), Brad Northrup (Conservation Coaches Network), Caroline Stem (Foundations of Success), Catherine Payne (Durrell Wildlife Conservation Trust), Diane Detoeuf (Wildlife Conservation Society), Clair Dougherty (Bush Heritage Australia), Dan Salzer (The Nature Conservancy), Felix Cybulla (Independent, Conservation Coaches Network), Gustavo Gatti (Conserve Brazil), Hui Shim Tan (WWF-Malaysia), Ilke Tilders (Foundations of Success), Irina Montenegro (WWF Chile), John Morrison (WWF US), Judy Boshoven (Foundations of Success), Kerryn Morrison (Endangered Wildlife Trust), Lydia Gaskell (WWF International), Marcia Brown (Foundations of Success), Mariano de la Maza (CONAF Chile), Mariella Saenz (Pronatura), Nick Salafsky (Foundations of Success), Oscar Maldonado (Independent, Conservation Coaches Network), Patrick Crist (PlanIt Forward), Philippa Walsh (Community Solutions), Sandra Andraka (UNDP), Thomas Miewald (US Fish and Wildlife Service), and Will Beale (WWF-UK).

Байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүйн олон хувилбарыг хянан, боловсронгуй болгох, сайжруулахад чухал санал оруулсан Байгаль хамгааллын стандартын нийгэмлэгийн хүмүүст мөн талархал илэрхийлж байна.



ГАРЧИГ

Танилцуулга	1
Оршил	2
Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын зорилго	3
Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын эхлэл ба хувьсал	4
Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт болон бусад шийдвэр гаргахад дэмжлэг болдог аргачлалуудын уялдаа	5
Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг ашиглах нь	6
Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох нь	7
Ерөнхий зарчим ба анхаарах зүйлс	9
1. Тодорхойлох	12
1A. Төлөвлөлтийн зорилго тодорхойлох, багийг бүрдүүлэх	13
1B. Хамрах хүрээ, Алсын хараа, Хамгаалах үнэт зүйлийг тодорхойлох	14
1C. Ноцтой аюул, дарамтыг тодорхойлох	19
1D. Хамгааллын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох	21
2. Төлөвлөх	26
2A. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах: Зорилго, Стратеги, Таамаглал, Зорилтууд	27
2B. Албан ёсны мониторинг төлөвлөгөө боловсруулах, Үнэлгээ, Суралцах төлөвлөгөө	38
2C. Хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	44
3. Хэрэгжүүлэх	46
3A. Богино хугацааны нарийвчилсан төлөвлөгөө болон хэрэгжүүлэх хугацаа	47
3B. Төсвийг боловсруулах, сайжруулах	49
3C. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	50
4. Үр дүнг үнэлэх, төлөвлөгөөг уялдуулах	54
4A. Мэдээллийг дүгнэн шинжлэхэд бэлтгэх	55
4B. Үр дүнд дүн шинжилгээ хийх	56
4C. Стратегийн төлөвлөгөөг уялдуулах	58
5. Хуваалцах	60
5A. Сурснаа баталгаажуулах	61
5B. Үр дүнгээ хуваалцах	61
5C. Суралцах орчныг дэмжих	63
Төлөвлөлтийн алхмуудыг зангидах	65
ХАВСРАЛТ	67
Хавсралт 1. Нэр томъёоны тайлбар	68
Хавсралт 2. Голлох нэр томъёоны тайлбар шалгуур	72
Хавсралт 3. Ерөнхий зарчим анхаарах асуудал	73
Хавсралт 4. Байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүйн тойм, гарах үр дүн	76



ТАНИЛЦУУЛГА

ОРШИЛ

Байгаль хамгааллын мэргэжилтнүүд нь байгаль орчинд тулгамдаж буй төвөгтэй бөгөөд цогц асуудлуудыг шийдвэрлэдэг. Дэлхий даяар хүмүүс бидэнд итгэн найдаж, бидэнтэй зэрэгцэн байгаль дэлхийгээ илүү үр дүнтэй хамгаалахад нөөц боломжоор хангаж байдаг. Бидэнд урт хугацааны туршид нөлөө үзүүлэх асар их боломж байгаа бөгөөд дэвшил гаргаж чадаж буй ч цөөн тооны байгаль хамгааллын байгууллагууд нь юу болж байгаа, юуг сайжруулах эсвэл өөрчлөх ёстойг зааварлан, зөвлөж байдаг.

Хир үр дүнтэй ажиллаж буйг хэмжихгүй, өөрсдийн ажлаа дүгнэхгүйгээр тавьсан зорилгодоо хүрч буй эсэхээ хэрхэн мэдэх вэ? Хэрхэн илүү үр дүнтэй ажиллах вэ? Хэрхэн бусдын амжилт, алдаанаас суралцах вэ? Бид өөрсдийн ололт амжилтаа хэрхэн бусдад харуулж, тулгарч буй бэрхшээлийг даван туулахын тулд олон нийт, улс төрийн дэмжлэгийг хэрхэн авч чадах вэ?

Байгаль хамгаалагчдад төлөвлөх, менежмент, мониторинг болон суралцах сайн систем нэн даруй хэрэгцээтэй байна. Бид мэдээлэл дутмаг нөхцөлд ч одоо байгаа боломжтой баримт мэдээлэлдээ үндэслэн уян хатан менежментийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Ямар ч тохиолдолд үр дунгээ системтэйгээр үнэлэх, тухайн мэдээллийг ашигласнаар юу нь болдог, юу болдоггүйг бие биенээсээ сурч мэдэх хэрэгцээ байсаар байна.

Эдгээр хэрэгцээ, шаардлагын үүднээс Conservation Measures Partnership (CMP) нь 2002 оноос хойш ажиллаж байгаа бөгөөд ингэхдээ байгаль хамгаалах нотолгоонд сууриссан, дасан зохицох менежмент болон бусад шийдвэр гаргахад дэмжлэг болдог аргачлалуудаас авсан зарчим, шилдэг туршлагыг нэгтгэн, байгаль хамгаалах үйл ажиллагааны Нээлттэй стандартыг¹ (Цаашид Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт гэх) бий болгосон. *Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт* нь байгаль хамгаалах төсөл, хөтөлбөрийг загварчлах, менежмент, байгаль хамгаалах ажлыг сайжруулах мониторингийн ажилд нийтлэг концепц, аргачлал, нэр томъёог нэгтгэн гаргасан. *Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг* аль ч газар нутаг, түр зуурын эсвэл программын түвшинд ашиглаж болно.

CMP-ИЙН АЛСЫН ХАРАА

CMP-ийн алсын хараа нь дэлхийн хэмжээнд байгаль хамгааллыг хэрхэн илүү үр дүнтэй болгох, мэдсэнээ хэрхэн бусадтай хуваалцах, юунаас зайлсхийн зэргийг бодит туршлага дээр үндэслэн нээлттэйгээр хуваалцахад оршино. Энэхүү алсын харааг бодит болгох бидний эрмэлзэл нь:

- Хамгааллын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, нотолгоо, туршлагад үnlэслэн шийдлийг олох
- Бидний хүсч буй үр дүн бол үйл ажиллагаа биш харин байгаль орчныг хамгаалснаар гарсан үр дунгээр илэрхийлэгдэнэ
- Хүссэн үр дүнд хүрэх амжилтандаа мониторинг хийх
- Сургамжиндаа үндэслэн стратегиа уялдуулж байх
- Сургамж, туршлагадаа үндэслэн талуудад мэдээллийг шударга, ил тодоор хүргэж байх

Гишүүдийн оруулсан саналыг бүтнээр нь үзэхийг хүсвэл эндээс харна уу [CMP's Charter](#).

1. “Нээлттэй стандарт” нээлттэй эх сурвалж/олон нийтийн хамтын хүчээр өөрчлөлт, шинэчлэлт хийгддэг үнэгүй ашиглах, бүгдэд нээлттэй, аль нэг байгууллагын өмч биш юм. 4.0 хувилбарт, CMP нь хүмүүст илүү хүртээмжтэй, ойлгомжтой байлагах үүднээс нэрийг “Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт” өөрчилсөн. Бүтэн нэр нь цаашид өөрчлөгдхүй.

БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН СТАНДАРТ АРГА ЗҮЙН ЗОРИЛГО

Байгаль хамгааллын төлөвлөлтийн багуудад алсын хараагаа бодит болгохын тулд байгаль хамгаалах төслүүдээ амжилттай хэрэгжүүлэхэд нь туслах үүднээс сайн туршлагуудыг багтаасан² таван алхам бүхий менежментийн төлөвлөлтийн арга зүйг танилцуулж байна.



АЖЛАА ТОХИРОМЖТОЙ АЛХМААС НЬ ЭХЛҮҮЛЭХ

Төлөвлөлтийн баг нь байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг заавал 1-р алхамаас эхлэх шаардлагагүйгээр өмнө нь ямар ажил хийгдсэн, төлөвлөлтөө хаанаас эхлүүлэхийг харгалzan үзэх ёстай. Төлөвлөлтийн алхмуудын аль ч хэсгээс нь эхлэж болох бөгөөд нөхцөл байдалтайгаа танилцсаны дараа бусад хэсгүүд дээрээ ажиллаж болно.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт нь яштал дагаж мөрдөх жор биш бөгөөд талуудын оролцоотойгоор ил тод, шударга шийдвэр гаргах, бусадтай амжилт сургамжаа хуваалцах арга хэрэгсэл юм. Төлөвлөлтийн баг нь байгаль хамгааллын төлөвлөгөөг боловсруулахдаа нэн тэргүүнд хаана, юу хийх хэрэгтэй байгааг тогтоохын тулд олон төрлийн арга ашиглаж болно. Тухайлбал орон зайн дүн шинжилгээ хийх гэх мэт. Мөн байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт нь хүний нөөцийн менежмент, гэрээ байгуулах зэрэг захирагааны үйл явц, чиг үүргийг орлуулах бус, нөхөх зорилгоор бүтээгдсэн. Энэхүү гарын авлага нь зааварчилгаа биш, стандарт болон зарчимд суурилсан, харин "Яаж хийх" тухай гарын авлагыг СМР-ийн гишүүдийн боловсруулсан олон төрлийн эх сурвалжаас

авах боломжтой (Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэсгийг үзнэ үү). Энэхүү арга зүйн талаархи санал, сэтгэгдлээ бидэнд ирүүлэхийг хүсвэл CMPIinfo@conservationmeasures.org хаягаар хандана уу.

2. Байгаль хамгаалах том жижиг бүхий л үйл ажиллагааг бид "Төсөл" гэж тодорхойлж болно. Үүнд: тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тулд менежерүүд, судлаачид, бүлэг нөхөрлөлийн гишүүд зэрэг, хамтран ажилладаг байгууллагуудын цогц үйл ажиллагааг хэлнэ. Энэ гарын авлагад бид "Төсөл" гэдэгт хийж буй төлөвлөлтийн ажил болон хэсэг төслүүдийг нийтэд нь "Төсөл" гэж авч үзсэн. Жишээ нь: (жижиг цөөрөмнөөс авхуулаад дэлайт хүртэл төсөл гэж нарлэж болно)

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙН ХУВЬСАЛ

Нээлттэй стандарт арга зүй нь СМР болон бусад байгууллагуудын хамтын бүтээл юм. Анхны хувилбар 1-ийг 2002 оноос туршин ашигласаар 2004 онд Байгаль хамгааллын Үр Нэлөөг Хэмжих Санаачлагын бүтээл болгосон бөгөөд байгаль хамгааллын сайн жишиг загварын нийтлэг арга зүй, менежмент, мониторинг зэргийг багтаасан 7 хэсгээс бүрдэнэ.

Арга зүй боловсруулах судалгааны үр дунд уян хатан менежментийн хэд хэдэн зарчим бий болсон. Үүнтэй зэрэгцэн СМР байгууллага нь бусад байгууллагуудын ашигладаг аргачлал, нэр томъёоны ижил төстэй болон ялгаатай байдлыг нэгтгэн "Rosetta Stone" аргачлалыг бий болгосон. Эдгээр бүтээгдэхүүнд үндэслэн СМР-ийн гишүүн байгууллагууд байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг өөрийн туршлагад нийцүүлэн, ялангуяа биологийн олон янз байдлыг хамгаалахад онцгойлон анхаарч боловсронгуй болгож ирсэн.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг хэрэгжүүлэх нь байгууллагын нягт уялдаатай стандартыг боловсруулж, илүү нарийвчилсан зааварчилгааны материалыг алхам бүрт гарган, дэлхийн өнцөг булан бүрт төслийн багуудын сургамж, туршлагыг багтаасан тасралтгүй, динамик үйл явц юм. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг амжилттай ажиллуулахын тулд СМР-ийн олон гишүүд болон түвшн байгууллагууд шаргуу ажиллаж, байгаль орчны салбарын нийтлэг бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй болоход туслах хөдөлгөгч хүч болгож ирсэн. Үүний зэрэгцээ Байгаль хамгааллын төлөвлөлтийн сургагч багш нарын сүлжээ (CCNet) нь байгаль хамгаалах стандартыг сурталчлах, хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх замаар дэлхийн механизм болгон өргөжүүлэн, байнгын сайжруулалт хийсээр байна. Хайрцааг 1-д 4.0 хувилбарын гол шинэчлэлийг онцлон харуулав.

ХАЙРЦАГ 1: 4.0 ХУВИЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

Хувилбар 4.0 нь СМР-ийн гишүүд болон Байгаль Хамгааллын Төлөвлөлтийн Стандарт арга зүйг ашигладаг байгууллагуудын хамтын оролцоо, хамтын хүчин чармайлт, тэдний хэрэгжилтийн явцад олсон туршлагад үндэслэн сайжруулах дараахи саналуудыг оруулсан:

- Шинэ төрх, мэдрэмжтэй боловч техникийн агуулга нь гайхалтай хэвээр байна
- 3-5-р алхамуудын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх
- Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт нь дасан зохицоо менежмент, нотолгоонд сууриссан хамгааллын зарчмуудыг хэрхэн дэмжиж байгааг тодруулах
- Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт болон бусад шийдвэрийн дэмжилгийн тогтолцооны уялдаа холбоог тодруулах
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг сайжруулах
- Гол ойлголтуудыг илүү сайн хүргэхийн тулд нэр томъёог өөрчлөх
- Нийгмийн хэмжээс, хүний сайн сайхны талаархи СМР-ийн удирдамжаас оруулсан шинэчлэлүүдийг нэгтгэх
- Сэдэвчилсэн төслүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар сайжруулсан тайлбар өгөх
- Үе шатуутай холбоотой орон зайн хэмжээсийг хүлээн зөвшөөрөх
- Үндсэн стандартуудад анхаарлаа төвлөрүүлж, "хэрхэн яаж хийх" зааврыг багасгах

БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН СТАНДАРТ АРГА ЗҮЙ БОЛОН БУСАД ШИЙДВЭР ГАРГАЛТЫГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙНҮҮДИЙН УЯЛДАА

Байгаль хамгаалах үйл ажиллагааны нээлттэй стандарт араг зүй нь байгаль хамгаалах шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ашигладаг хэд хэдэн арга зүйнүүдийн нэг юм. Бусад жишээ нотолгоонд суурилсан дадлага, шийдвэр гаргах бүтэц, стратегийн алсын хараа, байгаль хамгааллын системтэй төлөвлөлт, системтэй нягтлах зэрэг орно ([Schwartz et al 2012](#)-оос харна уу)

Эдгээр арга зүйнүүд нь нийтлэг шинж чанартай боловч өөр өөрийн давуу талыг илтгэсэн нэмэлт арга хэрэгслүүдтэй гэж үздэг. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт нь бусад арга зүйнүүдийн гол зарчмуудыг тодорхой тусгасан бөгөөд тодорхой алхмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бусад арга зүйнүүдээс холбоотой хэсгүүдийг нь авч нийцүүлэн ашиглаж болох юм. Үүний нэг жишээ бол системтэй шийдвэр гаргахад ашигладаг хэрэгсэл болох үр дагаврын хүснэгтүүд нь стратегийн тэргүүлэх чиглэл, сонголтыг дэмжиж чаддаг. Үүнтэй адил нөхцөл байдлын дун шинжилгээ, үр дүнгийн хэлхээс (Байгаль Хамгааллын Төлөвлөлтийн Стандартуудын үндсэн хэрэгсэл) нь нарийн төвөгтэй харилцааг товч бөгөөд үр дүнтэй харуулах замаар бусад арга зүйнүүдийг дэмжиж чаддаг.



БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН СТАНДАРТ АРГА ЗҮЙГ АШИГЛАХ

Байгаль хамгаалах төлөвлөлтийн стандарт арга зүйг ашиглах нь шинжлэх ухаан, үрлагийн хослол хэмээн хэлж болох юм. Та болон танай багийнханд бодит нөхцөл байдалд үр дүнтэй хэрэгжүүлэхэд уян хатан, хариу үйлдэл үзүүлэх тодорхой туршлага шаардлагатай байгааг олж мэднэ. Жишээлбэл, Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүй нь дэс дараатай алхам эсвэл үе шаттай явдаг ч төлөвлөгөөг боловсруулахад заримдаа шууд шугам шиг шулуун явах нь ховор байдаг. Иймээс тэд төлөвлөлтийн алхмуудын үе шатуудаар наана цаана орж болдог. Үүнтэй адил бүх стандарт арга зүй нь бүх төслүүдэд тохирохгүй тул эдгээр стандартыг өөрийн нөхцөл байдалд хэрхэн нийцүүлэхээ тодорхойлох хэрэгтэй болно.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүй нь таван алхамтай бөгөөд тус бүрдээ (Зураг 1) мөн жижиг үе шатуудыг багтаасан бөгөөд үг хэллэгүүдийг тайлбарласан тодорхойлолтуудыг оруулсан (бүх үр дүнгийн жагсаалтыг Хавсралт 4-ээс үзнэ үү). Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын үйл явц нь төвөгтэй байж магадгүй ч, та эдгээр алхамын олонхийг аль хэдийн хийж байсан байх. Алхам тутамд өө сэвгүй үр дүн гаргахыг зорихын оронд санаатай хэрнээ хурдан хугацаанд үе шатуудыг дамжин, үр дүнгийн боломжийн таамаглалыг гаргаж, дараа нь төсөөллөө дахин хянах давталт бүхий үйл явц гэж үзэх нь тустай. Үүний нэгэн адил, мэдээллийн зөрүүтэй тулгарлавал сандралгүй - хамгийн боломжийн мэдээллээр гол шийдвэр, таамаглалыг баримтжуулах хэрэгтэй.

ТУСЛАМЖ ОЛОХ

[Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын вэбсайтын номын сангийн](#) төрөл бүрийн нөөцийн ихэнхийг Байгаль Хамгааллын Төлөвлөлтийн Стандартын байгууллагуудын гишүүдийн бүрэлдэхүүн хянан үнэлж, шинэ нөөцөөр тогтмол нэмэж байдаг.

[Байгаль хамгааллын сургагч багш нарын сүлжээний вэбсайт нь](#) таныг сургагч багш нартай болон байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын төрөл бүрийн алхамуудаар дамжуулан туслах багуудыг дэмжихэд чиглэсэн тодорхой материалыдтай холбож өгнө.



PHOTO: DAVID SULZER / THE NATURE CONSERVANCY

Зураг 1.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүйн алхмууд

1. Тодорхойлох

- Төлөвлөлтийн зорилго, баг
- Хамрах хүрээ, алсын хараа, хамгаалах үнэт зүйл
- Ноцтой аюул, дарамт
- Хамгааллын өнөөгийн нөхцөл байдал



5. Хуваалцах

- Сурсан зүйлээ баримтжуулах
- Сурснаа хуваалцах
- Суралцах орчныг дэмжих

2. Төлөвлөх

- Зорилго, стратеги, таамаглал, зорилт
- Мониторингийн төлөвлөгөө
- Үйл ажиллагааны төлөвлөгөө

3. Хэрэгжүүлэх

- Ажлын төлөвлөгөө, хугацаа
- Төсөв
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх

4. Үр дүнг үнэлэх, уялдааг хангах

- Мэдээллийг дүгнэн шинжлэхэд бэлтгэх
- Үр дүнд дүн шинжилгээ хийх
- Төлөвлөгөөг уялдуулах

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Төслийн багууд байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартад заасан өндөр түвшний стандарт, зарчмуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гарын авлага авах янз бүрийн арга замууд байдаг.

Сургагч багш нар

Төлөвлөлт, хэрэгжилтэд үр дүн, нотолгоонд суурилсан хандлагыг ашиглах нь ихэвчлэн байгууллага, хувь хүмүүсийн сэтгэх, ажиллах хэлбэрт гарсан эрс өөрчлөлтийг тусгадаг тул Байгаль хамгааллын

төлөвлөлтийн стандартыг шинээр ашиглах багууд сургагч багштай ажиллах нь их тустай байж болох юм.

Зарим байгууллагуудад Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын арга зүйд суралцсан, багийн гишүүдийг хэрэгжилтийн үйл явцад дэмждэг өөрийн сургагч багш настай байдаг. Зарим байгууллага, зөвлөхүүд Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын чиглэлээр мэргэшсэн байдаг. Эдгээр хүмүүсийн ихэнх нь СМР-ийн түнш болох бүс нутагтаа тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, чухал газруудыг хамгаалахаар ажиллаж буй багуудыг дэмжих зорилгоор тив бүр дэх сургагчдыг бүрдүүлэх зорилго бүхий [Байгаль хамгааллын сургагч багш нарын сүлжээний](#) (CCNet) нэг хэсэг байдаг.

Удирдамж болон арга зүй

СМР-ийн гишүүн байгууллагууд, түншүүд үндсэн сэдвүүдийн талаар алхам алхамаар удирдамж болон нарийн мэдээлэл өгөх олон төрлийн арга зүй, хэрэгслийг боловсруулсан. Зураг 2-т үзүүлсний дагуу эдгээр эх үүсвэрүүд нь зарчим, практик хэрэгжилтийг дэмжихэд тусалдаг. Тухайн гарын авлагуудад байгууллагын онцлог зааварчилгаа, ангиллын систем (жишээлбэл, байгаль хамгаалах аюул, дарамт ба үйл ажиллагааны ангилал), онлайн курс, туршлага, хичээлийн хөтөлбөр зэрэг багтана.

Зураг 2.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүй болон холбогдох гарын авлагуудын хоорондын хамаарал

Сайн туршлагуудын тайлбар



Миради программ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын нэг буюу хэд хэдэн алхамыг дэмжихийн тулд олон программ хангамжийг ашиглаж эсвэл тохируулж болно. [Миради программ](#) нь(хэд хэдэн хэл дээр байдаг) байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын гол үе шатууд дээр ажиллахад зориулагдсан. Энэ программ нь багууд юуг хамгаалахыг хүсэж байгаа, гол аюул дарамт, боломжууд, тэргүүлэх стратеги, тодорхой үйл ажиллагаа болон хүлээгдэж буй үр дүн, зорилго, зорилтууд, үр дүнд хүрэх ахиц дэвшлийг төсөөлөх, баримтжуулах хэрэгсэл болж өгдөг. Миради программ нь стандарт өнгө, дүрсээр дамжуулан байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг мэддэг хүмүүсийн ойлголцох хэлийг бий болгоход тусалдаг. Миради нь гол хэлэлцүүлэг, нотолгоо, шийдвэрийг баримтжуулах янз бүрийн чиглэлийг санал болгодог бөгөөд энэ нь [дасан зохицох менежмент](#),

Эдгээр материалыг Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын вэбсайт дээрээс (<https://conservationstandards.org/>) авах боломжтой бөгөөд ихэнх удирдамж материалыг СМР, CCNet-ийн гишүүдийг төлөвлөсөн институтуц хоорондын хороо шалгаж, үнэлсэн болно.

Мөн Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын уламжлалт арга зүйгээс гадна шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх олон янзын жишээ материалыг (жишээлбэл, орон зайд эрэмбэлэх хэрэгсэл, хувилбарын төлөвлөлт, үр дүнгийн хүснэгт гэх мэт) багууд ашиглаж болно.

нотолгоонд сууринсан хадгалалт, илүү өргөн хүрээнд суралцахад дэмжлэг үзүүлэх чухал шинж чанар юм³.

Миради програм нь үүлэн технологид шилжин ([via Miradi Share](#)) багаар хамтран ажиллах, төсөл хоорондын болон зохион байгуулалтын чиглэлээр суралцах нэмэлт чадварыг бий болгодог.

Miradi Share нь байгаль хамгаалах стратегитай холбоотой өөрчлөлтийн онол эсвэл хүлээгдэж буй үр дүнг тодорхойлоход чиглэсэн баталгаажуулсан загвар, жишээний сан болоо [Байгаль хамгаалах арга хэмжээ ба үнэлгээний санг \(CAML\)](#) дэмждэг. Эдгээр давуу талыг үл харгалзан Миради бүх нөхцөл байдалд тохирогчийг байж болох тул баг нь тохирох эсэхийг тодорхойлох хэрэгтэй.

3. Доогуур нь зурсан нэр томъёоны тодорхойлолтыг толь бичгээс үзнэ үү.

[Miradi](#) болон [Miradi Share](#) website, Миради-ийн [YouTube](#) суваг нь видео, тодорхой сэдвээр богино хэмжээний гарын авлага, танилцуулгыг санал болгодог.

Ерөнхий зарчим ба анхаарах зүйлс

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйн бүх үе шаттай холбоотой хэд хэдэн зайлшгүй зарчим, анхаарах зүйлс байдаг. Хавсралт 3-т эдгээрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн бол Шигтгээ 2-т дээд түвшний хураангуйг оруулсан болно.

Зорилго, зорилтууд, стратеги, үйл ажиллагаа, хамгаалах үнэт зүйлс, чухал үе шат, үр дүн гэх мэт техникийн нэр томъёоны харьцангуй утгын талаар маргаанууд гардаг. Нийтээр тохирсон ойлголт байхгүй ч **Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт араг зүй нь** төслийн багийн гишүүд болон хамтран ажиллаж буй хүмүүсийн сонгосон нэр томъёоны талаар тодорхой бөгөөд нийтлэг тодорхойлолтой байх нь маш чухал тул энэхүү баримт бичигт тусгагдсан техникийн нэр томъёог нарийвчлан сонгож, эхний тодорхойлолтын доогуур тодотгон зурж, туштайгаар ашиглан, эцэст нь тайлбар толь бичигт тодорхойлсон болно. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд өөрчлөгдж байдаг тул үндсэн зарчим, алхамуудыг сайжруулахын тулд 4.0 хувилбарт зарим шинэчлэлт, тодруулгыг багтаасан болно (Хүснэгт 1).

ХАЙРЦАГ 2: ҮНДСЭН ЗАРЧМУУД БОЛОН АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ХУРААНГУЙ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйг ашиглахдаа дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй (дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү).

Зарчим

- Түншүүдтэй хамтран ажиллах
- Оролцогч талуудыг татан оролцуулах
- Нотлох баримтыг зохих ёсоор ашиглаж, хувь нэмэр оруулах
- Тодорхой бус байдалд дасан зохицох менежментийг ашиглах
- Шийдвэрээ баримтжуулах
- Суралцах орчныг бий болгох

Анхаарах зүйлс

- Эдгээр стандарт нь цаг хугацааны явцад өөрчлөгднө
- Эдгээр стандарт нь "хамгийн тохиромжтой" байдлыг илэрхийлдэг
- Эдгээр стандарт нь тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон гэж үздэг
- Цөөхөн төсөл төлөвлөлтийн ажлаа эхлүүлэхдээ байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйг ашиглаж эхэлдэг
- Төсөл бүр өөр тул **байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг** ашиглахдаа тохируулах шаардлагатай
- Эдгээр стандарт нь аливаа орон зайн болон/эсвэл цаг хугацааны цар хүрээтэй төсөлд хамаарна
- Эдгээр стандартын гол зорилго **байгаль хамгаалахад** чиглэсэн ч дасан зохицох боломжтой
- Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйг олон янзын хэрэгсэл ашиглан хэрэгжүүлж болно
- Эдгээр стандарт арга зүйн нэр томъёог тодорхой болгож, туштай ашиглахыг эрмэлздэг

Хүснэгт 1.

4.0 хувилбар дахь шинэчилсэн нэр томъёо

ӨМНӨХ НЭР ТОМЬЁО/ ОЙЛГОЛТ	ШИНЭ НЭР ТОМЬЁО/ ОЙЛГОЛТ	ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ
Нээлттэй стандарт	Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүй	“Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүй” эдгээр стандартын зорилгыг илүү сайн тодорхойлдог. Энэ нь шинэ хэрэглэгчдэд интернетэд хайх боломжийг хөнгөвчлөх болно. Бүтэн нэр нь “Байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүй” хэвээр байна.
Нөхцөл байдлын дүн шинжилгээ	Шалтгаан үр дагаварын дүн шинжилгээ	“Үзэл баримтлалын загвар” нь маш өргөн цар хүрээтэй байж болно. “Нөхцөл байдлын загвар” нь нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх явцыг илүү тодорхой холбож өгдөг (нөхцөл байдлын загварыг диаграмм хэлбэрээр харуулах боломжтой).
Таамаглал/үр дүнгийн хэлхээс	Өөрчлөлтийн онол	Бид “таамаглал” эсвэл “үр дүнгийн хэлхээ” ний зарчмыг алдалгүй, харин “өөрчлөлтийн онол”-ыг нэмж түгээмэл нэрийг ашиглан илүү хялбар болгосон. Үр дүнгийн хэлхээс нь өөрчлөлтийн онолын харагдах диаграмм юм.
Шууд аюул,	Шууд аюул, дарамт	“Дарамт” нь албан ёсны байгаль хамгаалах төлөвлөлтийн ижил утгыг илрхийлнэ. Энэ нь зарим оролцогчдын “аюул” гэж ангилах асуудлаас зайлсхийнэ.
Стратеги	Стратеги эсвэл интервенци	“Интервенц” гэдэг нь “стратеги” гэсэнтэй ижил утгатай. Стратеги нь өндөр түвшний шинж чанартай (жишээлбэл, тогтвортой далайн бүтээгдэхүүний хэрэглээг дэмжих) эсвэл илүү тодорхой (жишээлбэл, мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг хэрэгжүүлэх эсвэл жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд нөлөөлөх) байж болно. Стратегийн мөн чанарыг тодруулахын тулд багууд “өндөр түвшний” эсвэл “тодорхой” гэх мэт тодорхойлолтыг ашиглаж, “интервенц”-г илүү тодорхой, зорилтот арга хэмжээний хүлээн зөвшөөрөгдсөн ижил утгатай үг болгон ашиглаж болно.
Үйлдэл(тодорхой бус)	Үйл ажиллагаа	“Үйлдэл” нь стратеги, үйл ажиллагааны хамтын нэр томъёо. Бид өмнө нь энэ нэр томъёог ерөнхийлөн ашиглаж (жишээлбэл, Байгаль хамгаалах үйл ажиллагаа, эсвэл Байгаль хамгаалах үйл ажиллагааны ангилал зүй), гэхдээ үүнийг бүх түвшинг хамарсан гэж тодорхойлоогүй байсан.
Алхамын нэр:	Алхамын нэр:	Шинэ алхамууд нь илүү энгийн, бага үг хэллэгийг ашигласан. Богино нэр нь илүү санамжтай, зөвхөн алхамын ерөнхий нэрийг харуулсан, дахин давтагдах мөчлөгийн зураглалд тохирсон.
1. Төсөөлөх 2. Үйл ажиллагааг төлөвлөх ба хянан үнэлэх 3. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба мониторинг 4. Дүн шинжилгээ хийх, ашиглах, дасан зохицуулах 5. Суралцах ба туршлагыг хуваалцах	1. Тодорхойлох 2. Төлөвлөх 3. Хэрэгжүүлэх 4. Үнэлэх & төлөвлөгөөг 5. Уялдуулах Хуваалцах	
Хүний сайн сайхны төлөөхи зорилт	Гүн ногоон зууван (мөн хүрэн)	Загварын энэ өөрчлөлт нь хүний сайн сайхны төлөө зорилгыг харуулах өнгөтэй холбоотой. Бор өнгөөр тодотгон ашигладаг нь хэвээр байгаа (Мирадигийн шинэчлэлт хараахан гараагүй байгаа тул) гүн ногоон өнгө нь зорилтуудын ялгааг харуулсан шинэ сонголт юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН СТАНДАРТЫН УЯЛДАА



Уур амьсгэлын өөрчлөлт нь ойрын ирээдүйд ч үргэлжлэн, дэлхийн дундаж температур жилд 2.0°C-ээс дээш өсөх төлөвтэй байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор далайн түвшин нэмэгдэж, улирлын шинж чанар, шуурга, хур тунадасны цаг хугацаа, хэмжээ өөрчлөгдсөөр байна.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйг анх боловсруулж байх үед радарын дэлгэцэн дээр бараг хардадгүй байсан цаг уурын өөрчлөлттэй тэмцэх нь дэлхийн байгаль хамгааллын тэргүүлэх зорилт болж, байгаль хамгаалах аливаа төслийг боловсруулах, менежмент хийх мэргэжилтнүүдийн анхаарах ёстой асуудал болоод байна. Үүнийг харгалзан, байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөхөөс илүү түүнд дасан зохицоход чиглэсэн сэдэв бүхий хайрцгуудыг багтаасан болно. Эдгээр нь хоёулаа чухал хариу арга хэмжээ боловч үүнийг бууруулах арга хэмжээ нь одоо байгаа Байгаль Хамгааллын Төлөвлөлтийн Стандартын хүрээнд бүрэн нийцэж байгаа тул дасан зохицоход бэлтгэхийн тулд шинэ хэрэгсэл боловсруулах эсвэл одоо байгаа хэрэгслийг өөрчлөх шаардлагатай.

Энэхүү баримт бид янз бүрийн алхамуудтай холбоотой цаг уурын онцлог шинж чанарыг харуулахын тулд ийм ногоон хайрцгийг ашиглах болно. Ерөнхийдөө бид уур амьсгалын өөрчлөлтөөс БОЯБ-д, экосистемд үзүүлж болзошгүй нөлөөлөл, хүмүүст үзүүлэх нөлөө, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх хүний хариу үйлдэл, экосистемд үзүүлэх шууд бус нөлөөлөг задалж, ойлгохыг онцолсон. Уур амьсгалын ирээдүйн тодорхойгүй байдлыг хязгаарлахын тулд уур амьсгалын өөрчлөлтийн олон хувилбаруудыг ашиглахыг зөвлөж байна.



ТОДОРХОЙЛОХ

ТОДОРХОЙЛОХ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын энэ үе шатанд төслийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлдэг. Ялангуяа төлөвлөлт хийх болсон зорилго, төслийн багийн бүрэлдэхүүнийг эхний байдлаар тогтоож, төсөл хэрэгжүүлэх газарзүйн байршил, хамрах хүрээ, ирээдүйн зорилго болох алсын хараа болон байгаль хамгааллын үнэт зүйлсээ тодорхойлоход төвлөрнө. Түүнчлэн учирч буй аюул дарамт, боломж бололцоо болон гол оролцогч талуудыг тодруулах зэрэг төслийн ерөнхий нөхцөл байдлыг ойлгох асуудлууд энэ үе шатанд хамаарна.

1А. Зорилгоо тодорхойлж, төслийн баг бүрдүүлэх

Байгаль хамгааллын төлөвлөлтийн

зорилгыг тодорхойлох

Байгаль хамгааллын төлөвлөлтийн үйл явцын аль ч үе шатыг нэмэлт мэдээллээр баяжуулж болох бөгөөд тухай бүрдээ төлөвлөлтийн зорилгоо эргэн харж, түүнийг дэмжих аливаа шийдвэр болон шийдвэр гаргагчийг тодорхойлон оруулах нь зүйтэй. Байгууллагын эрхэм зорилго болон өнөөгийн тэргүүлэх чиглэлийг эргэн харах нь, өмнө нь гаргасан шийдвэр, шийдвэр гаргагчийн хүлээж буй үр дүн, хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх таамаглалыг тодруулахад тустай. Бусад талуудтай хамтран ажиллаж байгаа тохиолдолд тус тусын үүрэг, даалгавар, тэргүүлэх чиглэлүүдээ харьцуулан үзэж, талуудын хэрэгцээ шаардлага, зорьж буй үр дүн нь харилцан нийцтэй байгаа эсэхад анхаарч, зөрчил үүсэж болзошгүй хэсгүүдийг анхнаасаа тодорхойлох хэрэгтэй. Мөн санхүүжүүлэгч талтай хамтран ажиллахаар төлөвлөж байгаа бол Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг үндсэн арга замаа болгон ашиглахыг санал болгож болно. Түүнчлэн хэрэгжиж буй болон ижил төстэй төслүүдийн өмнөх туршлагаас санаа авч, суралцах нь зүйтэй. Ингэж нягтлах нь энэ үе шатанд хир их хүчин чармайлт зарцуулах шаардлагатай, ямар алхам нь бусдаас харьцангуй чухал болохыг тодорхойлоход туслах болно (тухайлбал, байгаль хамгааллын үнэт зүйлс болон зорилгоо тодорхойлсон, аюул, дарамтын үнэлгээ хийгдсэн байгаа бол тэдгээрийг нягталж үзээд, нөхцөл

байдлын дүн шинжилгээ болон стратегиэ боловсруулах боломжтой).

Төслийн баг

Аливаа төслийг баг болон ажиллаж буй хэсэг хүмүүс боловсруулан, хэрэгжүүлдэг. Багийн гишүүдэд ихэвчлэн тухайн байгууллагын ажилтнууд болон бусад гол хамтрагч талууд орно. Багийн ахлагч нь төслийн ерөнхий зохицуулалтыг хариуцан, багийн ажлыг чиглүүлэх үүрэгтэй. Зарим байгууллагад өндөр түвшний төслийн санхүүжүүлэгч эсвэл төслийн багийн ажлаа тайлагнадаг удирдагчтай байдаг. Багийн бүрэлдэхүүн, гишүүн тус бүрийн үүрэг хариуцлага тодорхой байх ёстой. Гэхдээ багийн гишүүдийн ур чадвар, туршлагыг анхааран үзэж, төслийг сайн хэрэгжүүлэхийн тулд дутагдаж буй орон зайлт тодорхойлох нь гол асуудал юм. Төслийн явцад багийн бүрэлдэхүүн өөрчлөгдж болно. Төслийн хэрэгжилтэд хэн дэмжлэг үзүүлэхийг мэдэж байгаа бол тэднийг анхнаас нь оролцуулах нь зүйтэй. Төслийн багаас гадна багийн гишүүдэд зөвлөн, төслийн үйл ажиллагааг дэмжиж чадах нэг буюу хэд хэдэн зөвлөхийг сонгох хэрэгтэй. Оролцогч талуудын үнэлгээг (1-р алхам) хийсний дараа төслийн багийн бүрэлдэхүүнийг эргэн харж өмнө нь тодорхойлсон оролцогч талуудаас төслийн багийн бүрэлдэхүүнд оролцох шаардлагатай төлөөлөл байгаа эсэхийг дахин нягтална. Энэ нь шаардлагатай тохиолдолд нэмэлт гишүүн оролцуулах боломжтой байдлаар багийн бүрэлдэхүүнийг уян хатан нээлттэй байлгах хэрэгтэй гэсэн үг юм.

ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Зорилго, шийдвэр гаргагчид тодорхой болж, төлөвлөлтийн ажлыг дэмжихэд шаардлагатай шийдвэрүүд гарсан байна
- ◆ Төслийн багийн ахлагч, гол гишүүд болон зөвлөх гишүүдийн төлөөлөл бүхий баг эхний байдлаар бүрдсэн байна
- ◆ Багийн гишүүдийн үр чадварыг тодорхойлж ажлын явцад үүсэж болзошгүй, шаардлагатаай хоосон орон зайд, дутагдлыг олж илрүүлсэн байна
- ◆ Гишүүдийн үүрэг, хариуцлага тодорхой болж томилогдсон байна

1B. Хамрах хүрээ, Алсын хараа, байгаль хамгааллын үнэт зүйлсийг тодорхойлох

Хамрах хүрээ

Хэрэгжүүлэх стратеги болон үйл ажиллагааг тухайллан бодож эхлэхийн өмнө хүрээээр зорьж буй үр дүнгээ өргөн цар хүрээгээр харж ойлгосон байх нь төлөвлөлтийн ажлын үндэс суурь нь болж өгнө. Төслийн хамрах хүрээ нь төслийн нөлөө үзүүлэхээр зорьж буй цар хүрээг тодорхойлох хэдий ч, тухайн хамрах хүрээнд явагдаж буй үйл ажиллагаагаар хязгаарлагдах шаардлагагүй. Хамрах хүрээг дараах 3 байдлаар авч үзнэ:

- **Газар нутгийн хамрах хүрээ нь** газарзүйн байршилд голлон төвлөрөх ба экологийн бүс нутаг, чухал ач холбогдолтой газрууд эсвэл тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, үр дүнтэй удирдан чиглүүлэх үйл ажиллагаа хамрагдана. Газар нутгийн хамрах хүрээнд экосистемийн төрөл ба функц, үйл ажиллагаа, аюул, дарамтын ижил төстэй байдал болон нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, газарзүйн тодорхой байршил, засаг захиргааны болон менежментийн нэгжийн бүтэц зэргийг харгалzan авч үздэг. Тухайлбал, өөр хоорондоо ялгаатай экосистем ба биологийн олон янз байдал бүхий байгалийн цогцолборт газар нь энэ төрлийн хамрах хүрээ юм.
- **Байгаль хамгааллын үнэт зүйлсийн хамрах хүрээ** нь тодорхой нэг биологийн төрөл зүйл болон экосистемийг хамгаалах зорилготой. Төрөл зүйлийн хамрах хүрээ нь тухайн зүйлийн амьдрах орчныг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хамарч болно. Байгаль хамгааллын үнэт зүйлсийн хамрах хүрээний жишээг дурдвал, дэлхий даяар олон төрлийн ландшафтад амьдарч буй зэрлэг барыг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх дэлхийн хэмжээний

хөтөлбөрийг нэрлэж болно. Экосистемийн хамрах хүрээ гэдэгт Ази тив эсвэл дэлхийн дээрх тал хээрийн экосистемд ургадаг мангро модыг хамгаалах төслийн жишээ байна.

- **Сэдэвчилсэн хамрах хүрээ** гэдэгт бололцоот нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хамруулна. Тухайлбал, Европын холбооны улсууд руу хууль бусаар импортлогдож буй гуалин модны худалдааг багасгах зорилготой хууль бус мод бэлтгэлийн төсөл эсвэл зам тээвэр, барилга орон сууц, хоол хүнс, эрчим хүчний үйлдвэрлэлээс ялгарч буй нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулахад чиглэсэн уур амьсгалын үндэсний хөтөлбөр зэргийг жишээ татаж болно.

Хамрах хүрээг эдгээрийн алинаар тодорхойлсоноос үл хамааран, хүсэж буй үр нөлөөг гаргахын тулд тохирх хамрах хүрээг тодорхойлох шаардлагатай болдог (тухайлбал, нийт тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хувь нэмэр оруулдаг хэд хэдэн тусгай хамгаалалттай газарт зэрэг ажиллах шаардлагатай болох зэрэг...). Түүнчлэн, хэдий хугацаанд, хир их үр дүнд хүрч болох тухай цаг хугацааны хэмжигдэхүүнийг харгалzan үзэх нь зүйтэй. Ихэнх тохиолдолд нэг эсвэл таван жил хүртэл хугацаатай хэрэгждэг төслүүд нь экосистем болон төрөл зүйлийн амьдрах чадварыг сайжруулахад чиглэсэн дорвитой өөрчлөлт, үр дүнд хүрч чаддаггүй ч, хүний зан үйл, хандлагыг дээшүүлэн, бодлогын түвшинд өөрчлөлт хийх замаар экосистем болон төрөл зүйлийг хамгаалахад зерэг нөлөө үзүүлдэг.

Тодорхой газарзүйн байршил дахь үл мөр, нөлөөнд чиглэсэн төслүүдийн хувьд, хамгааллын менежмент хэрэгжүүлэх нэгжүүд болон үлс төр, засаг захиргааны хил хязгаарыг харуулсан орон зайн зураг боловсруулах нь тустай байдаг. Ингэсэнээр төслийн зорилтот газарт харгалzan үзэх шаардлагатай хамтрагч талууд, байгаль хамгааллын үнэт зүйлс, аюул дарамтыг нэмж олж илрүүлж болох юм.

Алсын хараа

Хамрах хүрээнээс гадна, ойлгомжтой, тодорхой бөгөөд хүртээмжтэй алсын хараа буюу төсөл хэрэгжүүлсэнээр гарах эцсийн үр дүнг тодорхойлох шаардлагатай. Алсын хараа нь харьцаангуй ерөнхий, товч тодорхой байх гэсэн шалгууруудыг хангасан байна (эдгээр шалгуурын тодорхойлолтыг Хавсралт 2-оос үзнэ үү) Төслийн алсын хараа нь төслийн багийн бүрэлдэхүүнд орсон бүх байгууллагын эрхэм зорилгод нийцэж байх ёстай.

Онолын үүднээс авч үзвэл ийм төрлийн төсөл хамрах хүрээнд нь багтаж буй бүх экосистемийн хамгааллыг хангахуйц байх ёстой. Тодорхой газар нутагт чиглэн хэрэгжиж буй төслүүдийн дийлэнх нь, маш сайн үндэслэлтэйгээр тодорхойлогдсон 8 буюу түүнээс цөөн тооны байгаль хамгааллын үнэт зүйлстэй байдаг. Өргөн цар хүрээг хамран хэрэгжиж буй төслүүдийн хувьд хамгаалах үнэт зүйл нэмэх эсвэл төрлийн хүрээг тэлэх шаардлагатай байж

1.УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ ХАМРАХ ХҮРЭЭ



Төслийн хамрах хүрээг тодорхойлохдоо, тухайн төсөл нь биологийн олон янз байдлын хамгаалалд чиглэж буй эсэх, уур амьсгалын өөрчлөлт нь төслийн байгаль хамгааллын үнэт зүйлсэд хэрхэн нөлөөлж, эсвэл экосистемийг хамгаалж нөхөн сэргээх замаар хүн төрөлхтөнд тулгамдаад байгаа уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилготой (“байгальд түшиглэсэн дасан зохицууhy” г.м) эсэхийг харгалzan үзэх хэрэгтэй.

Энэ нь төслийн газарзүйн хамрах хүрээг тодорхойлохдоо нөлөөлөх магадлалтай. Хамрах хүрээг тодорхойлохдоо өнөөгийн байдал төдийгүй ирээдүйд учирч болзошгүй уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тооцож үзэх хэрэгтэй. Хамгаалахаар төлөөлж буй экосистем эсвэл биологийн төрөл зүйлийн хамрах хүрээ (өргөрөг эсвэл өндөршил) шилжих, эсвэл экосистем доторх зүйлийн тархац өөрчлөгдхөг магадлалтай эсэхийг тооцож, хэрэв магадлал байгаа бол төслийн хамрах хүрээг тэлэх шаардлагатай болно.

Ямар ч тохиолдолд хамгийн боломжит, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, мэдээлэлд үндэслэн төслийн хамрах хүрээг тодорхойлох нь зүйтэй боловч уур амьсгалын болзошгүй нөлөөг урьдчилан таамаглахад амаргүй байдаг. Иймд явцын хяналт мониторинг нь урьдчилсан таамгуудыг шалган, хамрах хүрээгээ өөрчлөх эсэхийг тогтооход чухал нөлөөтэй.

Байгаль хамгааллын үнэт зүйлс

Төслүүд тодорхой, хязгаарлагдмал тооны хамгаалах үнэт зүйлс сонгох нь зүйтэй (үүнийг мөн Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдал гэж хэлдэг). Эдгээр байгаль хамгааллын үнэт зүйлс нь тодорхой ойлгомжтой, төслийн тавьсан зорилгыг төлөөлөн өөртөө агуулсан, төслийн үйл ажиллагааны үр дунд хамгаалагдах боломжтой бодитоор оршин байгаа зүйлс байна.

Хамгаалах үнэт зүйлс нь зорилго тавих, түүнд хүрэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг сонгох, мөн тэдгээрийн үр дүнг хэмжих үндэс суурийг бүрдүүлдэг. Байгаль хамгааллын үнэт зүйлсийн онцлог нь төслийн төрөл болон хамрах хүрээнээс шалтгаалан харилцан адилгүй байдаг.

Газарт нутагт чиглэн хэрэгжиж буй төслүүдийн хувьд байгаль хамгааллын үнэт зүйлс нь

экологийн систем, амьдрах орчин эсвэл төслийн хамрах хүрээн дэх биологийн олон янз байдлыг бүрэн төлөөлж чадахуйц биологийн төрөл зүйлүүдийн нэгдэл байж болно.

болно (жишээлбэл, нэг зүйл шувууг хамгаалах зорилтын оронд төрөл тус бүрээс хамгаалах гэх зэрэг зорилт дэвшүүлж болно). Түүнчлэн тухайн экосистемийг хамгийн сайн төлөөлж чадах өөрмөц нэг зүйл (бар) эсвэл тухайлсан нэг экосистемийг (мангро модон ой г.м) хамгаалах гэсэн тодорхой ганцхан үнэт зүйлтэй ч байж болно.

- **Сэдэвчилсэн хамрах хүрээ бүхий төслүүд нь байгаль хамгааллын үнэт зүйлстэй холбоотой аюул дарамт юмуу экосистемийн үйлчилгээ зэрэг тодорхой нэг хүчин зүйлд илүү нарийвчлан чиглэсэн байдаг. Төслийн багийн гишүүд төсөлд хамаарлтай экосистемийн аль нэг онцлог шинж чанарыг эсвэл бүр эсрэгээр “биологийн олон янз байдал”, “байгалийн нөөц” гэх мэт илүү ерөнхий зүйлсийг байгаль хамгааллын үнэт зүйлс болгон тодорхойлж болно.**

Шаардлагатай гэж үзвэл, байгаль хамгааллын үнэт зүйлийн өнөөгийн нөхцөл, газарзүйн байршлын цар

хүрээг зураглаж үзэх нь зүйтэй. Ерөнхийдөө, байгаль хамгааллын үнэт зүйлсийн сонголтыг хийхэд шинжээчдийг оролцуулан нарийвчлал бүхий орон зайн анализ хийх шаардлагатай. Хамгаалах үнэт зүйлийн түүхэн болон ирээдүйн цар хүрээ, далайцыг зураглахын зэрэгцээ үнэт зүйлсэд тулгамдаж буй аюул дарамт тус бүрийг өөр хоорондоо адилгүй нөхцөл байдлын хувилбаруудаар авч үзвэл тустай (1С алхмын хэсэгт жишээгээр тайлбарлав). Мөн өргөн цар хүрээ бүхий байгаль хамгааллын үнэт зүйл сонгосон бол (тодорхой экосистемийн хэмжээнд тархсан шувуудыг цогцоор нь хамгаалах г.м.) орон зайн хувьд ойлгомжтой байдлаар дэд үнэт зүйлс болгон хувааж болох юм (тухайлбал, шувуудын төрөл зүйлийн тодорхой нэг популяц эсвэл үргжлийн, нүүдлийн, үргжлийн бус үеийн г.м. амьдралын мөчлөгийн тодорхой нэг үе шатыг хамгаалах зэрэг).

Байгаль хамгааллын үнэт зүйл тус бүрийн өнөөгийн төлөв байдал, нөхцлийг тодорхойлохдоо юуны өмнө үнэт зүйл тус бүрийн амьдрах чадварын үнэлгээг гарын дор бэлэн

ашиглагдах боломжтой мэдээлэл, нотолгоог ашиглан хийх хэрэгтэй. Илүү нарийвчилсан судалгаа хийх тохиолдолд чухал хүчин зүйлсийг (биологийн, экологийн шинж чанарууд) хамгаалах үнэт зүйл тус бүрээр, шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлох төдийгүй шалгуур үзүүлэлт тус бүрийг боломжит өөрчлөлтийн хязгаарын хүрээнд тооцож үзсэний дараа тэрхүү өөрчлөлтийн хязгаар доторхи хувьсах хэмжигдэхүүний хүрээнд (суурь утга болон чиг хандлага гэх мэт) өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно. Энэ нь байгаль хамгааллын үнэт зүйлүүд дээр хэрэгжүүлэх хамгааллын зорилтоо сайтар ойлгомжтой боловсруулж хяналт мониторинг хийх, гол аюул, дарамтыг ойлгож мэдэх үндсэн суурь мэдээлэл болдог. Гэхдээ зарим тохиолдолд хамгаалах үнэт зүйлсийн амьдрах чадварын талаар Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын нэлэн хожуу үе шатанд буюу ялангуяа нарийн мэргэжлийн мэргэжилтнүүдийн санал дүгнэлт хэрэгтэй эсвэл үнэт зүйлсийн сонголт, үнэлгээг сайжруулахаар ажиллаж байгаа үед анхааран ажилласан нь илүү дээр байж болно.

2. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ҮНЭТ ЗҮЙЛС



Арга зүйн дагуу төлөвлөлт хийх цаашдын бүхий л үйл явцад уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй нөлөөг тооцоолж үзэх нь төслийн зорилтот экосистем, амьдрах орчин, төрөл зүйлүүд нь төсөөлж буй цаг хугацаанд төслийн зорилтот газарзүйн байршилийн хүрээнд байсаар байх эсэхийг таамаглах боломж олгодог. Түүнчлэн байгаль хамгааллын үнэт зүйл тус бүрийн амьдрах чадварт уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж болох, хамгаалах үнэт зүйлийн тогтвортой байдлыг хадгалах, сайжруулахад чиглэн төлөвлөж буй хамгааллын үйл ажиллагаа нь тухайн болзошгүй өөрчлөлтийн нөлөөн дор ч үр дүнтэй байх эсэхийг олж мэдэх болно. Үнэт зүйлсэд учирч болзошгүй уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг үнэлсэний дараа хамгаалах зүйлс болон зорилтуудаа дахин нягтлахыг зөвлөж байна.



Хүний сайн сайхны төлөөх зорилтууд

Байгаль хамгааллын үйл ажиллагаа нь эцсийн дүндээ хүний амьдралд хэрхэн нөлөөлөх талаар харуулах нь чухал байдаг бөгөөд зарим төслийн хувьд энэ нь байгаль хамгааллын асуудалтайгаа эн тэнцэхүйц ач холбогдолтой байх нь ч бий. Энэ тохиолдолд, хүний сайн сайхны талаарх зорилт⁴ нэмж болно. Байгаль хамгаалах төслийн хувьд, хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг хамгаалах үнэт зүйлийн нөхцөл, түүнд хамаарах экосистемийн үйлчилгээтэй холбоотойгоор хүний ахуй амьдралд нөлөө

үзүүлж буй тодорхой бүрэлдэхүүн хэсэгт төвлөрүүлж болно. Хүний амьжиргаа, эрүүл мэнд, нийгмийн харилцаа, аюулгүй байдал, засаглал, ялангуяа нийгмийн хөгжлийн зорилтуудтай хамааралтай элементүүд нь хүний сайн сайхан байдалтай холбогдож болно (Шигтгээ тайлбар 3). Хамгаалах үнэт зүйлсийг сонгох, эсвэл нөхцөл байдлын суурь үнэлгээг хийх явцын алинд нь ч энэ төрлийн зорилтыг Тодорхойлох алхмын нэг хэсэг болгон нэмж оруулах боломжтой (Байгаль хамгаалал ба хүний сайн сайхан байдлын зорилтуудын хоорондын харилцан хамаарлын ерөнхий жишээг Зураг.3-т харуулав)




ШИГТГЭЭ ТАЙЛБАР 3: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ АШИГЛАН ХҮНИЙ САЙН САЙХНЫ ТӨЛӨӨХ ЗОРИЛТ ДЭВШҮҮЛЭХ, УЯЛДАА ХОЛБООГ ТОДОРХОЙЛОХ

Тогтвортой Хөгжлийн Зорилт TX3) нь хүн төрөлхтөн, хүрээлэн буй орчны ирээдүйн тогтвортой байдлыг хангах, дэлхий дахинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын дэмжин баталсан цогц зорилтууд юм. TX3 нь хүний сайн сайхан байдлыг сайжруулах, байгаль орчны доройтлыг бууруулах, эдгээрийн хоорондын тэнцвэрт байдлыг хангах нөхцөл бололцоог бий болгох зэрэг 17 зорилтоос бүрддэг. Дэлхий нийтийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн харилцан уялдаатай зорилтууд бүхий баримт бичиг тул байгаль хамгааллын төслүүдэд хүний сайн сайхан байдал, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилтуудын талаарх нэгдмэл, гунзгий ойлголтыг өгч чадна. Хүний хэрэгцээ, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн байгаль хамгааллын төсөл хэрэгжүүлж байгаа бол хүний сайн сайхны төлөөх болон байгаль орчны зорилтуудыг сонгоходоо TX3-ийн дэвшүүлсэн зорилтуудыг судлан тэдгээрийн биелэлтэд нь төслийн зүгээс оруулах хувь нэмрийг тодорхойлох, ойлголттой болох боломжтой.

⁴ Өмнөх зүйтэй тайлбарыг үзнэ үү.

Зураг 3.

Төслийн алсын хараа, хамрах хүрээ, хамгаалах үнэт зүйлсийг тоймлон харуулсан Нөхцөл байдлын дүн шинжилгээний ерөнхий диаграмм



ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ♦ Төслийн хамрах хүрээг тодорхойлж, боломжтой тохиолдолд түүний газарзүйн байршлыг харуулсан газрын зураг хийсэн байна.
- ♦ Төслийн алсын харааг тайлбарласан тодорхойлолт бий болсон байна.
- ♦ Сонгогдсон хамгаалах үнэт зүйлс, тэдгээрийн үндэслэл бүхий товч тайлбар, боломжтой бол хамгаалах үнэт зүйл тус бүрийн ерөнхий тодорхойлолт, газарзүйн байршлыг харуулсан зургийг гаргасан байна.
- ♦ Хамгаалах үнэт зүйл тус бүрийн амьдрах чадварын үнэлгээ буюу өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсэн байна.
- ♦ Хэрэв хамааралтай бол хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг дэвшүүлж, холбогдох экосистемийн тодорхойлолт, зорилт дэвшүүлэх болсон үндэслэл, шалтгааны талаар товч тайлбар бичсэн байна.


1С. Ноцтой аюул, дарамтыг тодорхойлох

Хамгаалах үнэт зүйлсээ тодорхойлсоны дараа ашиглах боломжтой бэлэн байгаа нотолгоонд тулгуурлан үнэт зүйлсэд шууд нөлөө үзүүлж буй аюул, дарамт (ижэн тохиолдолд дарамт гэж нэрлэдэг)⁵ болон тэдгээрийг үүсгэж буй хүчин зүйлсийг (аюул, дарамтын ард буй гол нөлөөлөгч хүчин зүйл буюу тоглогч) олж тодорхойлно. Энэ нь үндсэндээ хамгаалах үнэт зүйлсэд шууд нөлөөлөн дорийтуулж буй хүний үйл ажиллагаа байдаг. Тухайлбал, тогтвортой бус хэлбэрээр ажиллаж буй загасны аж ахуй, ан агнуур, газрын тос олборлолт, зам барилга, аж үйлдвэрийн хог хаягдал, этгээд болон харь зүйлийг нутагшуулах зэргийг дурьдаж болно. Мөн хүний үйл ажиллагааны уршгаар өөрчлөгдсөн байгалийн үзэгдлүүд болох хүчтэй шуурга байн байн болох,

дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас далай тэнгис, гол нуурын усны үүршилт нэмэгдэх зэрэг үзэгдлүүдийг энэ төрлийн дарамтад хамааруулах бөгөөд ховор тохиолдог ч хүний үйл ажиллагааны улмаас нөлөөллийн хүч нь нэмэгддэг байгалийн үзэгдлүүд бас хамгаалах үнэт зүйлсэд шууд нөлөөлөл үзүүлдэг. Жишээлбэл, цунами шуургын улмаас Азийн хирсний сүүлчийн популяцији устах аюулд өртөж болзошгүй юм. Илүү дэлгэрэнгүй жишээ, мэдээллийг Байгаль Хамгааллын Үйл Ажиллагааны Холбоо (CMP: Conservation Measures Partnership)-ноос гаргасан Байгаль хамгааллын аюул дарамтын ангилал-аас үзэж болно. Боломжтой бол, аюул дарамтын нөлөө, ул мөрийг орон зайн зурагалаар тооцоолж үзэх нь голлоо аюул, дарамт болон тэдгээрийн үүсгэж хүчин зүйлийг олж тодорхойлоход тусална (Зураг 4. Шимпанзе мич хамгаалах төслийн хялбаршуулсан жишээ

Зураг 4.

Шимпанзе мич хамгаалал, түүнд учирч буй аюул дарамтыг харуулсан хялбаршуулсан орон зайн зураглал



Хамгаалахаар зорьж буй Шимпанзе мичний амьдрах орчин

Газар тариалангийн зориулалтаар газар нутгийг хувиргах аюул, дарамт буюу амьдрах орчны алдагдал

Эх сурвалж: *Лилиан Пинтеа, Жэйн Гүүдолл хүрээлэн, “Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартад нийцүүлсэн уян хатан хэрэглээ”*

⁵ Эрхлэн явуулж буй үйл ажиллагаа эсвэл ажил маргажил нь “аюул, дарамт” гэж тодорхойлогдож болох фермийн эзэд болон мод бэлтгэгчид зэрэг зарим оролцогч талуудын хувьд “аюул, дарамт” гэх нэр томъёог шууд ойлгож хүлээн авахад хундрэлтий байх тохиолдол бий. Иймд, “дарамт” гэх ижил үтгатай үгийг хэрэглэх нь илүү тохиомжтой байж магадгүй. Мөн “тогтвортой бус” эсвэл “хүуль бус” гэх тэмдэг нэр ашиглах нь аюул, дарамт гэх ойлголтын үндсэн шинж чанарыг ойлгомжтой тайлбарлахад дөхөм байж болох юм. (жишээ нь, тогтвортой бус фермийн аж ахуй г.м.)

Зөвшөөрөлгүй загасчид, хулгайн анчид болон хууль бус үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, компани зэрэг гол үүсгэгч, хариуцагчийг олж тогтоох нь аюул, дарамтыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Тухайн аюул, дарамт нь нэг эсвэл ижил төстэй хэд хэдэн хариуцагч этгээдийн үйл ажиллагаанаас үүсэж буй эсэхийг мэдсэний дараа төслийн багийн гишүүдийн зүгээс учруулж буй аюул дарамтыг нь бүлэглэх буюу салган ангилж болно. Жишээлбэл, “хулгайн ан” гэх аюул дарамтыг “хэсэг бүлгээр үйлдэж буй зохион байгуулалттай хулгайн ан” эсвэл “тосгоны оршин суугчдын хийж буй хулгайн ан” гэх байдлаар ангилж болох юм. Аюул дарамтыг үүсгэж буй хариуцагч этгээдийг ил болгож тогтоох нь Оролцогч талуудын үнэлгээг боловсруулах, төлөвлөлтийн стратегиэ боловсруулахад тустай.

Төслийн суурь үнэлгээний нэг хэсэг болох аюул дарамтыг тодорхойлоодо хамгаалах үнэт зүйлсэд шууд нөлөө үзүүлж буй аюул дарамтыг нэн тэргүүнд олж тогтоосноор түүнд чиглэсэн оновчтой хамгааллын арга хэмжээ авч

хэрэгжүүлэхэд анхааран ажиллах боломжтой болох юм. Ялангуяа, онцгой анхаарал хандуулан ажиллах ёстой хамгийн ноцтой аюул, дарамтыг олж тогтоохыг хичээх хэрэгтэй. Аюул, дарамтыг үнэлж тооцдог хэд хэдэн аргыг үүнд ашиглаж болох ба тэдгээрийн тусламжтайгаар аюул дарамтыг эрэмбэлж болно. Энэ төрлийн ихэнх арга зүй нь аюул, дарамтын хамрах хүрээ болон хамгаалах үнэт зүйлсэд үзүүлж буй нөлөөллийн хүчийг тооцдог. Уг шалгууруудыг хамтад нь авч үзсэнээр аюул дарамтын нийлбэр үнэлгээг гаргаж ирнэ. Түгээмэл хэрэглэгддэг өөр нэг шалгуур үзүүлэлт бол засаж залруулах боломж болон зайлшгүй/хойшилуулашгүй байдал юм. Мөн аюул дарамтыг эрэмбэлэхэд түгээмэл хэрэглэгддэг бусад төрлийн арга хэрэгслүүд ч бий. Тухайлбал, өөр өөр хамгаалах үнэт зүйлсэд нөлөө үзүүлж буй тодорхой нэг аюул дарамтын үнэмлэхүй жинг үнэлэх, хамгаалах үнэт зүйлд өөр өөр аюул, дарамтаас ирж буй нийлбэр нөлөөг тооцдог стресс-үнэлэх арга, аюул дарамтуудын харилцан үйлчилж буй чанарыг үнэлэх арга зэргийг дурдаж болно.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ ЗАЮУЛ, ДАРАМТ БА ЭМЗЭГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ



Уур амьсгалын өөрчлөлт нь хамгаалах үнэт зүйлийн хувьд шинэ аюул, дарамт үүсгэж болох төдийгүй бусад нийтлэг аюул, дарамттай харилцан нөлөөлөх магадлалтай. Мөн тулгамдаад байгаа дарамт, стрессийг хурцатгаж ч болдог.

Уур амьсгалын болзошгүй сөрөг нөлөөг үнэлэн шинжилдэг эмзэг байдлын үнэлгээ нь өөр нэгэн ашиг тустай арга хэрэгсэл юм. Үнэлгээг нарийвчлан хийх нь төслийн нөхцөл байдлаас хамааран ялгаатай байдаг. Ихэнх нь нилээд ерөнхий байдлаар хийгддэг ч үүнийг эргэлзээтэй байгаа, асуудалтай гэж үзэж буй хамгаалах үнэт зүйлсэд төвлөрөн хийх нь зүйтэй. Энэ үнэлгээг хийхдээ температурын есelt, хур тунадсын өөрчлөлт, шуурга, ган, далай тэнгисийн усны түвшин нэмэгдэх, ус хүчиллэг болох гэх мэт байгалийн онцгой үзэгдлээр илрэч болзошгүй уур амьсгалын өөрчлөлтийн шууд нөлөө, эдгээрээс улбаалан хамгаалах үнэт зүйлсэд үзүүлэх шууд (их хэмжээний гал түймэр гарснаар ган болох эрсдэлт өртөмтгий болох) болон шууд бус нөлөөг (ган ойр ойрхон болсноор хүмүүс үс нөөцлөх далан байгуулахыг эрмэлзэж улмаар цэвэр усны хангамж, холбоост үзүүлэх сөрөг нөлөө үзүүлэх г.м.) үнэлнэ. Цаashiд 1D алхам буюу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхэд эдгээр мэдээллээс нэгтгэн оруулах шаардлага гардаг. Учир нь уур амьсгал хэрхэн өөрчлөгдхөх, хүн төрөлхтөн түүнд ямар хариу үйлдэл үзүүлэх, экосистем болон биологийн төрөл зүйлүүд хэрхэн оршин тогтоноо зэрэг тодорхойгүй асуултууд маш ихээр үүсэх тул ирээдүйд болзошгүй өөрчлөлтийн хүрээ, хязгаарыг ойлгож мэдэхийн тулд уур амьсгалын нөхцөл байдлыг хамгийн баагдаа 2 янзын хувилбараар урьдчилан таамагласан байх нь зүйтэй.

ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ♦ Шууд аюул, дарамтыг тодорхойлон шаардлагатай тохиолдолд, дарамт тус бүрийн хамгаалах үнэт зүйлсийн байршилтай давхцаж буй нөлөө, орон зайн ул мөрийг харуулсан газрын зураг хийсэн байна
- ♦ Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг байдлын үнэлгээг төслийн нөхцөл байдалд тохируулан хийсэн байна
- ♦ Ноцтой аюул дарамтыг олж тодорхойлохын тулд шууд нөлөө үзүүлж буй аюул дарамтуудаа үнэлж эрэмбэлсэн байна

1D. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

Энэ нь төслийн ерөнхий нөхцөл байдал буюу өмнөх үйл явцын туршид тодорхойлсон төслийн хамрах хүрээ, хамгаалах үнэт зүйлс болон шууд аюул дарамт дээр нэмэлт үнэлгээ, дүгнэлт хийх алхам юм. Дээр дурдсан бүх элемент нь нөхцөл байдлын дүн шинжилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд энэ алхмын хүрээнд нийгэм, эдийн засаг, улс төр, институцийн бүтэц, зохион байгуулалт, хамгаалахаар зорьж буй үнэт зүйлсэд нөлөө үзүүлдэг оролцогч талуудын хоорондын харилцан хамаарлыг тодорхойлж, багийн гишүүд төлөвлөлтийн суурь нөхцлийн талаарх нэгдмэл ойлголтод хүрнэ. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь боломжит нотолгоо болон төлөвлөлт хийх болсон суурь асуудал/газрын талаарх нарийн судалгаа бухий нягт, нямбай албан ёсны тойм, эсвэл суурь асуудал, нөхцлийг мэддэг талуудаас авсан мэдээлэлд үндэслэсэн албан бус тодорхойлолт болох эсэх нь төлөвлөлтийн далайц болон ашиглагдаж буй нөөц бололцоноос хамааралтай байдаг. Заримдаа анхааралгүй орхигддог энэ алхам нь угтаа төлөвлөлтийн үйл явцад хамгийн чухал ач холбогдолтой хэсэг юм. Нөхцөл байдлаа сайтар ойлгож мэдсэнээр хамгааллын зорилго, зорилт, арга хэмжээг загварчлан боловсруулах бололцоотой болдог.

Уг дэд алхмын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээг дуусгахад шаардлагатай нотолгоонуудаа дахин нэг хянаж үзэж, шууд аюул дарамтыг үүсгэж буй эсвэл амьдрах орчныг доройтуулж буй-өөрөөр хэлбэл хамгаалах үнэт зүйлд нөлөө үзүүлж буй гол хүчин зүйлийг тодорхойлох хэрэгтэй. Мөн шууд бус аюул дарамт (ундсэн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл ч гэгддэг) болон боловсруулж ба таатай нөхцлийн талаар ч бас оруулах нь зүйтэй. Эдгээр хүчин зүйлийг орон нутгийн түвшнээс эхлээд дэлхийн хэмжээнд бодож тооцоолсон байх ёстой. Нөхцөл байдлын дүн шинжилгээг хэрэглэх боломжтой байдлаар хийхийн тулд гол хүчин зүйлийн ард байгаа хариуцагч тал буюу хүмүүсийг стратегийн зорилгодоо нийцсэн, ойлгомжтой байдлаар тодорхойлох шаардлагатай болно.

Оролцогч талууд гэдэг нь төслийн зорилтот газар нутаг дахь байгалийн нөөцед нөлөө үзүүлж буй эсвэл төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үр шим хүртэх болон алдагдах хүлээх хувь хүн, бүлэг нэгдэл ба байгууллагуудыг хэлдэг. Оролцогч талуудын талаар сайн ойлголтой байх нь нөхцөл байдлын дүн шинжилгээнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

Оролцогч талуудын үнэлгээ хийсэнээр гол оролцогч талууд, тэдний гүйцэтгэж буй үүрэг, гол ашиг сонирхол, нөлөөллийн түвшин болон оролцооны боломжийг ангилан ялгаж, ойлгомжтой тодорхой болгоход тусалдаг.

Эрх мэдэл, хүчтэй нөлөө бүхий оролцогчдын аль алиныг нь анхаарч үзэх нь чухал бөгөөд төслийн хэрэгжилтийн улмаас таагүй үр дагавартай тулгарч болзошгүй болон таатай нөхцөл, үр дүн хүртэж болох талуудыг мөн төлөвлөлтөд хамруулан оруулах нь зүйтэй. Ялангуяа, төслийн үйл ажиллагаа нь шийдвэр гаргах түвшний янз бүрийн оролцогчдийн төлөөлөл, тэдний оролцоонд хэрхэн нөлөөлөх, төслийн хэрэгжилтийн эцсийн үр дүн нь тэдний амьдрал, эрүүл мэндэд ямар үр дагавар авчрах талаар багийн гишүүд сайтар анхаарч бодолцож үзэх хэрэгтэй.


Оролцогч талуудын талаар дахин хянаж үзэхдээ аль нь цаашид төслийн стратегийн хамтрагч болж болохоор байгаад анхааралт хандуулаарай (1A алхам). Түүнчлэн төлөвлөлт хийж буй тал болон төслийн багийн гишүүд ч төслийн хэрэгжилтэд оролцоо тул өөрсдийгөө мөн оролцогч талуудын үнэлгээнд оруулах нь зүйтэй.

Мэдлэг, хандлагад нь нөлөөлөхийг хүсэж буй зорилтот бүлгийг сонгохдоо оролцогч талуудын үнэлгээг ашиглана. Бодлого төлөвлөлт болон компани, аж ахуйн нэгжүүдийн дадал практик, эсвэл хэрэглэгчийн сонголт гээд алийг нь ч зорилт болгон авсан бай өдгээр нь эцэстээ бүгд л хандлага, дадал зуршилд нөлөөлөх үйл ажиллагааг шаардана. Үйл явдлын гол тоглогчид шууд хандах боломж тэр бүр олддоггүй бөгөөд ялангуяа тэд хууль бүс үйл ажиллагаанд мэдсээр байж зориудаар оролцож байгаа нөхцөлд илүү төвөгтэй байж болно. Ийм тохиолдолд, тухайн тоглогчид нөлөөлж чадахуйц бусад талууд болон эвсэл холбоодтой хамтран ажиллах хэрэгтэй. Оролцогч талуудын үнэлгээ нь цаашдаа стратеги боловсруулах үйл явцыг эхлүүлэх чухал чиглүүлэгч болдог (2A алхам).

Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлсон аюул, дарамт, боломж болон гол тоглогчдыг нэгтгэн дүгнэх нэг арга нь нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм хийх явдал юм. Үүнийг мөн төслийн үзэл баримтлалын загвар гэдэг. Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм нь дүн шинжилгээгээр гарч ирсэн янз бүрийн хүчин зүйлийн хоорондын харилцан хамаарлыг товч дүрслэн харуулдаг (Зураг 5. Ерөнхий загвар, Зураг 6. Бодит амьдрал дээр тодорхой газарт хэрэгжиж буй төслийн жишээгээр тус тус харуулав). Сайтар боловсруулсан нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм нь төсөл хэрэгжих газар нутаг болон тухайн агуулгын хүрээн дэх аюул дарамтыг үүсгэгч шалтгаан, үр дагаврын харилцан хамаарлыг харуулдаг. Үүнд хамгийн чухал бөгөөд нарийн учир шалтгааныг аль болох энгийн байдлаар оруулах нь зүйтэй. Томоохон төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ нь цар хүрээ багатай төсөлтэй харьцуулахад нилээд бүдүүн тойм байдлаар хийгдэх шаардлагатай болдог.


Зураг 5.

Төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм



Зураг 6.

Голын сав газарт хэрэгжиж буй төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммын жишээ



Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм нь төслийн суурь нөхцөл байдлын талаарх багийн гишүүдийн ойлголтыг төлөөлж чадаж байгаа эсэхийг бататгахын тулд үүнийг багийн гишүүдтэй хамтран аль болох олон нотолгоонд тулгуурлан хийж гүйцэтгэх нь сайн. Мөн нөхцөл байдлыг харуулсан газрын зураг хийх хэрэгтэй. Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм болон орон зайн зураглал нь, нэгдмэл ойлголт өгч байгаа эсэхийг магадлах үүднээс багийн гишүүд болон бусад талуудын оролцоотойгоор газар дээр нь очиж баталгаажуулах нь маш үр дүнтэй байдаг.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммыг хийх явцад янз бүрийн бүрэлдэхүүн хэсэг, элементүүдийн хооронд харилцан хамаарал үнэхээр байгаа эсэхийг батлах нотолгоо хэр их байгааг анхаарч, тэмдэглэл хөтөлнө. Тэрхүү харилцан хамаарлыг батлах нотолгоо нь: хэвлэн нийтлэгдсэн шинжлэх ухааны бүтээл, нийтлэл, судлаачдаас цүглуулсан мэдээ баримт, мэргэжилтний үзэл бодол, эсвэл талуудын туршлагад үндэслэсэн таамаг төсөөлөл байж болно. Мөн тэрхүү таамаглалууд нь баталгаатай байдлынхаа хувьд “тодорхойгүй” гэдгээс эхлээд “итгэлтэй” гэх зэрэг баталгаатай байдлын хувьд өөр өөрөөр тодорхойлогдсон байж болно. Аль хэдийн ойлгож мэдсэн зүйл дээрээ хэт төвлөрөх хэрэггүй. Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммыг хийж газар дээр нь баталгаажуулах явцад мэдлэгийн зөрүү, зөрчилдөөнтэй нотолгоо, аль эсвэл өмнө нь мэдээгүй

өнгөрсөн зүйлс байгаа эсэхийг анхаарч тэмдэглэл хийхийн зэрэгцээ цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай зүйлсийг олж тогтооно. Эдгээр хэрэгцээт мэдээллийг олж харсаны дунд эцэстээ тодорхой нэг стратеги эсвэл үйл ажиллагааг үүнд зориулан тусгайлан боловсруулах хэрэгтэй болж болно. Тэрхүү харилцан хамаарал болон түүнийг баталж буй нотолгоонуудыг дэлгэж харуулсанаар стратегиээр эрэмбэлэх, нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм юмуу үр дүнгийн хэлхээ доторх алдаа дутагдлаа олж харахад нь багийн гишүүддэд тустай байх болно (2A алхам).


Төслийн багийн гишүүд нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг оруулсан тохиолдолд хамгаалахаар зорьж буй үнэт зүйлсийн төлөв байдал ба тэдгээрээс хүртэх экосистемийн үйлчилгээ нь хүний сайн сайханд хэрхэн нөхөнөлж байгааг тодорхой харуулж өгөх хэрэгтэй (Зураг 7.-д нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг тусгасан жишээ загвар харуулав). Мөн хамгаалах үнэт зүйлс болон хүний сайн сайхны төлөөх зорилтуудын уялдаа холбоог диаграммаар харуулахдаа аль болох өөрчилж болохуйц, шинэлэг байдаар бодож хийж нь нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммыг янз бүрийн зорилтот талуудад⁶ ойлгуулах, тэд цаашид өөрсдийн болгон авч явахад нь тустай.⁷

6 Байгаль хамгааллын үйл ажиллагааны холбоо CMP-ноос гаргасан “Хүний сайн сайхан болон нийгмийн асуудлуудыг Биологийн олон янз байдлын хамгааллын төслиүүддэд уялдуулан наягтэж нь” (2016)- илүү дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

7 CMP (2016) г харах [Incorporating Social Aspects and Human Well-being in Biodiversity Conservation Projects](#).

Зураг 7.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд хүний сайн сайхны төлөөх зорилт тусгасан жишээ загвар



ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ♦ Шууд бүс аюул дарамт болон боломжийг тодорхойлон дүн шинжилгээ хийсэн байна
- ♦ Оролцогч талууд, тэдгээрийн анхдагч ашиг сонирхлыг тодорхойлон үнэлсэн байна
- ♦ Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммын эхний хувилбарыг хийсэн байх бөгөөд үүнд төслийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйл хоорондын шалтгаан-ба-ур дагаврын гол харилцан хамаарлыг дурслэн өгүүлэх, эсвэл бусад арга хэлбэрээр төлөөлүүлэн тайлбарласан байна.
- ♦ Нөхцөл байдлын дүн шинжилгээг газар дээр нь очиж баталгаажуулан үлмаар дүн шинжилгээний диаграммыг түүнтэй уялдуулан сайжруулан засссан байна.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэ алхмын талаар нэмэлт мэдээлэл: <https://conservationstandards.org/resources/>

Бодит жишээнүүд: <https://conservationstandards.org/case-studies/>



төлөвлөх



ТӨЛӨВЛӨХ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын энэ үе шатанд төслийн зорилго, стратеги, зорилтыг тодорхойлно. Төслийн зорилго, стратеги, зорилт, суурь таамаглал нь төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрдүүлнэ. Үүнээс гадна энэ үе шатанд төслийн гүйцэтгэлд хяналт тавих, мэдээллийн бусад хэрэгцээг хэрхэн шийдвэрлэх, үйл ажиллагаа, мониторингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын болон нөхцөл байдлын бусад хүчин зүйлс хэрхэн нөлөөлөхийг харгалзан үзнэ. Үйл ажиллагаа, мониторингийн болон ажлын төлөвлөгөө нь бүхэлдээ (Үе шат 3-д тайлбарласан болно) үндсэн стратеги төлөвлөгөөг бүрдүүлдэг (Зураг 8).

Зураг 8.

Төлөвлөгөө хоорондын уялдаа холбоо.

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үндсэн төлөвлөгөө. Стратегийн цогц төлөвлөгөө нь төслийн хамрах хүрээ, алсын хараа, хамгааллын үнэт зүйл; төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө зэргийг багтаана.

Үйл ажиллагааны төлөвлөгөө
Тодорхойлсон аюул дарамтыг бууруулах болон нөөц боломжийг ашиглахад чиглэсэн төслийн зорилго, зорилт, стратегийн тайлбар тодорхойлолт

Мониторингийн төлөвлөгөө
Төсөлд хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө. Үүнд мэдээллийн хэрэгцээ, шалгур үзүүлэлт ба арга, орон зайн талбай ба байршил, мэдээлэл цуглуулах хугацаа, үүрэг, хариуцлага багтана

Гүйцэтгэлийн төлөвлөгөө
Шаардлагатай хөрөнгө оруулалт, хүний нөөцийн чадавхи, тэдгээрийн үр чадвар, бусад санхүүгийн бус нөөц боломжид хийсэн дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ, бууруулах арга зам, төслийн үргэлжэх хугацааны тооцоо ба хаалтын стратеги

Ажлын Төлөвлөгөө

Үйл ажиллагаа эсвэл мониторингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх богино хугацааны төлөвлөгөө. Ажлын төлөвлөгөө нь хийгдэх ажлын жагсаалт, даалгавар тус бүрийг хариуцах эзэн, биелүүлэх хугацаа, хэрхэн хийх талаарх жагсаалт. Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө болон бусад нөөцийн мэдээлэл.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын энэ үе шат нь бусдын адил уялдаа бүхий хэд хэдэн алмаас бүрдэнэ. Жишээлбэл, Ye шат 2C явцад Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулдаг ч Ye шат 2A-ийн хүрээнд арга зүйг сонгоходоо тогтвортой байдал, эрсдэл, хаалтын төлөвлөгөөний тухай бодох хэрэгтэй. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь багийн гишүүд, менежерүүдэд тодорхой стратегийг хэрэгжүүлэх эсэх эсвэл төслийг үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлоход тус болно.

2А. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ: ЗОРИЛГО, СТРАТЕГИ, ТААМАГЛАЛ, ЗОРИЛТУУД

Зорилго

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хамгийн чухал эхлэл нь юу хийх, ямар зүйлд тэмүүлж байгаа талаарх тодорхой санааг буулгах явдал юм. Зорилго нь төслийн хамгааллын үнэт зүйлсэд шууд хамаарах бөгөөд урт хугацаанд тэдгээр хамгааллын үнэт зүйлсийн хүсэж буй төлвийг илтгэнэ. Зорилго нь хүрэхийг хүсч буй түйлн үр дүнгийн албан ёсны мэдэгдэл буюу тодорхойлолт юм. Сайн зорилго нь “СМАРТ” буюу тодорхой, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, үр дүнд чиглэсэн, хугацааны хязгаартай гэсэн шаардлагыг хангасан байна (Хавсралт 2, Хайрцаг 4-өөс үзнэ үү).

Төслийн зорилго нь өргөн хүрээний хөтөлбөр эсвэл байгууллагын зорилгод нийцэж, тэдгээрт хувь нэмэр оруулах ёстой. Зарим тохиолдолд төсөл ямар үр дүнд хүрэх ёстойг тухайн байгууллага эсвэл хуульд заасан шаардлагаар тодорхойлсон байж болох бөгөөд эдгээр үүрэг нь үйл хэргийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход нөлөөлнө. Боломжтой бөгөөд шаардлагатай тохиолдолд төслийн баг нь зорилгоо илүү өргөн хүрээнд буюу үндэсний, бус нутгийн эсвэл олон улсын хүчин чармайлттай (жишээлбэл, Тогтвортой Хөгжлийн Зорилт, Биологийн олон янз байдлын Конвенци) нийцүүлэн өргөн хүрээний зорилтуудад ямар хувь нэмэр оруулахыг зааж өгнө.

Хэрэв Ye шат 1B-д амьдрах чадварын үнэлгээ хийсэн бол хамгааллын үнэт зүйлсэд харгалзах гол шинж чанар, хүсэн хүлээж буй үр дүнд хэзээ хүрэх, үнэлгээнд шаардлагатай хэмжигдэхүүнийг мэдэж байгаа тул сайн зорилго тодорхойлоход шаардлагатай бүрэлдэхүүн хэсгийг тогтоож чадна. Зорилго тодорхойлох гэдэг нь дээрх мэдээллийг албан ёсны мэдэгдэл болгон хувиргахад

оршино. Тухайлбал, Зураг 6-д дүрсэлсэн ойн коридорын байгаль хамгааллын үнэт зүйлийн зорилгыг дараах байдлаар “СМАРТ”-аар тодорхойлж болно. Үүнд: “2030 он гэхэд Цагаан голын сав газрыг Лос Гриллостой холбох ойн коридорын өргөн тасалдалгүйгээр дор хаяж 5 км байна”.

Хэрэв төсөл хүний сайн сайхны төлөөх үнэд зүйлд чиглэсэн зорилт тавьсан бол амьдралыг сайжруулахад чиглэсэн зорилгуудыг тодорхойлох шаардлагатай. Ингэхийн тулд төслийн баг нь хүний сайн сайхны төлөөх зорилтод харгалзан, байгаль хамгааллын үнэт зүйлийн төлөв байдал болон тэдгээрээс үзүүлж буй экосистемийн үйлчилгээнээс шууд хамааралтай шинж чанарыг тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл, байгаль хамгаалал хариуцсан баг нь холестрины түвшинг бууруулах нь эрүүл мэндэд сайн ч хүний сайн сайхныг хангах зорилгод тавихгүй, харин биологийн олон янз байдлын хамгааллын зорилтууд нь үр тарианы тоос хүртээх үйлчилгээг сайжруулах тул хүнсний эх үүсвэрийн хүртээмжийг сайжруулах зорилт тавьж болох юм.

ХАЙРЦАГ 4. ЗӨВ ЗОРИЛГО, ЗОРИЛТ ТОДОРХОЙЛОХ

**Зөв зорилго ба зорилт нь дараах СМАРТ(SMaRT)
шалгуурыг хангасан байна:**

Тодорхой – Төсөлд оролцог бүх хүн дэвшүүлж буй зорилго, зорилт нь яг юу гэсэн үтгыг илэрхийлж байгаа талаар ижил түвшний ойлголт авахүйц тодорхой томъёолсон байх.

Хэмжигдэхүйц – Зарим стандарт хэмжигдэхүүнээр тодорхойлогдсон байх (тоо хэмжээ, хувь, эсвэл төлөв байдал).

Хэрэгжихүйц – Төсөл хэрэгжих газрын онцлогт тохирсон, улс төр, нийгэм, санхүүгийн нөхцөл байдалд нийцсэн байх (энэ нь ялангуяа дэвшүүлж буй зорилтод хамаарах ба зорилго нь илүү их хүсэл эрмэлзэлтэй байж болно).

Үр дүнд чиглэсэн – Зорилтот хүрэх түвшин, аюул дарамтын бууралт болон бусад хүлээгдэж буй гол үр дүнгийн өөрчлөлтийг илэрхийлсэн байх.

Цаг хугацаатай – Тодорхой цаг хугацаанд биелэгдэхүйц байх. Ерөнхийдөө зорилгын хувьд 10-20 жил, зорилтоо 1-10 жилийн дотор хүрэхээр тооцож төлөвлөдөг.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДАЛ 4 ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ



Амьдрах чадварыг үнэлэх, зорилго тодорхойлоходо нөхцөл байдлын дүн шинжилгээнд тодорхойлсон уур амьсгалын өөрчлөлтийг харгалzan зорилгодоо хүрэх боломжтой хэвээр байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.

Стратеги

Үүнд хүрэхийг хүсэж байгаагаа тодорхойлсон (зорилго) бол юу хийх ёстойгоо бodoх хэрэгтэй (стратеги/арга зам ба үйл ажиллагаа). Сайн стратеги төлөвлөлт нь хэнд нөлөөлөх, хаана, хэрхэн оролцох эсвэл эс оролцох асуудлыг тодорхойлоход чиглэсэн, үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон зай, цаг хугацааг харгалzan үзсэн байна.

Нөлөөлөх хүчин зүйлийг сонгох (Хөндлөнгөөс оролцох гол цэгүүд)

Стратегийг төлөвлөхдөө нөхцөл байдлын дүн шинжилгээ болон диаграммд илрүүлсэн нөхцөл байдлыг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлүүдийг эрэмбэлэдэг – эдгээрийг хөндлөнгөөс оролцох гол цэг гэнэ. Хөндлөнгөөс оролцох гол цэгийг тодорхойлохын тулд бүх хүчин зүйлийг үнэлж, байгаа бүх баримтыг ашиглан аль хүчин зүйл нь зорилтод хамгийн их нөлөөлж болохыг илрүүлж, төслийн зорилгод хүрэх хөшүүргийн сайн боломжуудыг харуулах хэрэгтэй. Хөшүүргийн чадавхийг үнэлэх зарим нэг хувилбарт аюул дарамтыг бууруулах, загварын хэмжээнд олон хүчин зүйлд нөлөөлөх боломж, тэдгээрийг шийдвэрлэх зайлшгүй нөхцөл (эсвэл тэдгээрийн доод түвшний хүчин зүйл) зэрэг багтана.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд харгалзах аливаа хүчин зүйлд нөлөөлөх/оролцох боломжийг бүрдүүлнэ. Зарим тохиолдолд хамгийн боломжтой чухал орох гол цэг нь шууд аюул дарамтыг бууруулах (жишээлбэл, түрэмгий зүйлийг нутагшуулахыг бууруулах) эсвэл хамгааллын үнэт зүйл (жишээлбэл, экосистемийн нөхөн сэргээлт) байна. Гэхдээ шууд аюул дарамтад нөлөөлөх гинжин хэлхээ нь шууд бус аюул дарамтыг (жишээлбэл, бодлогод нөлөөлөх эсвэл удирдлагын оновчтой арга нэвтрүүлэх) эсвэл байгаа боломжид нөлөө үзүүлснээр нөлөөллийн илүү олон хөшүүрэг бий болгох өөр олон тохиолдол бий. Зураг 9-д чухал жишээг харуулав.


Хөндлөнгөөс нөлөөлөх гол цэгийг тодорхойлох, эрэмбэлэх, стратеги боловсруулах болон сонгох үйл явц нь өөр хоорондоо нягт уялдаатай арга барил хэрэглэх нь шийдвэр гаргах тохиромжтой арга зам болно.



PHOTO: TORRESTRAIT REGIONAL AUTHORITY

Зураг 9

Хөндлөнгөөс орох гол цэгүүд (тод хараар хүрээлэв) болон стратегийн нөхцөл байдлын дүн шинжилгээ



Нөлөөллийг хаана, хэрхэн шийдэх вэ

Стратеги бол нэг чигт үялдсан, тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тулд хөндлөнгийн гол цэгт төвлөрсөн, боломж бололцоог нэгтгэх, бэрхшээлийг хязгаарласан нэг ба түүнээс олон төрлийн үйл ажиллагааны нэгдэл юм. Стратеги нь холбоотой, төвлөрсөн, үндэслэлтэй, тохиромжтой гэсэн шаардлагыг хангасан байна (Хавсралт 2-ыг үзнэ үү).

Стратеги нь амьдрах орчныг нөхөн сэргээх, газар нутгийг хамгаалах, бодлогод нөлөөлөх, ард иргэдэд мэдээлэл хүргэх зэрэг хамгааллын олон үйл ажиллагааг багтааж болно (илүү олон жишээг Хайрцаг 5, Хамгааллын Арга Хэмжээний [Туншлэлийн Хамгааллын Үйл Ажиллагааны Ангилал](#)-аас үзнэ үү). Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх явцад боломжит стратегийн жагсаалтыг гаргаж, тэдгээрээс төслийн зорилго, зорилтод хүрэхэд (зорилтын талаар дэлгэрэнгүйг дор үзнэ үү) хамгийн сайн тохирох стратегийг (хамгийн сайн нотолгоо баримтанд түшиглэн) сонгоно. Хайрцаг 5-д хүмүүсийн зан төлөвд нөлөөлөх стратегийн зарим нийтлэг ойлголтыг орууллаа.

ХАЙРЦАГ 5. ХАНДЛАГА ӨӨРЧЛӨХ СТРАТЕГИ

Олонхи стратеги хүний зан байдлыг өөрчлөхөд чиглэсэн байдаг. Зан байдлын шинжлэх ухаан ба эдийн засагт зан байдалд нөлөөлөх стратегиудыг ерөнхийд нь дараах харилцан үгүйсгэгдэхгүй ангиудад хувааж болно. Үүнд:

- Зохицуулах – хуулийн хүчээр сонголтыг хязгаарлах
- Урамшуулал – эдийн засгийн өртөг ба шагналаар сонголтыг хязгаарлах
- Мэдээлэл – сонголт хийх эрхийг хязгаарлах биш мэдээлэл хүргэх ба ятгах
- Түлхэлт үзүүлэх – зөвлөн нөлөө үзүүлэх, сонголт хийх эрх чөлөөг хадгалахын сацүү зарим үр дүнг биелүүлэх

Стратегийг тодорхойлох, сонгох гэдэг нь одоо хэрэгжиж байгаа стратегийг судлах, шинэ стратеги гаргах, баримтад түшиглэн хамгийн боломжит стратегийг сонгох гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Одоо хэрэгжиж байгаа боломжит стратегийг судлах хэсэг нь ижил төстэй нөхцөлд эсвэл ижил зорилтот бүлэгт бусад хүмүүс ямар үйлдэл хийх оролдлого хийсэн, амжилттай хэрэгжсэн эсэхийг тодорхойлж, хэрэв үгүй бол яагаад гэдгийг судлан илрүүлэх ажил юм. Шинэ стратеги төлөвлөх хэсэг нь нөхцөл байдлын дун шинжилгээний үе шатанд боломжит шийдлийг олоход бүтээлчээр ажиллахад шаардлагатай багийн бүрдүүлсэн мэдлэг болон стратеги судалгааг хамруулна. Гол зорилго нь боломж, бололцоо, бэрхшээл, эрсдлийг тооцсоны үндсэн дээр төслийн хамгааллын зорилгыг биелүүлэх стратегийг тодорхойлох явдал юм. Хэрэв төслийн хамрах хүрээнд тухайн стратеги үр дүнтэй байж болох талаар хөдлөшгүй нотолгоо байгаа бол түүнийг хэрэгжүүлж эхлэх, баримт нотолгоо байхгүй эсвэл хоёрдмөл шинжийг агуулсан бол шинэ стратеги гарган

туршилт хийж, уян хатан менежментийг нэвтрүүлэх замаар төслийн хүрээнд тохиоро стратегийг тодорхойлж болно. Төслийн хүрээнд үр дүнтэй эсэх нь тодорхойгүй стратегийг баримталж байгаа тохиолдолд учирч болзошгүй эрсдэлүүдийг харгалzan үзэх, өөрийн стратегид мониторинг хийх шаардлагатай.

Төслийн баг нь боломжит стратегийн талаарх мэдлэгтэй байх шаардлагатай бөгөөд стратеги сонголтын аль нэг аргыг (Хайрцааг 6) ашиглан боломжит хувилбараас хамгийн тохиромжтойг сонгон нарийвчлах ёстой. Багийн стратегийн сонголт нь төслийн агуулгад хамгийн сайн нийцэх аргад түшиглэх нь зохимжтой. Гэхдээ зохион байгуулалтын бэрхшээл болон шийдвэр гаргах үйл явцыг харгалzan үзэх, зорилгодоо хүрэх, аюул дарамтыг бууруулах үйл ажиллагааг зөв газар хэрэгжүүлж буйгaa ойлгохын тулд боломжтой бол стратегийн зураглал үйлдэх нь түстай (Зураг 10).

ХАЙРЦАГ 6. СТРАТЕГИ СОНГОЛТ

Стратеги сонголт нь хязгаарлагдмал сонголт хийхийг хэлнэ. Нөөц боломжийн хязгаарлагдмал нөхцөлд төслийн баг аль стратегийг хэрэгжүүлэх эсвэл хэрэгжүүлэхгүй байх вэ гэдгийг шийдэх шаардлага тулгардаг.

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартад стратеги сонголтыг хэд хэдэн үе шаттайгаар олон янзын түвшинд хийдэг. Анхан шатанд нөхцөл байдлын дун шинжилгээгээр тодорхойлсон аюул, дарамтыг бууруулах стратегид шуурхай үнэлгээ өгч жагсаалтыг цөөрүүлэх оролдлого хийж болно. Энэ шатанд аль стратегид нэмэлт дун шинжилгээ хийх шаардлага байгааг тодорхойлох тул бүх стратегид анхан шатны үнэлгээ хийж, эцсийн шатанд стратеги сонголтыг хийж боломжит стратегиудыг хооронд нь харьцуулахад илүү анхаарал хандуулах хэрэгтэй.


Боломжит стратегиудээс тохиромжтой стратегийг сонгох шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг болох олон янзын арга бий. Үүнд:

- **Тодорхойлолтод сууринсан харьцуулалт** (жишээлбэл, давуу болон сул талын хүснэгт) – Боломжит стратегийн давуу болон сул талыг гол төлөв нөхцөл байдлын дун шинжилгээтэй уялдуулан зарим шалгуур, шийдлийн зангилааг стратеги тус бүрт болон өөр хооронд нь харьцуулан тодорхойлох.
- **Шалгуурт сууринсан харьцуулалт** (жишээлбэл, үнэмлэхүй эсвэл харьцангуй эрэмбэ, үр дагаварын хүснэгт) – Шалгуурууд ашиглан хувилбар бүрийг үнэлзэх. Түгээмэл шалгуурт боломжит нөлөө, эрсдэл, үндэслэл (санхүүгийн, техникийн, сэтгэлзүйн), таарц, орхигдol зэрэг багтана. Харьцангуй, шатлалт болон ерөнхий эрэмбэлэл ашиглахад эдгээр шалгуурыг хэрэглэж болно. Зарим шалгуурын эзлэх жинг бусдаас илүү үнэлж болно.
- **Хязгаарлагдмал сонголттой харьцуулах** (жишээлбэл, цэгэн сонголт, сонгох хүснэгт) – Нийт санхүүжилт эсвэл боломжит хугацаа зэрэг тооцох шаардлагатай хязгаарлалтуудад үндэслэн стратегийг сонго.
- **Загварт сууринсан тоон харьцуулалт** (жишээлбэл, шугаман программчлал) – Өгөгдсөн үзүүлэлт, хязгаарлалтуудын хүрээнд хамгийн тохиромжит стратеги сонгоход тус болох алгоритм боловсруулах.

Баг өөрийн төслийн агуулгад тохируулан тохиоро арга эсвэл аргуудын хослолыг сонгох хэрэгтэй.

Зураг 10


Шимпанзе бичийг хамгаалах нутаг дэсвгэрийн стратегийг харуулах орон зайн хялбаршуулсан зураглал



ХАА-Н НӨЛӨӨЛЛИЙН АЮУЛ ДАРАМТ БОЛОН АМЬДРАХ ОРЧНЫ ХОМСДОЛ

Хамгаалалттай газар нутагт ирээдүйн нөлөөллийг хязгаарлах стратеги

Эх үүсвэр: Лиллиан Пинтеагийн Хамгааллын Стандартын хэрэглэсэн жишээнээс авав, Жэйн Гоодалын Хүрээлэн



Хамгийн сүүлийн асуудал бол төсөл нь зохих түвшний нийгмийн болон байгаль орчны баталгааг хангасан байх явдал юм. Энэ нь стратегийн нийгэм, байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөг үнэлэх асуудал бөгөөд үүнд нэр төр, хүний эрх, уламжлалт мэдлэг, газар болон нөөц эзэмшиг эрх, нөлөөлөлд өртсөн бүлгүүдийн соёл, зан заншил, байгаль орчны төлөвлөөгүй үр дагаврыг харгалzan үзнэ.

Төслийн хүрээнд нийгмийн болон байгаль орчны аюулгүй байдлыг хянаж үзэх хэрэгтэй бөгөөд стратеги боловсруулах үе шатанд болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, нөлөөг бууруулахад тохируулан засах эсвэл эргэн харахад шаардлагатай байж болзошгүй тул онцгой чухал юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДАЛ 5 УУР АМЬСГАЛТАЙ ХОЛБООТОЙ СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХ



Уур амьсгалын асуудалд чиглэсэн стратегийг дэвшүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлт болон түүний үр нөлөөг бууруулахад чиглэсэн дараах стратегийг харгалzan үзнэ:

- Дарамт үүсэх нөхцлийг бүрдүүлэх энгийн аюул дарамтад нөлөөлөх замаар зорилгод хүрэхэд нөлөөлөх **Уур амьсгалтай холбоотой дарамтыг бууруулах** (жишээлбэл, ХАА-н газрыг тэлэх зорилгоор эрэг хавийн модыг отлохыг хязгаарлах замаар урсацыг сүүдэрлж агаарын температурын өсөлтөөс илүү сайн хамгаалах)
- Уур амьсгалын өөрчлөлтөд бага өртөх амьдрах орчныг хамгаалах эсвэл нөхөн сэргээх замаар **Уур амьсгалын рефуги газруудыг хамгаалах** (жгшээлбэл, бусад газар дулаарах нөхцөлд хүйтэн урсгал үс сэруүн орчинд зохицсон зүйлүүдийн амьдрах орчин болж байгаа бол урсгалын тэр хэсгийг хамгаалах/хадгалан үлдээх)
- Хамгааллын үнэт зүйлийн **Амьдрах чадварыг сайжруулах эсвэл нэмэгдүүлэх** замаар түүний уур амьсгалд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх (жишээлбэл, далайн түвшин нэмэгдэхэд түрлэгээр үүсэх намгархаг газрын талбайг эх газар руу шилжих боломжийг олгох зорилгоор дотооды шилжилт хөдөлгөөнийг хамгаалах)
- Тооцоолж буй өөрчлөлтөнд илүү тэсвэртэй зүйлүүд болон **Зорилтот зүйлийг нөхөн сэргээх** (жишээлбэл, ганд тэсвэртэй зүйлүүд)
- Алдагдсан амьдрах орчныг солих эсвэл орлуулах зорилгоор **Хиймэл амьдрах орчин бий болгох** (жишээлбэл, хуучин хөлөг онгоцыг живүүлэх замаар хиймэл хяасаа үүсгэх)
- Эмээг байдлыг хүрцатгах **Хүний буруу дасан зохицол эсвэл үйлдлээс сэргийлэх** (жишээлбэл, далайн шуурганы давалгаанаас сэргийлэх хана босгохоос зайлсхийх)



PHOTO: PAULINA YAKOVO / GROWING AND BETTER MOORE FOUNDATION

Таамаглал / Өөрчлөлтийн онол

Баг нэгэнт стратегиэ сонгосон бол стратеги тус бүрийн нэн даруй хүрэх шаардлагатай зорилт болон урт хугацааны хамгаалал, хүний сайн сайхан амьдралыг хангах зорилгод хүрэхэд хэрхэн тус болох талаарх таамаглалуудыг дэвшүүлэх шаардлагатай. Энэ нь өөрчлөлтийн онол бөгөөд үүнийг бичвэр, диаграмм эсвэл өөр бусад хэлбэрээр дүрсэлж болно. Үр дүнгийн хэлхээ нь байгаль хамгааллын урт хугацааны үр дүнд хүргэх хүлээгдэж буй богино болон урт хугацааны завсарын үр дүнг шалтгаан үр дагаварын (“тэгвэл-дараа нь”) гинжин хэлхээгээр өөрчлөлтийн онолыг илэрхийлж буй диаграмм юм. Үр дүнгийн хэлхээ нь тэгвэл-дараа нь гэсэн утга агуулсан тул энэ хэрэгсэл нь хүлээгдэж буй үр дүнгийн хугацааг мөн илтгэнэ.

Хэрэв нөхцөл байдлын дүн шинжилгээг диаграммаар илэрхийлж байгаа бол үүнийг үр дүнгийн хэлхээ хийхэд суурь болгон ашиглаж болно (Зураг 11-т ерөнхий жишээг харуулсан бол Зураг 12-т Зураг 9-ийн жишээн дээр

суурилсан жишээг үзүүлэв). Энэ нь стратеги хүсч буй төлөв байдалд (үр дүнгийн хэлхээнд харуулснаар) хүрэхийн тулд одоо байгаа төлөв байдалд (нөхцөл байдлын загварт үзүүлсэнчлэн) сонгосон стратеги хэрхэн нөлөөлөхийг тодорхой харуулахад туслана. Ихэнх тохиолдолд үр дүнгийн хэлхээнд стратегийг амжилттай хэрэгжүүлэхдэд чиглэсэн үйл ажиллагааг агуулсан байдаг. Ингэж үйл ажиллагаа бүрийг тусгаснаар төсөл нь нэг үр дүнгээс нөгөө үр дүнд хэрхэн өрнөж буйг тогтооход дэм болно.

Өөрчлөлтийн онолд заасан үр дүн, таамаглал нь бодит баримтанд тулгуурлах ёстой ч зарим таамаг нь баримтгүй байж болох тул хүлээгдэж буй үр дүнд хүргэх эсэх болон хүсээгүй үр нөлөөнөс үүсэх боломжит эрсдлийн тодорхойгүй байдал мэдэгдэхүйц өснө. Иймд баримтын орхигдолыг тодорхойлох нь чухал тул тэдгээрийг судалгаа, мониторинг, үнэлгээ болон мэдлэгийн хүрээнд эрэмблэнэ (жишээлбэл, Зураг 12-т тасалдсан шугамаар багийн гаргасан таамаглалын тодорхойгүй байдлыг илэрхийлсэн байна).


Зураг 11

Холбогдох үр дүнгийн хэлхээ бүхий “Хүчин зүйлс” нөхцөл байдлын ерөнхий загвар



Зураг 12

Гол мөрний урсац бүрэлдэх эхэд байгаль орчинд ээлтэй бүсчлэлийг дэмжих үр дүнгийн гинжин холбооны жишээ
Шалтгааны дүн шинжилгээ



Хэрэв нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд хүний сайн сайхан амьдралд чиглэсэн зорилт тодорхойлсон бол үр дүнгийн хэлхээг (илүү ерөнхийгөөр - өөрчлөлтийн онол) ашиглан хүний сайн сайхан амьдралд хувь нэмэр оруулах экосистемийн үйлчилгээг хамгааллын зорилтууд хэрхэн хангаж байгааг харуулж болно (Зураг 13-ийн баруун талд хүний сайн сайхан амьдралын зорилт агуулсан үр дүнгийн хэлхээг харуулсан).

Гэхдээ байгаль хамгааллын үйл ажиллагаа хэрхэн экосистемийн үйлчилгээгээр дамжин хүний сайн сайхан амьдралд хувь нэмэр болох болон хэзээ байгаль хамгааллын үйл ажиллагаа шууд хувь нэмэр үзүүлдгийг тодорхой мэдэж байх нь чухал. Баг ихэнх тохиолдолд

байгаль хамгааллын зорилгоос хальсан нийгмийн чухал асуудлыг шийдвэрлэн ажилладаг (жишээлбэл, сайн засаглалыг бүрдүүлэх эсвэл тогтвортой амьжиргааг хангах чадавхийг бий болгох). Ийм тохиолдолд стратеги нь байгаль хамгаалалд үйлчлэх нийгмийн үр ашгийг хангана. Зураг 14-т мод бэлтгэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, гэрчилгээжсэн туршлагыг хэрэгжүүлэх, ойн хамгааллыг сайжруулах хөшүүрэг болох багийн зорилгыг харуулсан жишээг үзүүлэв. Орлогыг нэмэгдүүлэх нь хүмүүст ашиг өгөх тодорхой стратегийн шууд (ба шаардлагатай) үр дүн юм. Энэхүү зурагт хүний сайн сайхан амьдралын зорилт (ойн аж ахуй)-ыг оруулж болох бөгөөд орлогын өсөлтөөс хүний сайн сайхан амьдралын зорилтот түвшин хамааралтай болохыг анхаарна уу.


Зураг 13.

Экосистемийн үйлчилгээ ба Хүний сайн сайхан амьдралын зорилт бүхий үр дүнгийн хэлхээний жишээ



Зорилт 14.


Хүмүүст шууд нөлөө үзүүлэх хамгааллын стратегийн жишээ



Үр дүнгийн хэлхээг төслийн тодорхой ажлыг харуулахад ашиглаж болохоос гадна төслийн хугацаа, удирдаж болох сонирхолоос давсан урт хугацааны үр нөлөөг харуулахад хэрэглэнэ. Зарим төсөл хамгааллын зорилтот түвшинд гарах өөрчлөлтийг хүсэж болох бол зарим нь аль нэг аюул дарамтыг бууруулах үр дүн (жишээлбэл, Зураг 15-д далайн усан дахь хуванцар хаягдлыг бууруулах) эсвэл завсарын үр дүнд (жишээлбэл, бодлого тодорхойлогчид хуванцарын хэрэглээг хязгаарлах хууль хэрэгжүүлэх) хүрэхдэд тэмүүлж болно. Сүүлийн тохиолдолд аюул дарамтыг бууруулах болон/эсвэл хамгааллын үр дүн илүү далд илрэх талтай.

Зураг 15.

Биологийн олон янз байдалтай шууд холбогдоогүй сонирхолыг удирдах төслийн жишээ



Зорилт

Зорилт нь зорилгодоо хүрэхэд шаардлагатай завсарын үр дүнг (эсвэл таны үр дүнгийн гинжин хэлхээн дэхь завсарын үр дүн) тусгасан албан ёсны мэдэгдэл юм. Зорилт нь багийн тооцож байгаа богино болон дунд хугацаанд хүрэхэд шаардлагатай хүчин зүйлсэд (шууд ба дам аюул дарамт, нөөц боломж) гарах өөрчлөлтийг тодорхойлно. Үр нөлөө нь тодорхой тоглогчтой холбоотой эсвэл түүнээс хамааралтай бол холбогдох зорилтод тоглогч болон хүсч буй байдлыг тодорхой тусгасан байна. Сайн зорилт (ба зорилго) нь “СМАРТ” шалгуурыг хангасан байна. Үүнд: тодорхой, хэмжигдэхүйц, биелэгдэх, үр дүнд чиглэсэн ба хугацаагаар хязгаарлагдсан (Зорилго хэсэгт оруулсан Хайрцаг 4).

Зураг 12-т үзүүлсэнээр зорилт нь өөрчлөлтийн онол хэвээр үлдэхэд шаардлагатай үр дүнтэй холбоотой. Шууд аюул дарамтад чиглэсэн зорилт тавихыг (хэрэв тэдгээр нь Зураг 15-д харуулсан удирдаж болох сонирхолын хүрээнээс халихгүй бол) сайн туршлагад тооцдог. Энэ шууд аюул дарамтын зорилт (ба хүсч буй ирээдүйн түвшин) нь хамгааллын зорилтод түвшинд тодорхойлсон зорилгод нийцсэн байна. Сайн зорилтыг тодорхойлохын тулд юу тохирох, шалгуурууд хангагдаж байгаа эсэхийг харгалzan үзэж бүх зорилтуудтай нэгд нэгэнгүй ажиллах нь чухал. Энэ нь гол төлөв давтамжит үйл явц, цаг хугацаанд илүү олон мэдээлэл бий болдог учир зорилтуудыг эргэн харж, нарийвчилахыг шаардах бөгөөд зорилтод хүрэхийн тулд стратегиудыг сайжруулах, холбогдох өөрчлөлтийн онолыг нягтлах нь мөн багтана. Хайрцаг 7-д зорилт тодорхойлох зарим нэмэлт асуудлыг оруулав.

Өөрчлөлтийн онолд тусгасан зорилго, зорилт нь гүйцэтгэх шаардлагатай ажлыг илтгэнэ. Зорилтууд нь стратеги нь үр дүнд хүрэхэд хэрхэн туслах, төслийн ахиц дэвшилийг хэрхэн үнэлэх таамаглалыг тодорхойлж өгнө.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ, зорилго, стратеги, үр дүнгийн хэлхээ, зорилтыг албан ёсны үйл ажиллагааны төлөвлөгөөнд (Зураг 8-аас олон янзын төлөвлөгөө өөр хоорондоо хэрхэн холбогддогийг эргэн үзнэ үү) тусгах ёстой.

ХАЙРЦАГ 7. ЗОРИЛТ ТОДОРХОЙЛОХОД АНХААРАХ БУСАД АСУУДАЛ

Зорилтыг тодорхойлоход тавигдах шаардлага (СМАРТ “SMART” шалгуураас гадна):

- Зорилтоо тодорхойлоход байгаа мэдээллийг ашиглах. Боломжтой бол хэр хэмжээний өөрчлөлт хэрэгтэйг тогтоохдоо одоогийн буюу суурь төлөв байдлыг ойлгох нь тустай.
- Боломжтой, зохистой гэж үзвэл өөрийн зорилтоо тоон болгоход онолын загвар, шинжэчдийн хувь нэмэр болон бусад мэдээллийг ашиглах.
- Хамгааллын үр дүнг бодитоор харахын тулд хэдий хэмжээний өөрчлөлтийг хийх шаардлагатайг тодорхойлох. Үр дүнгийн хэлхээг үр дүнтэй ахиулахад өмнөх зорилтыг хэр их гүйцэтгэх шаардлагатайг тодорхойлох, ингэхдээ тодорхойлсон зорилго эсвэл завсарын үр дүнгээ эргэн ажиллах нь зөв байдаг.
- Бусад зорилт, стратегийн хоорондын уялдаа, холбоо болон үр нөлөөг ойлгох. Нэг хэлхээнд байх зорилтууд нэг нь нөгөөгөөс нөхцөлдөх логик дараалалтай байна. Түүнчлэн бусад стратегиуд (өөр хэлхээнд байх) эцсийн үр дүнд хувь нэмэр болно гэдгийг анхаарна уу. Иймээс хэд хэдэн стратегийн үр дүнг зорилтод тусгах хэрэгтэй.

ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Байгаль хамгааллын үнэт зүйл болон шаардлагатай бол хүний сайн сайхан амьдралын зорилт бүрт харгалзах зорилгууд тодорхойлогдсон байна
- ◆ Хөндлөнгөөс нөлөөлөх гол цэгүүд, стратегиудын хувилбарыг тодорхойлсон байна
- ◆ Стратегиудыг ач холбогдоор нь эрэмбэлсэн байна
- ◆ Багийн таамаглал, гол стратегийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой болсон байна
- ◆ Завсарын үр дүн болох зорилтуудыг тодорхойлсон байна
- ◆ Үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн гаргасан байна

2B. Мониторинг, Үнэлгээ болон Суралцах Төлөвлөгөө боловсруулах

Энэ дэд үе шатанд мониторинг, үнэлгээ болон мэдлэгийн төлөвлөгөө (мониторинг төлөвлөгөө) багтана.

Мониторинг төлөвлөгөө нь зорилго, зорилтын биелэлт, өөрчлөлтийн онолтой холбоотой гол таамаглал, нөхцөл байдлын дүн шинжилгээнд гарч ирсан тодорхойгүй байдалтай холбоотой мэдээллийн хэрэгцээ, стратеги сонголт болон/буюу өөрчлөлтийн онолын явцад хяналт тавихаас гадна хэрэгжилтэд шаардлагатай нөөц боломжийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх хугацааг тогтоох, харгалзан үзэх шаардлагатай боломжит эрсдлийг тусгасан байна. Дэвшүүлсэн таамаглалд итгэх итгэл (өөрөөр хэлбэл, өөрийн таамаглалыг дэмжих хангалттай баримт байгаа эсэх), алдаанаас гарах үр дагавар, төслийн үе шат ба боломжит нөөцийн талаарх мэдлэг, мэдээллээс мониторингийн төрөл, түвшин хамаарна.

Олон нийт ба Мэдээллийн хэрэгцээ

Мониторингийн төлөвлөгөө хийхийн өмнө холбогдох олон нийт, тэдгээрийн мэдээллийн хэрэгцээг тодорхойлох ёстой. Тулгамдаж буй тодорхойгүй байдал болон төслийн тавьсан зорилтоо хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавихад шаардлагатай мэдээллээр хангах үр дүнтэй мониторинг нь хүний болон санхүүгийн хамгийн бага нөөцийг ашигладаг.

Эхний шатанд мониторинг хэнд зориулж хийж байгаа, шийдвэр гаргахад юг мэдэх шаардлагатай, мэдээлэл тэдэнд хэзээ хэрэгтэй болон хэрэгцээг хангахад ямар түвшний хяналт хэрэгтэйг тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл, нэг зорилтот бүлэг төслийг санхүүжүүлэгч байж болох бөгөөд тэд хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг мэдэхийг хүснэ. Өөр нэг бүлэг өөрсдийн ашиг сонирхлыг шийдвэрлэж байгаа эсэхийг мэдэхийг хүсч болно. Хамгийн чухал гь олон нийт бол таны төслийн баг юм. Мониторинг нь үйл ажиллагааны хэрэгжилт, зорилго болон зорилтын биелэлтэнд хяналт тавих, өөрчлөлтийн онолын таамаглалыг шалгах, тодорхой бус байдлыг бууруулах, цуглуулсан мэдээллээс мэдлэг олж авах, одоогийн болон ирээдүйн программчлалыг сайжруулахад тус болно. Доорх хүснэгтэд олон нийтийн түгээмэл хэлбэрүүд, тэдгээрийн мэдээллийн хэрэгцээний жагсаалтыг оруулсан болно.

Хүснэгт 3.

Олон нийтийн оролцоотой мониторинг, тэдгээрийн мэдээллийн хэрэгцээ

ОЛОН НИЙТ	МЭДЭЭЛЛИЙН ЕРӨНХИЙ ХЭРЭГЦЭЭ/СОНИРХОЛ
Төслийн баг ба түншүүд	Танай баг үйл ажиллагааг төлөвлөсний дагуу хэрэгжүүлж байна уу? Танай баг тогтоосон хугацаанд, баталгаат таамагын хүрээнд зорилтондоо хүрсэн үү? Юу хэрэгжиж, юу хэрэгжихгүй байгаа, яагаад? Танай баг яаж стратегиа сайжруулах вэ?
Донорууд	Танай баг үйл ажиллагааг төлөвлөсний дагуу хэрэгжүүлж байна уу? Танай баг тогтоосон хугацаанд зорилтондоо хүрсэн үү? Төслийн хэмжээнд тавьсан таамаглалууд хүчин төгөлдөр үү?
Хамрагдаж буй олон нийт болон оролцогч тал	Танай баг үйл ажиллагааг төлөвлөсний дагуу хэрэгжүүлж байна уу? Төсөл тэдэнд хэрхэн нөлөөлөх вэ?
Байгаль хамгаалах нөхөрлөл	Юу хэрэгжиж, юу хэрэгжихгүй байна? Яагаад? Төслийн юуг өөр бусад агуулгаар ерөнхийлж болох вэ?
Судлаачид ба оюутнууд	Юу хэрэгжиж, юу хэрэгжихгүй байна? Яагаад?
Аудитор болон баталгаажуулах этгээд	Төсөл хууль, журмыг даган мөрдөж байна уу? Төсөл сайн туршлагыг дагаж байна уу?

Мониторингийн хүчин чармайлтыг зөвхөн гол таамаглал (нөхцөл байдлын загвар болон үр дүнгийн хэлхээнд тусгасан) болон тодорхойгүй байдалд төвлөрүүлснээр та зөвхөн тодорхой мэдээллийн хэрэгцээг (жишээлбэл, аюул дарамтын төлөв байдал, үр дүнгийн биелэлт, тодорхойгүй байдалын хамрах хүрээ) хангахад шаардлагатай мэдээллийг цуглувулна.

Хэрэв та аль нэг үйл ажиллагаа хэрэгжээд, аль нэг нь хэрэгжихгүй байгааг ойлгох зорилгоор мониторинг хийж байгаа бол та зөвхөн тодорхой үр дүн, зорилт, зорилгод

мониторинг хийхээс гадна хүсч буй үр дүнд нөлөөлж байгаа эсвэл тэдгээрт хүрэх таны чадавхийг хязгаарлах хүчин зүйлсэд мониторинг хийх шаардлагатай. Мэдээллийн хэрэгцээг эрэмблэхдээ тухайн мэдээлэл байхгүй бол төсөлд учирч болох эрсдэл, удирдлагын шийдвэрт эдгээр мэдээллийг хэрхэн ашиглах, мэдээллийн хэрэгцээг төслийн нөөц болон хугацааны хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэхийг тооцож үзэх хэрэгтэй. Энэ нь давтамжит үйл явц гэдгийг санан стратеги тодорхойлох, эрэмблэх явцад эдгээр асуудлыг харгалзан үзэх шаардлагатай.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДАЛ 6 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ БОЛОН СТРАТЕГИД МОНИТОРИНГ ХИЙХ



Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй холбоотой олон тодорхой бус байдал байдаг – жишээлбэл, уур амьсгал яах эсвэл юу болох, хүмүүс хариу ямар үйлдэл хийх, төрөл зүйл болон экосистемүүд яаж өртөх, бидний стратеги аль хир үр дүнтэй зэрэг олон тодорхой бус асуулт бий.

Ийм олон тодорхойгүй байдал байгаа учир ямар нэг тусгай мониторинг хийх шаардлагатай эсэхийг авч үзэх нь чухал. Үүнд уур амьсгалд мониторинг хийх цаг уурын станц байгуулах эсвэл тодорхой нэг зүйл, экосистемд мониторинг хийж өөрчлөлтөнд хэрхэн хандаж буйг хянах зэрэг багтаж болно. Үүнээс гадна, өдөөгч эсвэл босго утгыг тодорхойлох арга хэмжээг багтааж болох бөгөөд энэ нь өндөр өртөгтэй, өргөн хүрээний стратеги сонгох эсэхийг тодорхойлоход туслана.

Шалгуур үзүүлэлт

Зорилтот бүлэг болон мэдээллийн хэрэгцээг тодорхойлсоны дараагийн алхам бол мэдээллийн хэрэгцээг хангахын тулд тодорхой шалгуур үзүүлэлт болон цуглуулах хэрэгтэй мэдээллийг тодорхойлно. Сайн шалгуур үзүүлэлт нь хэмжигдэхүйц, тодорхой, тохиromжтой, мэдрэмжтэй гэсэн шалгуурыг хангасан, нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм эсвэл үр дүнгийн хэлхээнд туссан гол хүчин зүйлс, үр дүн, таамаглалтай уялдсан байх шаардлагатай (Хавсралт 2

үзнэ үү). Шалгуур үзүүлэлт нь чанарын болон тоон байж болох бөгөөд дор өгүүлсэнчлэн шалгуур үзүүлэлтийг хэмжих олон төрлийн аргууд байдаг.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм, үр дүнгийн хэлхээ, зорилго, зорилтоор дамжуулан мэдээллийн хэрэгцээг эрэмбэлснээр шалгуур үзүүлэлтийн тоог цөөлж, зохицуулж болох жагсаалтыг бий болгоход тусална. Зураг 16-д өөрчлөлтийн онол шалгуур үзүүлэлтэнд хэрхэн нөлөөлж болох жишээг




PHOTO: JOHN MORRISON / WWF-MU

харуулав. Таны мэдээллийн гол хэрэгцээг хангах хамгийн цөөн тооны мэдээллийг цуглуулахыг зорих хэрэгтэй. Өмнө дурьдсанчлан, мэдээллийн гол хэрэгцээ нь нөхцөл байдлын загвар дахь орхигдол, нөхцөл байдлын загвар болон үр дүнгийн хэлхээний таамаглалыг шалгах, зорилгод хүрэх явцыг илтгэх зэргийг өөрт агуулж болно. Өөрчлөлтийн онолын дагуу мониторинг хийхдээ

стратегийн амжилттай хэрэгжилтэнд нөлөөлж болох хяналтаас өөр чухал хүчин зүйлс байж болохыг бодож хэрэгтэй (жишээлбэл, улс төрийн нөхцөл эсвэл зах зээлийн хөшүүрэг). Энэ тохиолдолд тэдгээр хүчин зүйлсэд хязгаарлагдмал тооны шалгуур үзүүлэлт ашиглан мониторинг хийж, хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг (мөн яагаад тийм эсвэл үгүй) үнэлж болно.

Зураг 16

Хамгаалалд ээлтэй бүсчлэлийн үр дүнгийн хэлхээ болон боломжит шалгуур үзүүлэлт



Арга зүй

Шалгуур үзүүлэлт боловсруулж, үндсэн мэдээллийн хэрэгцээг тодорхойлсоны дараа тэдгээрийг яаж хэмжих талаар бodoх хэрэгтэй (өөрөөр хэлбэл, таны хэрэглэх арга зүй). Зэрлэг амьтны судалгаа, газар ашиглалтыг хиймэл дагуулын мэдээгээр тодорхойлох, оролцогч талуудын сэтгэгдэл, туршлагыг тогтоох зорилгоор гол мэдээлгэчдээс ярилцлага авах гээд маш олон аргуудын жишээ юм. Арга зүй нь үнэн зөв, найдвартай, зардал багатай, хэрэгжихүйц болон тохиромжтой гэсэн шалгуурыг хангаж байх ёстой (Хавсралт 2 үзнэ үү).

Арга зүй хэрэглэх өртөг зардал, түүний найдвартай, зөв байдлын хооронд үргэлж сонголт хийх шаардлагатай болдог. Хамгийн чухал асуудал нь таны менежментийн хэрэгцээг хангахад хангалттай зөв, найдвартай мэдээлэл гаргаж өгөх зардал багатай аргыг сонгох явдал юм. Ихэнх хэрэгцээтэй гэж тодорхойлсон мэдээллийн хувьд төсөлд холбогдох анхдагч мэдээлэл цуглуулах шаардлагатай. Жишээлбэл, загасны популяцийн талаарх мэдээллийг цуглуулах нэг арга нь төрийн байгууллагын интернэтэд тавьсан загасны аж ахуйн тоон мэдээлэл байж болох,

зарим нөхцөлд анхдагч мэдээлэл цуглуулах шаардлагатай болно.

Ихэнх тохиолдолд танай баг мэдээ цуглуулах, дун шинжилгээ хийх хариуцлагыг хүлээдэг (мэдээлэл анхдагч уу, хоёрдогч уу гэдгээс хамааралгүй). Зарим тохиолдолд төслийг үнэлэх ажилд хөндлөнгийн хүн хэлсөлж болно. Аль ч нөхцөлд нөхцөл байдлын загвар, үр дүнгийн хэлхээ нь мэдээлэл цуглуулах болон дун шинжилгээ хийх ажлын хүрээг тодорхойлдог.

Үүнээс гадна хэрэглэж буй арга зүйг ашиглах тодорхой заавар боловсруулах нь тустай. Заавар нь мэдээлэлд тайлал хийх, цаг хугацаанд ижил шалгуур үзүүлэлтэд гарах өөрчлөлтэнд мониторинг хийхэд дэмжлэг болно. Баг нь шалгуур үзүүлэлт болон арга зүйг хэрэглэхээс өмнө шалгаж, зохих засварыг хийсэн байвал зохилтой. Жишээлбэл, танд хэрэгтэй бөгөөд буруу тайлбарт өртөхөөргүй мэдээлэл өгч байгаад итгэлтэй байхын тулд арга хэрэгслийг туршиж болно. Үүнтэй нэгэн адил аль болох эрт үед суурь мэдээлэл цуглуулах нь арга зүйг шалгахад тус болно. Хэрэв эхний хэдэн сарын хугацаанд суурь мэдээг цуглуулж чадахгүй бол арга зүй болон шалгуур үзүүлэлтүүдийг эргэн харах хэрэгтэй.



Энэ бүгдийг нэгтгэх нь

Олон нийт, мэдээллийн хэрэгцээ, шалгуур үзүүлэлт, арга зүй бүгд мониторингийн төлөвлөгөөний хэсэг байна. Төлөвлөгөөнд мэдээлэл хэзээ, хэрхэн, хэн цуглуулах талаар тусгана (мониторингийн төлөвлөгөөний жишээг Хүнэгт 4-өөс үзнэ үү). Эцэст нь, Ye шат 3 (хэрэгжилт) болон 4 (дүн шинжилгээ хийх, тохируулах)-д бэлтгэх явцад баг нь мэдээллийг хэрхэн хадгалах, удирдах, хүртээмжийг хангах заавар боловсруулан хөтөлсөнөөр олон нийтийн мэдээллийн хэрэгцээг хангах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой болно. Баг нь ажлын төлөвлөгөө, төсөвлөлтийн нэг хэсэг болгон (Ye шат 3) мониторингийн үйл ажиллагаа, мэдээллийн менежментийг дэмжихэд цаг хугацаа, санхүүгийн нөөцийг тооцон төлөвлөгөөнд багтаасан байх ёстой.

Хүснэгт 4

Мониторингийн төлөвлөгөөний хХэсэг

ХЭРЭГТЭЙ МЭДЭЭЛЭЛ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ / ХУВЬСАГЧ	МОНИТОРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭН	ХУГАЦАА
Зорилго LUP1.	Мужийн онцгой газрын жагсаалтанд орсон талбайд барилга бариулахгүй байх шийдвэр бүхий бүсчлэлийн журмыг батласан байна.	Хотын захиргааны хурлын тэмдэглэл хянах Хэвлэгдсэн журмын засвар, үннэчлэлийг хянах	LS	Q4, 2022
Зорилго LUP2.	2024 оны дунд гэхэд мужийн онцгой газрын жагсаалтанд орсон талбайд барилга барих зөвшөөрөл олгохгүй.	Мужийн онцгой газрын жагсаалтанд орсон талбайд барилга барихаас зайлсхийх зорилгоор олгосон зөвшөөрлийн хувь	Мужийн газар зохион байгуулагчтай зөвлөлдөх	2023, 2024 Оны дунд үе
Зорилго LUP3.	2028 он гэхэд мужийн онцгой газрын жагсаалтад орсон талбайд орон сууцны зориулалттай барилга барихгүй, зөвшөөрөл олгохгүй, төлөвлөхгүй.	Мужийн онцгой газрын жагсаалтанд орсон талбайд орон сууцны зориулалттай барилга барихаар төлөвлөсөн зөвшөөрлийн тоо	Мужийн газар зохион байгуулагчтай зөвлөлдөх Газар дээр нь очиж үзэх	LS 2025, 2028
ЗОРИЛТ.	2035 он гэхэд Вайт Голын Сав газрыг Лос Гриллостой холбох ойн коридорын өргөн дор хаяж 5 км болж, тасархайтал үүсэхгүй байна.	Коридор нутгийн тасалдалтын баримт Ойн коридорын хамгийн бага өргөн (км)	Хиймэл дагуулын зураг шинжлэх	AM, JB 2020-2040 5 жил тутам
ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ.	Мужийн онцгой газрын жагсаалтанд орсон талбайд орон сууцны шинэ барилга барихыг хорьсоор 5 км өргөнтэй тасалдалтгүй коридорыг хадгалж чадах уу? Бидний мэдэхгүй өөр аюул занал байгаа юу?	Зорилго LUP3 ба ЗОРИЛТ-ын шалгур үзүүлэлт Ойн хомдолын бусад чухал шалтгааныг тодорхойлох	Мужийн газар зохион байгуулагчтай зөвлөлдөх Газар дээр нь очиж үзэх Хиймэл дагуулын зураг шинжлэх	LS, AM, JB 2021

ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Олон нийт, тэдгээрийн мэдээллийн хэрэгцээ болон хэлбэрийг тодорхой тогтоосон байна.
- ◆ Шалгур үзүүлэлт, аргуудыг тодорхойлсон байна.
- ◆ Мониторинг, үнэлгээ, суралцах төлөвлөгөө эцэслэн боловсруулагдсан байна.

2С. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Байгаль хамгааллын төслийг зөвхөн хүмүүс болон байгууллагууд хэрэгжүүлдэг. Хичнээн сайн үйл ажиллагаа, мониторингийн төлөвлөгөө байсан ч түүнийг гүйцэтгэлийн төлөвлөгөө болгохгүй бол хэрэгжилт тун хангалтгүй болно. Ийм учраас энэ дэд үе шатанд төслийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсэгт дараах үзүүлэлт багтана. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэхдэд шаардлагатай **санхүүжилт**, эдгээр нөөцийн ургал болон боломжит эх үүсвэрийн бүртгэл. Шаардлагатай санхүүжилтийг тодорхойлохын тулд баг нь стратегийг хэрэгжүүлэх, холбогдох мониторингийг гүйцэтгэх, үр дүнг өргөн хүрээнд солилцоход хэрэгцээтэй зардлын тооцоог боловсруулах хэрэгтэй. Төслийн өөрчлөлтийн онол болон түүнд тусгасан гол хэрэгжүүлэх арга хэмжээ, мониторинг үйл ажиллагаа нь дээрх өргөн хүрээний тооцоог хийхэд шаардлагатай мэдээллээр хангана.
- Төсөл хэрэгжүүлэхдэд шаардлагатай **хүний нөөцийн чадавх, үр чадвар, бусад санхүүгийн бус нөөц**, тэдгээр нөөцийг бүрдүүлэхдэд юу хийх, ямар түншлэл бүрдүүлэх шаардлагатайг тодорхойлох. Стратегийг хэрэгжүүлэх, холбогдох мониторинг хийхэд шаардлагатай цаг хугацаа, үр чадварыг өндөр түвшинд тооцоход мөн л өөрчлөлтийн онол болон үйл ажиллагааг ашиглаж болно. Түүнчлэн багийн үр чадвар, үр чадварын орхигдолыг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн өмнөх ажлаа эргэн харж мөн болно.
- Төсөлд хамаарах **эрсдэлийн хүчин зүйлс**, тэдгээрийг арилгах. Эрсдэлийн хүчин зүйлс гэдэг нь хэрэв илэрвэл төслийн аль нэг бүрдэл хэсэгт (жишээлбэл, хугацаа, өртөг, хамрах хүрээ эсвэл чанар) сөрөг нөлөө үзүүлж болох тодорхойгүй байдал. Эрсдэлийг дотор нь төлөв байдалд нөлөөлөх pragmatik эрсдэл (жишээлбэл, улс төрийн тогтвортгуй байдал, ган), төсөл хэрэгжүүлэх чадавхид нөлөөлөх гүйцэтгэлийн эрсдэл (жишээлбэл, байгууллагын манлайллын өөрчлөлт, түншүүдийн чадавхийн хязгаарлагдмал байдал) гэж хуваан үзэж болно. Эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлийн хүчин зүйл тохиолдох магадлал, хэрэв илэрвэл илрэх нөлөө болон зэрэглэлийг үнэлнэ. Эрсдэлийн үнэлгээний зорилго нь гол стратеги, зорилгод хүрэхдэд хэрэгжүүлэх төслийн чадавхид сөрөг нөлөө үзүүлэх асуудлуудыг тодорхойлох бөгөөд эдгээр эрсдэлийг бууруулах эсвэл зайлсхийх нэмэлт стратегийг тогтооход оршино. Иймээс эрсдэлийн үнэлгээ нь стратегийг сонгох чухал оролт (Ye шат 2A) юм. Эрсдэлийн үнэлгээний маят (байгууллагын боловсруулсан, хэрэв шаардлагатай бол) нь эрсдэлийг баримтжуулах ба үнэлэх, ингэснээр таны хүчин чармайлтыг эрэмбэлэн, төслийн хэрэгжилтийн явцад үүсчэх эрсдэлийг дахин үнэлэхэд чухал ач холбогдолтой.



- Төсөл хир удаан үргэлжлэх, багийн оролцоогүйгээр төслөөс гарсан үр дүнгийн тогтвортой байдлыг хэрхэн хангахыг тодорхойлох **хаалтын стратеги гэнэ**. Хэдийгээр энэ бүрэлдэхүүн хэсгийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний дэд үе болгон оруулсан ч төслийн тогтвортой байдал, хаалтын хувилбарыг төсөл эхлэхэд эхнээс нь харгалzan үзэх нь чухал. Энэ нь холбогдох үйл

ажиллагаа ажлын төлөвлөгөөнд бүрэн тусаж, төсөл хэрэгжих явцад уян хатан байдлаар өөрчлөгдөх боломжтойг баталгаажуулахад тустай. Эдгээр хүчин зүйлийг үл тоох нь төслийн баг болон оролцогч талуудад бодит биш төсөөлөл үүсэхэд хүргэн, төслийн цаг хугацаанд удирдахад хүндрэл учруулж болзошгүй.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хоёр бүрэлдэхүүн хэсэг нь Ye шат 3-т илүү тодорхой дурьдагдах ажлын төлөвлөгөө (дээд түвшний) болон төсвийн техник суурийг бүрдүүлнэ. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний нарийвчлал, албажуулалтын түвшин нь төслийн цар хүрээ болон цогц байдлаас хамааран өөр өөр байна. Жижиг төслүүд эдгээр сэдвийг өнгөц хөндөх бол илүү цогц шинжийг агуулсан том төслүүд тэдгээрийг илүү нухацтай бөгөөд албан ёсоор хөндөнө.

ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Хүний, санхүүгийн болон бусад нөөц боломжийн үнэлгээ хийсэн байна
- ◆ Эрсдлийн үнэлгээ, тэдгээрийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гарсан байна
- ◆ Төслийн дуусах хугацааг тооцох, хаалтын стратеги боловсруулсан байна

Төлөвлөлтийн Ye Шатны төгсгөлд стратеги төлөвлөгөөний (Зураг 8) бүхий л бүрэлдэхүүн хэсгийг боловсруулсан байна. Төслийн хэрэгцээнээс хамааран эдгээр мэдээллийг албан ёсны төлөвлөгөөнд нэгтгэж болно. Хэрэв MIRADI зэрэг программ хангамж ашиглаж байгаа бол эдгээр мэдээллийг программд оруулах, шаардлагатай бол холбогдох төлөвлөгөө, баримт бичгийн хэлбэрээр гаргана. Энэ нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд шинэчилэл өөрчлөлт хийж болох “амьд” төлөвлөгөөг бүрдүүлэхээс гадна төсөв зэрэг мэдээллийг бусад зохион байгуулалтын системтэй холбох боломжийг бий болгодог.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэ алхмын талаар нэмэлт мэдээлэл: <https://conservationstandards.org/resources/>

Бодит жишээнүүд: <https://conservationstandards.org/case-studies/>



ХЭРЭГЖҮҮЛЭХ

ХЭРЭГЖҮҮЛЭХ

Хэрэгжүүлэх алхам нь байгаль хамгаалах үйл явц дахь хамгийн чухал буюу өмнөх бүлгүүдэд төлөвлөж байсан бүх хүчин чармайлтыг хэрэгжүүлж эхлэх алхам юм. Энэ алхамаар хэрэгжүүлэх тодорхой ажлын төлөвлөгөөг боловсруулахын зэрэгцээ, хэрэгжилтийг нь хангахад шаардагдах хангалттай нөөц, чадавхи болон хамтран хэрэгжүүлэх талуудыг тодорхойлоход оршино. Энэ бүх ажлыг хэрэгжүүлэгч байгууллагын бодлого, журам болон ажлын төлөвлөгөө, төсвийг батлах шийдвэр гаргах зэрэг нь энэ хүрээнд хийгдэх ёстой.

Төслийг хэрэгжүүлж буй хүн бүр төлөвлөлтийн үе шат бүхэнд оролцоогүй байж болох тул, баримтжуулсан шийдвэр байгаа бол багийн гишүүдэд өгөх нь ажлыг илүү хялбар болгоно. Төсийг хэрэгжүүлэх үе шатуудад олон баг дамжин, төлөвлөгөөг уялдуулан, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно. Байгаль хамгаалах үйл ажиллагаандадаа дасан зохицооос гадна холбогдох дүн шинжилгээг нягтлах, түүнд уялдуулах талаар анхаарах хэрэгтэй (жишээлбэл, нөхцөл байдлын дүн шинжилгээ, эрсдлийн болон оролцогч талуудын үнэлгээ). Үүнийг хийх нь тухайлбал, ажлын төлөвлөгөөндөө шинэ эрсдлийг зохицуулах үйл ажиллагааг нэмэх, эсвэл шинэ оролцогч талуудтай харьцах шаардлагатайг ойлгоход тусалдаг.

ЗА. ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Байгаль хамгаалах төлөвлөлтийн арга зүйн өмнөх үе шатанд төслийн баг нь үйл ажиллагаа, мониторингийн төлөвлөгөөг багтаасан стратеги төлөвлөгөөг боловсруулна (Зураг 8). Энэ үе шатанд эдгээр ерөнхий төлөвлөгөөг илүү тодорхой болгож, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэ алхамын эхний үе шат нь төслийн баг, талуудтайгаа хамтран ирэх хэдэн сар, эсвэл хамгийн ихдээ нэг жилийн хугацааг хамарсан илүү тодорхой богино хугацааны ажлын төлөвлөгөөг боловсруулах боловсруулах явдал юм. Төлөвлөгөөнд дараах зүйлийг багтаасан байх ёстой:

- Стратеги төлөвлөгөөнд тусгасан арга замуудыг хэрэгжүүлэхд ямар тодорхой үйл ажиллагааг төлөвлөх. Ахиц дэвшил, эсвэл эргэлзээтэй байгаа асуудал болон үндсэн үйл ажиллагааг (тухайлбал, долоо хоног бүр багийн уулзалтад хийх) оруулах;
- Үйл ажиллагаа, даалгаварыг гүйцэтгэхд хэн хариуцах;
- Даалгавар бүрийг гүйцэтгэх хугацаа, дараалсан хийх ажлууд ямар байх;
- Үйл ажиллагаа, даалгавар тус бүрийг хаана хэрэгжүүлэх.

Байгууллага нь ажлын төлөвлөгөөнд тусгах хугацааны удирдамжтай байж болох ч ерөнхийдөө дараагийн 3-12 сарын ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, урт хугацааны мэдээллээр хангах нь зүйтэй. Цаг хугацааны явцад боломжит түвшинд тооцоолж, илүү тодорхой болгон сайжруулж болно.

Ажлын нарийвчилсан төлөвлөгөө нь төслийн хэрэгжилтийн хугацааг боловсруулах үндэс суурийг бүрдүүлнэ. Төслийн багийн бүх гишүүд төслийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх хугацааг төсөвлөхийн тулд цагийн хуваария боловсруулж байх нь чухал. Ажлын төлөвлөгөө нь аль багийн гишүүд завтай байж, аль нь их ачаалалтай болохыг тодорхойлоход тусална. Эдгээр мэдээлэл нь төслийн төсвийг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Төслийн хэрэгжилтийн явцад төслийн таамаглалуудыг эргэн харж, ажлын төлөвлөгөөг ойрын сараар илүү нарийвчилсан үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хүснэгт 17-д төслийн үйл ажиллагаа, мониторингийн үйл ажиллагаанд ажиллах хүмүүсийн хүснэгтийн жишээг үзүүлэв. Ажлын төлөвлөгөөг Miradi, хүснэгт, Gantt график, эсвэл төслийн хуанли дээр бичиж болно.

♦ ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ♦ Үйл ажиллагааны болон мониторингийн төлөвлөгөөтэй холбоотой үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон ажлын төлөвлөгөө
- ♦ Төслийг хэрэгжүүлэх хугцаа болон календарь

Хүснэгт 17.

Хүмүүсийн ажил, үүргийн хуваарь, далай дээр хэрэгжүүлж буй төслийн ажлын төлөвлөгөө

ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	1-Р	2-Р	3-Р	1-Р
АКУЛЫН СЭРВЭЭГЭЭР ШӨЛТЭЙ ХООЛ ХИЙХИЙГ ЗОГСООН КАМПАНИТ АЖИЛ	7	3,5	24	34,5
АКУЛ 1 CAI-тай хамтран кампанит ажлын төлөвлөгөө хийх	7	1,5	1	9,5
АТ Анна Томас	5	1	1	7
ЭМ Элера Мартин	2	0,5	-	2,5
АКУЛ 2; Кампанит ажлаа хийх	-	-	15	15
АТ Анна Томас	-	-	10	10
ЭМ Элера Мартин	-	-	5	5
АКУЛ M1; Кампанит ажлын явцыг хянах	-	-	2	2
АТ Анна Томас	-	-	2	2
АКУЛ M2; FAO-ын мэдээлэлд дүн шинжилгээхийх	-	-	1	1
АТ Анна Томас	-	-	1	1
АКУЛ M3; Орон нутгийн ажиглагчдыг сургах, дэмжих	-	2	5	7
ЭМ Элера Мартин	-	2	5	7
ЗАВЬНУУДАД ХАРХНЫ ХААЛТ ТАВИХ БОДЛОГЫН БИЧГИЙГ АЛБАЖУУЛАХ	4	2	1	7

ТАЙЛБАР

- Стратеги
- Үйл ажиллагаа
- Мониторинг

3B. ТӨСЛИЙН ТӨСВИЙГ БОЛОВСРУУЛАХ

Хэрэгжүүлэх ёстой даалгавар, үйл ажиллагааг илүү тодорхой мэдэж авсны дараа хэрэгцээтэй нөөцөө тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан санхүүжилтийн дун шинжилгээг хийх хэрэгтэй (Алхам 2C). Энэ нь стратеги болон ажлын төлөвлөгөөний тодорхой үйл ажиллагааны зардлын нарийвчилсан тооцоог боловсруулж, тэдгээрийг тэтгэх илүү өргөн стратеги боловсруулахад туслах болно.

Төслийн төсвөө боловсруулахаа байгууллагынхаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудтай хамтран ажиллах нь чухал юм. Олон төслүүдийн хувьд хамгийн үнэтэй хэрэгцээ нь ажилчдын цаг хугацаа байх болно. Бусад томоохон зардлуудын (жишээлбэл, дэд бүтэц, тээврийн хэрэгсэл, завь, машин механизм) шаардлагыг бодох хэрэгтэй. Мөн хяналт, менежментийн зардал, захирагааны болон ложистикийн дэмжлэгээс авахуулаад төсөлд шаардлагатай байж болох нэмэлт нөөцийг анхаарч үзэх хэрэгтэй.

Хүснэгт 18.

Зардлын дэлгэрэнгүй болон бусад зардлыг багтаасан ажлын төлөвлөгөөний жишээ

Хүснэгт 18-д төслийн үйл ажиллагаа, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг багтаасан Хүснэгт 17-ын ажлын төлөвлөгөөг харуулсан болно. Эдгээр зардлыг томилогдсон хүмүүсийн ажлын цагийн өртөгтэй хослуулан үйл ажиллагаа тус бүрийн нийт төслийг гаргана. Төслийн төсөвт үйл ажиллагааны ерөнхий зардал, тодорхой стратеги, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй шууд холбоогүй нэмэгдэл зардлыг багтаана.

төлөвлөсөн ажил	АЖЛЫН НЭГЖ				ТӨСЛИЙН ЗАРДАЛ				НИЙТ ТӨСӨВ
	2017	2018	2019	НИЙТ	2017	2018	2019	НИЙТ	
АКУЛЫН СЭРВЭЭЗЭЭР ШӨЛТЭЙ ХООЛ ХИЙХГЭЗГСООН КАМПАНИЯЖИЛ	36,5	14	9	59,5	5 000	1 250	1 250	8 100	13 625
АКУЛ 1: CAI-тай хамтран кампанит ажлын төлөвлөгөө хийх	11,5	-	-	11,5	5 000	-	-	5 000	5 925
АТ Анна Томас	8	-	-	8	-	-	-	-	400
ЭМ Элера Мартин	3,5	-	-	3,5	-	-	-	-	525
Аялалын зардал	-	-	-	-	5 000	-	-	5 000	5 000
АКУЛ 2; Кампанит ажлаа хийх	15	5	-	20	-	-	-	-	1 700
АТ Анна Томас	10	3	-	13	-	-	-	-	650
ЭМ Элера Мартин	5	2	-	7	-	-	-	-	1 050
АКУЛ M1; Кампанит ажлын явцыг хянах	2	4	4	10	-	-	-	-	500
АТ Анна Томас	2	4	4	10	-	-	-	-	500
АКУЛ M2; FAO-ын мэдээлэлд дун шинжилгээ хийх	1	1	1	3	-	-	-	600	750
АТ Анна Томас	1	1	1	3	-	-	-	-	150
Захиалыг тайлагнах	-	-	-	-	-	-	-	600	600
АКУЛ M3; Орон нутгийн ажиглагчдыг сургах, дэмжих	7	4	4	15	-	1 250	1 250	2 500	4 750
ЭМ Элера Мартин	7	4	4	15	-	-	-	-	2 250
Төслийн сайт дээр очиж мэдээлэл цуглуулах	-	-	-	-	1 250	1 250	2 500	2 500	
БУСАД ЗАРДАЛ	-	-	-	-	55 000	25 000	20 000	100 000	100 000
ТОНОГ ТӨХӨРӨМЖ	-	-	-	-	20 000	5 000	-	25 000	25 000
Компьютер	-	-	-	-	5 000	-	-	5 000	5 000
Машин	-	-	-	-	20 000	-	-	20 000	20 000
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-	-	-	35 000	20 000	20 000	75 000	75 000
Илүү зарцуулалт	-	-	-	-	35 000	20 000	20 000	75 000	75 000

Төслийн төсвийг боловсруулсны дараа боломжит санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлон, боломжит хандивлагчдад санал боловсруулж хүргүүлэх хэрэгтэй. Стратеги төлөвлөгөөнд цуглувсан мэдээллийг санхүүжилтийн баттай саналуудыг боловсруулахад ашиглах хэрэгтэй. Ихэнх төслийд санхүүгийн урт хугацааны эх үүсвэр шаардагдах тул төслийн мөчлөгийн янз бүрийн үе шатанд хөрөнгө босгох нь үргэлжлэх үйл явц байх болно. Стратеги төлөвлөгөөг санхүүжилтийн саналд мэдээлэл болгон ашиглахаас гадна, төслийн ахиц дэвшил, олсон дадлага туршлага, дасан зохицох чадварыг харуулахын тулд гарч буй үр дүн, олж авсан мэдлэгээ хандивлагчдад хүргэх санал, тайландаа тусгаж болно. Энэ нь хандивлагчдад Байгаль хамгааллын стандарт арга зүйн хандлага, Байгаль хамгаалах төлөвлөлтийн арга зүйг дэмжихийн ач холбогдлыг ойлгоход нь туслах боломжийг олгоно. Үүнд төслийн загвар, төлөвлөлтөд нөлөөлдөг шийдвэрээс эхлээд, нэмэлт тайлбар болон мониторингийн дүн шинжилгээ, уялдуулах зэрэг тусгал нь болдог.

Хамгийн тэргүүлэх ач холбогдол бүхий стратегиудийн санхүүжилтийг эхнээс нь хайж, олох нь зүйтэй. Бодит байдал дээр боломжийг ашиглах, зарим хязгаарлагдмал зүйлд дасан зохицох хэрэгтэй болж, анхны санхүүжилт нь зарим дунд хугацааны болон нэн тэргүүний бус стратегид төвлөрч байж болно. Нэн тэргүүний ач холбогдол бүхий стратегиа марталгүй, аль болох богино хугацаанд хэрэгжүүлэхийн төлөө хичээх нь зүйтэй.

♦ ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ♦ Төслийн төсөв
- ♦ Боломжит санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлон
- ♦ Санхүүгийн саналыг боловсруулж хүргүүлсэн
- ♦ Санхүүгийн эх үүсвэрийг олсон



ЗС. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

З-р алхамын дараагийн бөгөөд хамгийн чухал хэсэг бол стратеги төлөвлөгөө, илүү нарийвчилсан ажлын төлөвлөгөөг хуваарийн дагуу, төсвийн хүрээнд хэрэгжүүлэх явдал юм. Үүнд төлөвлөсөн үйл ажиллагаа, мониторингийн аль алийг нь хэрэгжүүлэх багтана.

Хэрэгжүүлэх шатанд орохын өмнө ажилтнуудтай (ялангуяа шинэ ажилтнууд байгаа бол) эхлэлийн уулзалт хийх нь ашигтай байдаг. Энэ нь багийг бүрдүүлэх, багийн бүх гишүүдэд төслийн дизайн, төсвийн хувиарлалт, хандивлагчдын гэрээний нөхцөл, дотоод бодлого болон бусад холбогдох дэлгэрэнгүй мэдээллтэй танилцах боломжийг олгоно. Хэрэгжүүлэх багийн гишүүдийг эхнээс нь татан оролцуулахыг хичээж, багийн уулзалтуудыг

тодорхой давтамжтайгаар хийж байснаар баг нь ахиц дэвшилд тогтмол хяналт тавьж, хамтран ажиллаж чаддаг.

Хэрэгжилтийг хянахын тулд явцыг хянах үнэлгээний арга зүйг Progress tracking tools ашиглаж болно. Хэрэгжилтийн явцын тайланг тогтмол гаргаж байх нь дараагийн алхамуудыг илүү нарийвчлан тусгахаас гадна

хандивлагчид, дэмжигчдэд тайлагнахад туслах болно (жилээр, эсвэл улирлаар). Өөрчлөлт, үр дүнгийн гинжин хэлхээний Result chain хүрээнд өөрийн ахиц дэвшлийг харах нь чухал юм (Алхам 4B-д илүү нарийвчлан харуулсан). Хүснэгт 19, 20-д үйл ажиллагааны явцын талаар мэдээлэх янз бүрийн форматыг санал болгов.

Хүснэгт 19.

Хүснэгт хэлбэрээр үйл ажиллагааны явцын тайлангийн жишээ


ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	АХИЦ ДЭВШИЛ	ЯВЦЫН ДЭЛГЭРЭНГҮЙ
АКУЛЫН СЭРВЭЭГЭЭР ШӨЛТЭЙ ХООЛ ХИЙХИЙГ ЗОГСООХ КАМПАНИТ АЖИЛ	Хэрэгжиж байгаа	-
АКУЛ 1 CAI-тай хамтран кампанит ажлын төлөвлөгөө хийх	Дууссан	Кампанит ажлын төлөвлөгөө хэрэгжиж дууссан
АКУЛ 2; Кампанит ажлаахийх	Хэрэгжиж байгаа	Эхэлж байгаа боловч эрчимжүүлэх шаардлагатай
АКУЛ M1; Кампанит ажлын явцыг хянах	Жижиг асуудал	Хэрэгцээт мэдээллийг цуглуулах явц хүндрэлтэй хэвээр байна
АКУЛ M2; FAO-ын мэдээлэлдүн шинжилгээ хийх	Жижиг асуудал	Өнгөрсөн улирлын өгөгдлийг хараахан цуглуулаагүй байна
АКУЛ M3; Орон нутгийн ажиглагчдыг сургах, дэмжих	Төлөвлөсөн	-
ХАРХ УСТГАЛ	Гол асуудал	Урхиар барих стратеги байгаа ч харх нэвтрэхэд саад болж байгаа эсэх нь тодорхойгүй байна
2A. ГОЛ АРЛУУДДЭЭР ХАРХЫГ БАРИХ 	Хэрэгжиж байгаа	-
2B. ЗАВЬНУУДАД ХАРХНЫ ХААЛТ ТАВИХ БОДЛОГЫН БИЧГИЙГ АЛБАЖУУЛАХ 	Хэрэгжиж байгаа	-
ХАРХ 1.1 Шийдвэр гаргахад мэдээлэл цуглуулах үүднээс харх устгах технологийг судлах	Дууссан	Бодлогод мэдээлэх зорилгоор харх устгах технологийг судалсан
ХАРХ 1.2 Яамны мэргэжилтнүүдийг сургах	Хэрэгжиж байгаа	Компаниуд манай утасны дуудлагад хариу өгөхгүй байна
ХАРХ 1.3 Жуулчдад мэдээлэл түгээх	Хэрэгжиж байгаа	Бэлтгэл ажлыг хийж байна

ТАЙЛБАР

- Стратеги
- Үйл ажиллагаа
- Мониторинг

Зураг 20.

Үр дүнгийн хэлхээний диаграмм дахь үйл ажиллагааны явцын тайлангийн жишээ



Хэрэгжүүлэлтийн туршид хяналтын мэдээллийг Monitoring data цуглуулна. Үүний нэг чухал хэсэг нь өгөгдлийг Data цуглуулах, хадгалах, цаадын дун шинжилгээ, хандалтанд тохируулах явдал юм. Жижиг төслүүдийн хувьд цаасан дээр сууринласан энгийн систем хангалттай байж болох юм. Олон хүмүүс хамрагдах эсвэл удаан хугацаагаар хэрэгжих төслүүдийн хувьд олон байгууллага, хэлтэстэй хамтран ажиллах тул, одоо ашиглаж байгаа өгөгдлийн системүүдээ баталгаажуулж, шаардлагатай байж болох тохиргоог олж тогтоох хэрэгтэй байх.

Ажлын төлөвлөгөө болон төсөвтөө эдгээр системийг бүрдүүлэх тодорхой хугацаа, нөөцийг суулгаж өгөх нь зүйтэй. 4-р алхамд шилжихийн өмнө (Үр дүнг үнэлэх, уялдааг хангах) өгөгдлөө нэгтгэж, бүрэн бүтэн, нарийвчлалтай эсэхийг шалгах хэрэгтэй. Хүснэгт 21-д Мирадид нэгтгэсэн мониторингийн мэдээллийг харуулав.

4, 5-р алхамаар дамжуулан ахиц дэвшилд дун шинжилгээ хийж, төслөө тохируулахын тулд 3-р алхам үргэлжлэх болно.



ФОТО: РИЧАРД САУЛСОН / АКВАКОМПАНИЯ МИРАДИД

Хүснэгт 21.

Мониторингийн өгөгдлийн жишээ

ТӨЛӨВЛӨСӨН	ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ	ХЭМЖИХ ХУГАЦАА	НЭГЖ	ХАНДЛАГА	ЭХ СУРВАЛЖ
2. ХАРХ УСТГАХ	Их сургуулийн судлаачдын хийсэн мониторингийс харахад хархнууд гол арлууд дээр үүрлэж буй далайн шувууд руу халдаг байна.	-	-	-	-
Е. ҮҮРЛЭЖ БҮЙ ДАЛАЙН ШУВУУДЫН ТОО ТОЛГОЙ	2025 он гэхэд Eastern Bay арлуудадор хаяж Ruby-crested puffins 750 үржлийн хос байна.	-	-	-	-
E1. Ruby- crested puffins шувууны үржлийн хосын тоо		2016-03-19	210	Хурдтай буурч байгаа	Шуурхай үнэлгээ
		2008-03-02	1200	Тогтвортой	Түргэвчилсэн үнэлгээ
ХАРХ 1. ЗАВИНД ХАРХ ОРОХ БОЛОМЖГҮЙ ХААЛТ ХИЙСЭН БАЙНА	2018 оны 6-р сар гэхэд Eastern Bay арлуудад ирж буй завинд хархны саад тавьсан байна.	-	-	-	-
Харх 1. Хархны саад сууринуулсан завины эзлэх хувь	Eastern Bay аралд ирдэг хархны саадтай завины хувь	2016-06-30	0	Тодорхой бус	Аман мэдээ
ХАРХ 2. ГОЛ АРЛУУД ХАРХГҮЙ БОЛСОН БАЙНА	2019 оны 6-р сар гэхэд шувууны үржил явагддаг бүх арлууд дээр харх бүрэн устсан байна.	-	-	-	-
Харх 2a. Хавханд орсон хархны тоо	Арал тус бүрт нэг долоо хоногийн хугацаанд хавханд орсон нийт хархны тоо. Гурван долоо хоног харх үзэгдэхгүй байвал хархгүй болсонд тооцно	2018-03-31	хэдэн арав	Бага зэргээр буурч байгаа	Түргэвчилсэн үнэлгээ

ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Стратеги төлөвлөгөө (Үйл ажиллагаа, мониторинг, үйл ажиллагааны төлөвлөгөө) болон ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төслийн төсөв, хувиарийг санууулж байх
- ◆ Өгөгдөл хадгалах, нэвтрэх системийг хөгжүүлэх
- ◆ Байгууллага, санхүүжүүлэгчид болон төслийн бусад оролоцгч талуудад ажлын тайлан гаргах
- ◆ Системд хадгалагдсан өгөгдлийг хянах

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэ алхмын талаар нэмэлт мэдээлэл: <https://conservationstandards.org/resources/>

Бодит жишээнүүд: <https://conservationstandards.org/case-studies/>



ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, УЯЛДААГ ХАНГАХ



ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, УЯЛДААГ ХАНГАХ

Байгаль хамгаалах төлөвлөлтийн энэ шатанд ирж буй өгөгдлийг боловсруулж, хэрэгцээтэй мэдээлэл, мэдлэг болгон хувиргахын тулд тогтмол дүн шинжилгээ хийх явдал юм (Зураг 22). Ялангуяа, төслийн үр дүн, үндсэн таамаглал, гол эргэлзээ, холбогдох үйл ажиллагааны болон санхүүгийн өгөгдөл дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол ажлын төлөвлөгөөндөө тохишуулах хэрэгтэй. Төслийн менежерүүд энэ үе шатыг хийхэд шаардагдах хугацааг дутуу үнэлсэнээс дүн шинжилгээ хийгээгүй, ашиглаагүй олон тооны өгөгдөлтэй болдог.

Зураг 22.

Сонирхож буй асуултын нотолгооны сууриний бүдүүвч зураглал



Эх сурвалж Salafsky et al. 2019. [Defining and Using Evidence in Conservation Practice](#)

Шинжилгээний төвөгтэй байдлын түвшин нь маш энгийн бөгөөд хурданаас авахуулаад, хугацаа их шаардсан, нарийн төвөгтэй хүртэл байна. Хяналтын аргуудыг сонгоходо дүн шинжилгээний түвшин, нөхцөл байдал нь шаардагдах нотолгооны түвшинтэй нийцэж байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.

4A. ДҮН ШИНЖИЛГЭЭНД ЗОРИУЛЖ ӨГӨГДЛӨӨ БЭЛТГЭХ

Дүн шинжилгээ гэдэг нь түүхий өгөгдлийг хэрэгцээтэй мэдээлэл болгон хувиргах үйл явц бөгөөд төслийн хэрэгжилтийн ганц цэгт хийгдэх ёсгүй. Төсөлд юу болж байгааг тасралтгүй ойлгож, цаг тухайд нь өөрчлөх чадвартай байхын тулд 3-р алхамд хийсэн өгөгдлийн менежментийн системийг ашиглан мониторингийн өгөгдлийг төслийн байнгын ажлын нэг хэсэг болгон

хяналт шинжилгээний өгөгдлөө цуглувулж, дүн шинжилгээ хийж байх нь чухал.

Дүн шинжилгээнд зориулж мэдээлэл бэлтгэх нь 3 ба 4-р алхамуудын хоорондох үргэлжлэл юм. Төслийн баг нь бүх өгөгдлүүд, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг тогтмол бүртгэж, хадгалан, боловсруулж, нөөцлөх хэрэгтэй. Түүхий өгөгдлийг цуглувулахдаа системтэйгээр шалгаж, боловсруулж байвал ажил илүү хялбар байх бөгөөд стратеги төлөвлөгөөнд тусгагдсан мэдээллийн гол шаардлагыг хангахын тулд өгөгдлөө боловсруулж, танилцуулж байх нь зүйтэй. Жишээлбэл, хэрэв улсын бүртгэлд багтсан онцгой бүсэд хичнээн барилга барих зөвшөөрөл шинээр олгож байгаа талаар мэдээлэл цуглувулж байгаа бол (Зураг 12,16 -ийг харна уу) систем нь зорилгоо хялбархан шалгах боломжийг олгоно (2024 оны дунд үе гэхэд шинээр баригдах бүх зөвшөөрлүүд муж улсын жагсаалтад багтсан онцгой бүсэд хөгжихөөс зайлсхийх болно).

ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Төслийн гол өгөгдлийг тогтмол бүртгэж, сэргээж, боловсруулж, нөөцлөх

4В. ҮР ДҮНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ТУСГАХ

Байгаль хамгаалах сайн туршлагын нэг чухал хэсэг нь (Байгаль хамгаалах төлөвлөлтөд Conservation Standard заасны дагуу) тодорхойлсон зорилго, зорилтоо биелүүлж байгаа эсэхээ системтэйгээр тогтмол үнэлэх явдал юм. Мониторингийн өгөгдөл нь Monitoring data мэдлэгийн цоорхойг нөхөх, хүлээгдэж буй завсрлын үр дүнд хүрсэн эсэхээ тодорхойлох, урт хугацааны амжилтанд хүрэх эсэхээ үнэлэхэд туслах болно. Мониторингийн өгөгдөл дүн шинжилгээ хийх нь (мөн үнэлгээний өгөгдөл эсвэл үр дүн) төлөвлөх үе шатанд дэвшүүлсэн үндсэн таамаглалууд (ялангуяа нөхцөл байдлын дүн шинжилгээ эсвэл өөрчлөлтийн онолууд) бодит байдалд нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход тусална. Энэхүү мэдлэг нь тодорхой үйлдлүүд яагаад амжилтанд хүрсэн эсвэл бүтэлгүйтсэнийг ойлгоход нь төслийн багт туслах болно. Үндсэн таамаглалуудыг туршиж, тусгаснаар төслийн үйл ажиллагааг илүү сайн уялдуулж, түүнд тохируулан өөрчлөх боломжтой. Мөн байгаль орчныг хамгаалах бусад хүчин чармайлтыг мэдээлэхэд туслах өргөн цар хүрээтэй нотлох баримт бүрдүүлэхэд мэдлэг, туршлага хуримтлуулдаг.

Баг нь төслийн төлөвлөгөө, мониторингийн өгөгдөл суралцан, дасан зохицоход ашиглаж байгааг баталгаажуулахын тулд төслийг тогтмол (ойролцоогоор 6-12 сар тутамд) хянаж, хэлэлцдэг байх хэрэгтэй. Эдгээр тоймд төслийн баг нь дараах асуудлыг шийдвэрлэхийн тулд дүн шинжилгээг ашиглана:


- Та үйлдлээ хэрэгжүүлэх замдаа явж байна уу? Хэрэв үгүй бол яагаад? Та ямар зохицуулалт хийх ёстой вэ? (Зураг 19 ба 20 –ийг харах)

- Та хүрнэ гэж бодож байсан үр дүн, гол үр дүнтэй холбоотой зорилго, зорилтдоо хүрч байна уу? Хэрэв үгүй бол яагаад? Төслийн үр дүнд нөлөөлж буй өөр агуулгын хувьсагчууд байна уу? Та ямар зохицуулалт хийх ёстой вэ? (Зураг 23)
- Бусад тэргүүлэх мэдээллийн хэрэгцээ (нөхцөл байдал, үр дүнгийн хэлхээний диаграмм дахь тасархай цэгүүд, асуултын тэмдгүүдээр харуулсан тодорхойгүй байдал, өөрчлөлтүүд орно) нэмж оруулсан уу? Хэрэв тийм бол, энэ нь төслийн талаар юу хэлж өгч байгаа бөгөөд ямар тохируулга хийх шаардлагатай байж болох вэ? Хэрэв та эдгээр мэдээллийн хэрэгцээг хангаагүй бол тэргүүлэх чиглэл хэвээр байна уу? Хэрэв тийм бол цаашид үүнд хэрхэн хандах вэ?



Зураг 23.

Үр дүнгийн явцыг харуулах гинжин хэлхээний жишээ



Төслийг дэмжиж буй үйл ажиллагааны үйл явцуудыг хэвийн ажиллаж байгаа эсэхийг харгалзан үзэх нь чухал юм. Төсөл нь хамгаалах үнэт зүйлд нөлөөлж буй аюул дарамт, боломжийг шийдвэрлэх төгс стратегиудыг ашигладаг байж болох ч, төслийн баг үр дүнтэй ажиллаж чадахгүй байгаа эсвэл ажлаа сайн хийхэд шаардагдах захиргааны болон санхүүгийн дэмжлэг байхгүй байж магадгүй. Дүн шинжилгээгээр дараах түвшинг шалгаж болно:

- Төслөө хэрэгжүүлэхэд хангалттай нөөцтэй (жишээлбэл, санхүүгийн, хүний нөөц, захиргааны, улс төрийн);
- Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд багийн гишүүд зохих үр чадвартай;
- Танд ажлаа хийх шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмж байгаа (жишээлбэл, оффисын талбай, тээврийн хэрэгсэл, компьютер);
- Таны төслийн баг үйл ажиллагаагаа жигд явуулдаг (жишээлбэл, харилцаа, үүрэг хариуцлагыг шилжүүлэх).

Суралцах, үр дүнтэй харилцаатай байхын тулд дүн шинжилгээнд зөв хүмүүсийг татан оролцуулах, эсвэл урьдчилсан дүн шинжилгээг тэдэнтэй хуваалцах нь чухал юм. Дүрмээр бол төслийн багийн гишүүд төслийн талаар болон ерөнхий нөхцөл байдлын талаар илүү ойлголттой тул шинжилгээнд хамрагдах ёстай. Нөхцөл байдлаас шалтгаалан багийн гишүүд өөрсдөө дүн шинжилгээ хийж, эсвэл шинжилгээг хянах, тайлбарлахад тусалж болох юм. Гэхдээ тэд үр дүнд үндэслэлгүйгээр нөлөөлөхгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй. Багийн оролцоо чухал боловч оролцогч талууд, гадны шинжээчид эсвэл өөр өнцгөөс харах хүмүүсийн санал бодол бас үнэ цэнэтэй бөгөөд хяналт шинжилгээний үр дүнг тэнцвэртэй тайлбарлахад тусална.

ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Төслийн үр дүн, таамаглалын дүн шинжилгээ
- ◆ Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийн дүн шинжилгээ
- ◆ Хэлэлцүүлэг, шийдвэрүүдийн баримтжуулалт



4С. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДУУЛАХ

Мониторингийн үйл ажиллагааны нэг хэсэг болох өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийх нь хөндлөнгийн оролцоо хэр үр дүнтэй болох, зорилго, зорилтоо илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд ямар зохицуулалт хийх шаардлагатайг тодорхойлох боломжийг олгодог. Энэ үе шатны төгсгөлийн хэсэг болохын хувьд дүн шинжилгээ, хэлэлцүүлгийн явцад олж мэдсэн зүйлээ өөрийн стратеги, үйл ажиллагааны багцыг шаардлагатай бол өөрчлөх, оновчтой болгоход ашиглах хэрэгтэй. Энэ бол байгаль хамгаалах сайн дадлын мөн чанар юм.

Урьд өмнө төлөвлөж байсан бүх төлөвлөгөө нь дахин ашиглахгүй нэг удаагийн арга хэмжээ биш, харин цаг хугацаа өнгөрөх тусам суралцаж, төслийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд төслийн параметрууд болон үндсэн таамаглал, үйл ажиллагаа-, мониторинг-, ажлын төлөвлөгөө болон төсвийг эргэн харж, шаардлагатай бол тохируулах хэрэгтэй. Иймд сурч мэдсэн зүйлээ тусгахын тулд стратеги төлөвлөгөөний зарим, эсвэл бүх хэсгийг шинэчлэх шаардлагатай болж магадгүй юм. Суралцах, сайжруулах санаа нь төслийн багтай хийсэн хэлэлцүүлэг, албан ёсны үнэлгээ, аудитын үр дүн, төслийн ажилтай танил гадны оролцог талуудын санал хүсэлт, эсвэл төслийн нөхцөл байдалд хамааралтай судалгааны үр дүнгээс үүдэлтэй байж болно.

Өөрчлөлт хийх явцдаа сурч мэдсэн зүйл, яагаад эдгээр өөрчлөлтийг хийснийг ойлгуулахын тулд тэдгээрийн ард баримтжуулж, нотлох баримт бичгийг хавсаргах нь 5-р алхамыг хэрэгжүүлэхэд чухал мэдээлэл болно. Зарим үйл ажиллагаа сайн явагдаж байгаа тул ямар нэгэн тохируулга хийх шаардлагагүй болохыг мөн олж мэднэ. Хамгийн гол нь эргэцүүлэл, дүн шинжилгээнд цаг хугацаа гаргаснаар, хаана дасан зохицох шаардлагатайг ойлгож чадна.

ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, ажлын төлөвлөгөө, төсөв зэргийг багтаасан төслийн шинэчлэн боловсруулсан баримт бичиг
- ◆ Хэлэлцүүлэг, шийдвэрүүдийг баримтжуулах

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэ алхмын талаар нэмэлт мэдээлэл: <https://conservationstandards.org/resources/>

Бодит жишээнүүд: <https://conservationstandards.org/case-studies/>





ХУВААЛЦАХ

ХУВААЛЦАХ

Энэ нь Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын хамгийн сүүлийн алхам бөгөөд төлөвлөлтийн явцад олж мэдсэн сургамж болон боловсруулан гаргасан албан ёсны баримт бичгүүдээ дотоод болон гадны хамтрагч талуудтай хуваалцдаг. Мөн санал сэтгэгдлээ хуваалцах, талуудаас санал зөвлөмж хүлээн авах зэргээр бие биенээсээ суралцах соёл, дадлыг бий болгож дэмждэг үе шат юм. Өмнөх алхмуудаас олж авсан мэдээлэл, сургамж нь төслийн цаашдын бүхий л үйл явцын туршид чухал үүрэг гүйцэтгэдэг учраас суралцах дадлыг төслийн баг дотроо болон хамтрагчид, оролцогч талуудын дунд хэвшиүүлэх нь чухал. Түүнчлэн суралцах, сайжруулах дадлыг байгууллагын түвшинд, байгаль хамгааллын салбар дахь хамтран ажиллагсад, түншүүдийн дунд сурталчлах ч мөн чухал байдаг. Ийм ч учраас Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт нь, төслийн баг болон байгууллагуудыг хуваалцах, бие биенээсээ суралцдаг болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой дадлага ажлуудыг багтаасан байдаг.

5A. Сурсан зүйлсээ баримтжуулах

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг ашиглах явцын туршид багийн гишүүдийн хуримтлуулсан мэдлэг, гол үр дүнг баримтжуулан тэмдэглэж, нотлох баримт бүрдүүлэлтэд хувь нэмэр болгон ашиглах нь зйтэй. Ерөнхийдөө, 2B алхмыг хэрэгжүүлэх явцад мэдээ, мэдээлэл маш их шаардагдаг бөгөөд үүний ачаар 4 дүгээр алхам дээр ирэх үед аль хэдийн маш олон тооны үр дүн, сургамжуул гарсан байдаг. Тиймээс тэдгээрийг тэмдэглэж авч баримтжуулж чадаж байгаа эсхээ нягтлахын зэрэгцээ хариулт тодорхойгүй, байгаа хэрэгцээт мэдээллүүдийг алдалгүй мөшгин тэмдэглэл хөтлөх нь хэрэгтэй. Үүнийг багийн гишүүдийн ажиллах арга барилд нийцүүлэн хийвэл цаашдаа багийн гишүүд, байгууллагад тань төдийгүй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажилладаг бусад мэргэжилтнүүдэд ч нээлттэй, хүртээмжтэй мэдээлэл болон үлдэх юм.

Мэргэжлийн судлаачдын үнэлгээ, санал дүгнэлттэй шинжлэх ухааны өгүүлэл болгон нийтлэх, цахим сүлжээний мэдээллийн санд нэгтгэх эсвэл албан бус гар тэмдэглэл хөтлөн бүртгэх байдаараа мэдээлэл, сургамжийг баримтжуулж авч болно. Ажлын явцад хурмтлуулж буй мэдлэг, сургамжаа хуваалцан, засварлаж, хөтлөх зориулалттай, багийн бүх гишүүдэд нээлттэй байдаг дундын цахим хүснэгт, ажлын файлтай болох зэрэг маш энгийн хялбархан арга ч бас бий. Өдөр тутмын ажил, төлөвлөгөөт цаг хугацаатай ажлуудаас үүдэн энэ аргыг хэрэгжүүлэх нь хүндэрлэлтэй байж болох талтай. Иймд, төслийн баг болон байгууллагын зүгээс, үүнийг хариуцуулах хүний ажлын цаг, урамшууллын тогтолцоог тусгайллан бий болгоход анхаарах нь чухал.

ЭНЭ АЛХМААС ГАРСАН БАЙХ ҮР ДҮН

- ♦ Гол үр дүн ба сургамжийг баримтжуулсан байна.

5B. Сурсанаа хуваалцах

Үйл явцын туршид гаргаж ирсэн нотолгоо, хуримтлуулсан сургамжаа баримтжуулаад авчихвал, өнгөрсөн жилүүдэд хийгдсэн ба хийгдээгүй ажлууд, ирээдүйд хийхээр төлөвлөсөн зүйлс зэргийг сануулсаар байдаг ач холбогдолтой. Энэ нь багийн гишүүдэд урт хугацааны ашиг тус өгөхөөс гадна шинээр орж ирэх гишүүдэд ч бас өнгөрсөнд хийгдсан ажил, түүнээс гарсан сургамжийн талаар мэдээлэлтэй байхад нь тусална. Үүний хамгийн чухал ач холбогдол нь төслийн баг өнгөрсөнд гаргасан алдаагаа дахин давтахаас сэргийлэх явдал юм. Төслийн менежментийн Миради (Miradi) эсвэл Миради Шэйр (Miradi Share) зэрэг програм дээр ажиллаж байгаа бол холбогдох мэдээллийг тохиорох алхам тус бүрээр нь тэмдэглэн оруулж болдог бөгөөд энэ нь цаашид төслийн баримт бичгийн түүхэн мэдээ баримтад нэгтгэх үндэс суурь болно.

Зорилтот талуудад зориулсан албан ёсны мэдээлэл, сурталчилгааны бүтээгдэхүүнүүдээр дамжуулан төслийн хэрэгжилтээс бий болсон мэдлэг, үр дүн дэлхий даяарх мэргэжилтнүүдтэй хуваалцаж болно. Үр дүн, мэдлэгийг баримтжуулан хуваалцсанаар ижил төстэй нөхцөл байдалд адилхан арга хэрэгсэл ашиглан ажиллаж буй олон мэргэжилт нэгт хүмүүс таны түршлагаас суралцан, тулгарч болох бэрхшээлээс зайлсхийх боломжтой болохоос гадна эцэстээ байгаль хамгааллын зорилтууд илүү үр дүнтэй биелэх нь хамгийн чухал билээ.

Нотолгоо, өгөгдлийн санг баяжуулах, шинжлэх ухааны сэтгүүлүүдэд нийтлэл хэвлүүлэх, олж авсан сургамжаа цахим хүудсандaa нийтлэх, нийгмийн сүлжээ ашиглан мэдлэг түгээх, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөний үеэр өөрсдийн түүхийг хуваалцах зэрэгээр төслийн үр дүнг илүү өргөн хүрээнд сурталчлан, танилцуулж болно.

Хэдийгээр мэдээлэл түгээх, сурталчлах арга хэмжээг хамгийн сүүлийн алхам гэж танилцуулдаг ч гэлээ төслийн үр дүнгийн талаархи болон бусад мэдээллийн танилцуулгыг нэлээд эртнээс бэлтгэж байх нь зүйтэй. Жишээ нь, хяналт мониторингийн үр дүнг танилцуулах зорилтот талууд болон тэдний мэдээллийн хэрэгцээ шаардлага нь 2B алхмын явцад тодорхойлогдчихсон байдаг. Мэдээллийг зорилтот талуудад үр дүнтэй хүргэхийн тулд олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх стратегиа ойлгомжтой тодорхой боловсруулсан байх хэрэгтэй. Тэргүүлэх ач холбогдол бүхий талуудын сонирхол, хэрэгцээг харгалзан үзсэний үндсэн дээр ямар төрлийн мэдээлэл, нотолгоо, сургамжийг хэнд хүргэх вэ гэдгээ шийдэх, тэр дундаа хамгийн тохиомжтой арга, хэрэгслийг оролцогч тал тус бүрт тохиуулан сонгох, сурталчилгааны материал, бүтээгдэхүүн боловсруулан тараах, түгээх зэрэг үйл ажиллагаа нь үүнд хамаарна. Тухайлбал, төслийн ажилтнууд болон хамтрагчид зэрэг дотоод харилцагчдад үр дүн, сургамжийн талаархи мэдээллийг тогтмол хуваалцахын тулд и-мэйл/цахим захидал, утас зэрэг ердийн, албан бус харилцааны аргыг ашиглаж болох юм. Төслийн сургамжийг хуваалцахдаа дараах зүйлсийг багтаасан байх нь зүйтэй:

- Дүн шинжилгээнд үндэслэсэн, хариуцсан зохих албан тушаалтанд нь хандсан, ойлгомжтой, тодорхой, менежментийн зөвлөмж
- Зөвлөмжүүдийн үндэслэлийг хамгаалах, мөн төслийн үр дүнг тайлбарлан ойлгуулахад шаардлагатай зарим нарийн мэдээлэл
- Үр дүнд үндэслэсэн бусад боломжит хувилбар ба урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал Хандивлагчид, бусад салбарын мэргэжилтнүүд, олон нийт зэрэг илүү өргөн хүрээний гадаад харилцагч талуудад илүү албан ёсны арга хэрэгсэл, суваг буюу мэдээллийн самбар, тайлан, илтгэл, видео, шинжлэх ухааны өгүүлэл зэргээр дамжуулан төслийн үр дүн, сургамжаас хуваалцаж болно. Мэдээлэл сурталчилгааны бүтээгдэхүүн тус бүр нь хүргэхээр зорьж буй мессеж, санааг ойлгомжтой хүргэж чадаж байгаа эсэх, түүний илүү сайжруулж болох хувилбарууд байгаа эсэсхийг үнэлж үзэх нь чухал.

Дахин хэлэхэд, хяналт мониторинг, суралцах, уялдуулан ажиллах зэрэг үйл ажиллагаа тасралтгүй явагдах байдаг. Байгаль хамгааллын салбарт ажиллаж буй бусад бүхий л оролцогч талууд бол төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл олж авах, суралцах эх үүсвэр гэдгийг мартаж болохгүй. Бусдын туршлагыг судлах нь сургамж олж авах хамгийн сайн эх сурвалж болдог.



ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ♦ Шаардлагатай гэг үзвэл, гол оролцогч талууд болон тэдний мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл харилцааны арга хэлбэрийг сайжруулсан байна
- ♦ Төслийн багийн гишүүд болон гол оролцогч талууд тогтмол харилцаатай байж мэдээлэл солилцож ажиллана
- ♦ Нотлох бармит бүрдүүлэлтэд хувь нэмэр оруулсан байна
- ♦ Тохиромжтой мэдээлэл, сурталчилгааны материал, бүтээгдэхүүнүүд боловсруулан гаргаж түгээсэн байна

5C. Суралцах орчныг дэмжих

Байгаль хамгааллын сайн практик болсон энэхүү хамгийн сүүлийн дэд алхмын хүрээнд ажлын гүйцэтгэл ба түүнээс суралцах соёлыг төслийн баг төдийгүй байгууллага, хамтрагч түншүүдийн дунд, мөн дэлхий дээрхи байгаль хамгааллын төлөө ажиллаж буй бүх хүнд түгзэх, улам сайжруулах үйл ажиллагаанууд багтдаг. Гүйцэтгэл ба харилцан суралцах соёлыг эдгээр янз бүрийн түвшинд нэвтрүүлэх нь бусад хүмүүс танай багийн туршлагаас суралцаж, үр шим хүртэхэд чухал ач холбогдолтой. Суралцах орчныг бүрдүүлэх талаар хамгийн сүүлийн алхмын явцад гарч ирж байгаа боловч эн нь төслийн баг болон байгууллага бүр эхний шатнаас эхлэн хөгжүүлэн авч явах ёстой зүйлийн нэг юм. (Нийтлэг зарчмын тухай хамгийн эхний бүлэгт энэ талаар дурдаж өнгөрсөн) Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд нотолгоонд үндэслэсэн, дасан зохицох менежменттэй төслийн орчинг бий болгон ажиллах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, та болон танай баг, байгууллага тань нэгнийхээ санал бодлыг асууж, харилцан саналаа солилцон, түүнийгээ ажилдаа тусгах дадлыг хэвшил болгох нь зүйтэй. Албан болон албан бус аль ч хэлбэрээр багийн гишүүд болон байгууллагын бусад ажилтнууд саналаа өгч болно. Түүнчлэн, төслийн хэрэгжилт нь тавьсан зорилгодоо нийцэж буй эсэх талаарх хөндлөнгийн үнэлгээ, зохих үйл ажиллагааны стандартын хүрээнд хэрэгжиж буй эсэхэд хяналт хийдэг аудит, мөн өмнөх бүлгүүдэд дурдаж өнгөрсөн бусад төрлийн үйл ажиллагаа зэрэг гадаад механизмуудын зүгээс санал зөвлөмж ирдэг. Суралцах орчныг дэмжихийн тулд гадна харилцагч талуудаас ирж буй санал, зөвлөмжийг нээлттэй хүлээн авах нь чухал, учир нь хийж буй ажлаа огт өөр өнцгөөс, илүү гархай байдлаар харах боломж олгож мэдэх юм.

Суралцах орчныг дэмжих нь амаргүй. Нотолгоонд сууринсан байгаль хамгаалал ба дасан зохицох менежментийн шуурхай арга хэмжээнээс авахуулаад урт хугацааны үйл ажиллагаануудыг хүртэл, боломжит багахан хэмжээний нөөцдөө тохируулан явуулах хэрэгцээ, шаардлагыг үнэнхүү ойлгож үхамсарладаг удирдлага болон донор/ санхүүжүүлэгч заавал байх хэрэгтэй. Суралцах орчныг дэмжих нь байгаль хамгааллын тодорхой нэг арга хэрэгсэл, стратегитэй холбоотой тогтсон хэвшмэл ойлголтод шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах боломжийг салбарын мэргэжилтнүүдэд олгодог. Улмаар шинэлэг санаа, дэвшүүлсэн таамаглалд шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах зарчмыг манай байгууллага эрхэмлэдэг юм байна гэсэн байгууллагын дотоод зарчмыг төслийн багийн гишүүдэд ойлгуулдаг. Түүнчлэн, шударга, нээлттэй хамтын ажиллагаа, практикийг бий болгоё гэвэл өөрсдийн амжилт, дутагдлын аль алиныг нь дэлхий даяарх бүх мэргэжил нэгтгүүдтэйгээ хуваалцаж чадахуйц үнэнч байдлыг шаарддаг. Үүнийг үргэлж санаж явсаннаар Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг ашигладаг, хөгжүүлдэг хэн бүхэн өөрсдийн байгууллага дээрээ энэхүү стандартыг хэрэгжүүлсэн туршлага, бэрхшээл болон амжилтаасаа хуваалцан, харилцан үр ашигтай байх боломжтой юм. Энэ нь, Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартыг хэрхэн өөрийн байгууллагатаа нэвтрүүлж, сайжруулж, хэрэгцээ шаардлагатай нийцүүлэн өөрчлөн авч хэрэглэхэд тус болно.

ЭНЭ АЛХМААС ГАРАХ ҮР ДҮН:

- ◆ Санал сэтгэгдэл хуваалцдаг албан ба албан бус горим бий болсон байна
- ◆ Аудит болон байгаль хамгааллын бусад сайн туршлагыг хэрэгжүүлж буй эсэх үнэлгээ зохих ёсоор хийгдсэн байна
- ◆ Удирдлага болон бусад ажилтнууд нь харилцан суралцах, шинэлэг байдлаар ажиллах итгэл үнэмшилтэй болж бодитоор хэрэгжүүлэн ажилладаг болсон байна
- ◆ Шинэлэг санаа, туршилтыг урамшуулсан орчныг бий болгож, хэвшмэл ойлголтуудыг шүүмжлэлт сэтгэлгээгээр шинжилдэг болсон байна
- ◆ Ололт ба алдаа дутагдлаа салбарын бусад мэргэжилтнүүдтэй хуваалцдаг зарчимтай болсон байна

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Үр дүнг хуваалцах алхмын талаар нэмэлт мэдээлэл: <https://conservationstandards.org/resources/>

Бодит жишээнүүд: <https://conservationstandards.org/case-studies/>



ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛХМУУДЫГ
ЗАНГИДАХ

ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛХМУУДЫГ ЗАНГИДАХ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүй гэдэг нь, төлөвлөлтийн баг өөрсдийн нөхцөл байдалд нь тохиромжтой гэж үзсэн аль ч шатанд орж ажиллаж болдог, мөчлөг, эргэлт бүхий үйл явц болох талаар танилцуулсан билээ. Шинэ төсөл эхлүүлж буй багийн хувьд, төслийн үндсэн стратегийн төлөвлөгөөг ноороглох зорилготой 1 ба 2 дугаар алхмыг харьцангуй хурдан өрнөлтэйгээр (4-5 өдрийн хэлэлцүүлэг г.м) явуулж болдог. Улмаар, 3-дугаар алхам буюу хэрэгжилтийн үйл явцыг эхлүүлэх явцдаа өмнөх алхмуудаа эргэн харж 1 болон 2 дугаар алхмын явцад дутуу орхигдсон нарийн мэдээллүүдээ нөхөж ажиллаж болно. Үүнээс 6-12 долоо хоногийн дараа 4 дүгээр алхмыг хэрэгжүүлэхдээ анхны дүн шинжилгээгээ хийх бөгөөд үүнийгээ 5 дугаар алхмын үед буюу мэдээлэл, сурталчилгааны бүтээгдэхүүн боловсруулахдаа ашигладаг. Гэхдээ, төлөвлөлтийн нэлээн хожуу үе шатанд ч мөн, эдгээр алхмууд руу эргэж орж ажилладаг багууд олон бий. Тухайлбал, өмнө нь хийгдсэн ажлууд төлөвлөсний дагуу хэрэгжиж буй эсэхийг ойлгож, үнэлэхийн тулд “Үр дүнг үнэлэх, төлөвлөгөөг уялдуулах” алхмыг дахин нягтлах гэх зэрэг. Цаг хугацааны явцад, багийн гишүүд өмнөх алхмууд руугаа буцах, тухайн үед гаргаж байсан, таамаглал, шийдвэрээ эргэн харж, улам ойлгомжтой, дэлгэрэнгүй болгохоор ажиллаж болно.

Хамгийн сүүлийн 5 дугаар алхмыг хэрэгжүүлж дууссаны дараа 1 дүгээр алхам руу буцаж буй байдлаар Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын үйл явцыг харуулсан байдаг. Энэ нь төлөвлөлтийн баг дуусашгүй тойргоор ажиллаж байгаа гэсэн агуулгаар бус, харин нотолгоонд тулгуурласан, дасан зохицох менежмент гэдэг нь тасралтгүй суралцаж, цаг хугацааны явцад сайжруулсаар байдаг идэвхитэй үйл явц юм шүү гэдгийг сануулах зорилготой юм. Дараахи асуултад хариулахаар оролдож үзэх нь үүний жишээ болно: “Цугларсан бүх мэдээ өгөгдөл дүн шинжилгээ хийж, шаардлагатай нотолгоо баримтуудаа бүрдүүлсний дараа эргээд харахад, өмнө нь боловсруулан гаргасан алсын хараа болон хамгаалах үнэт зүйлсээ дахин эргэж харах, сайжруулах шаардлага байна уу?”, “Өмнө нь харгалзаж үзээгүй бөгөөд нөхцөл байдлын дун шинжилгээний диаграмм эсвэл тодорхой нэг зорилго, зорилтод тусгах шаардлагатай гэж үзэж буй шинэ төрлийн хүчин зүйл, эсвэл харилцан хамаарал бий болсон уу?”, “Зорилтот талууд эсвэл тэдний мэдээллийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдсөн үү?” Мониторингийн төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай байна уу?”, “Төсөл дуусгавар болгох, түүний үр дүнг нь тогтвортой хадгалахын тулд үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад ямар нэг төлөвлөгөөнд өөрчлөлт хийх шаардлага урган гарч байна уу?” гэх зэрэг. Төлөвлөлтийн алхмуудыг зангидах гэдэг нь төслийн бүхий л үе шатны явцад эдгээр тойрог алхмуудаа дахин дахин эргэн харж, улам сайжруулах эсвэл нэмэлт ажиллагаа, бүтээгдэхүүн шаардлагатай байгаа эсэхийг тодорхойлохыг хэлдэг. Ердийн менежментийн арга барилыг нотолгоонд сууринласан, дасан зохицох менежмент болгон өөрчилж буй гол мөн чанар нь үүнд оршино.

ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ 1. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Зорилго, зорилт, үйл ажиллагаа, хамгаалах үнэт зүйл, үе шат, үйл ажиллагааны үр дүн, хүрэх үр дүн гэх мэт нэр томъёоны талаар байгаль хамгааллын төлөвлөлтийн мэргэжилтнүүдийн дунд эцэс төгсгөлгүй маргаан байсаар байна. Энэ нь байгууллага, төсөл, хувь хүн бүр өөрийн гэсэн нэр томъёоны тайлбар ашиглаж байгаатай холбоотой. Энд зөв хариулт гэж байхгүй бөгөөд танай багийн гишүүд, хамт олон тухайн нэр томъёог ашиглах тодорхой, нэгдсэн ойлголттой байх нь хамгийн чухал. Гэхдээ стандарт толь бичигтэй байхын давуу талууд бас бий. Тиймээс энэхүү гарын авлагад анх удаа хэрэглэж байгаа (доогуур зураас зурж тэмдэглэсэн) болон байнга хэрэглэдэг үгсийг сонгон нэр томъёоны тайлбар орууллаа.

Арга хэмжээ – Байгаль хамгааллын ажилд хамаарах ерөнхий нэр томъёо. Үүнд стратеги, үйл ажиллагаа, даалгавар бүгд хамаарна.

Үйл ажиллагаа – Төслийн ажилтнууд эсвэл түншүүдийн нэг буюу хэд хэдэн зорилгод хүрэхийн тулд хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ, багц даалгавар. Заримдаа арга хэмжээ, хариу арга хэмжээ, стратегийн үйл ажиллагаа гэж ч нэрлэдэг. (Стратегийн тайлбарыг харьцуулан харна уу.)

Дасан зохицох менежмент – Шийдвэр гаргах тодорхой бус байдлыг арилгах зорилгоор сурсан зүйлээ практикт нэвтрүүлэх. Өөрөөр хэлбэл, мэргэжилтнүүд дэвшигүүлж буй гол таамаглалаа системтэйгээр туршаад, үр дүнг нь үнэлэх, менежментийн шийдвэрийг гаргахад ашиглах, суралцах чадварыг бий болгох төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт шинжилгээний нэгдэл юм. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь дасан зохицох менежментийн зарчмуудыг байгаль хамгааллын практикт шууд авч ашигладаг.

Таамаглал – Багийн гишүүдийн үнэн гэж үзэж байгаа тодорхой төлөв байдал. Төслийн стратегийн өөрчлөлтийн онолд тусгагдсан нэг буюу хэд хэдэн зорилттой холбоотой логик дараалал. Таамаглалд гадны хувьсагчдыг хэрхэн хүлээж байгааг харуулсан багийн гишүүдийн төсөөлөл нь үр дүнд хүрэхэд хэрхэн нөлөөлж болохыг илэрхийлж болно (Эрсдлийн хүчин зүйлийн тайлбарын харна уу). Таамаглал нь нөхцөл байдлын дун шинжилгээ дэх нөлөөллөх хүчин зүйл болон бусад хүчин зүйлүүдийн хоорондын хамаарлыг илэрхийлж болно.

Олон нийт – Мэдээлэл харилцааны эсвэл тодорхой нэг зан үйлд нь нөлөөлөх зорилгоор багийн гишүүдийн хүрч ажиллахыг зорьж буй бүлэг хүмүүс эсвэл хувь хүн.

Аудит – Төсөл, хөтөлбөрийг нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, тогтвортой ашиглалтын зарчим эсвэл баримт бичигт

заасан стандарт зэрэг бусад шалгууртай уялдуулан үнэлэх (Үнэлгээний тайлбартай харьцуулан харна уу.)

Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдал – Байгаль хамгааллын үнэт зүйлтэй ижил утгаар хэрэглэнэ.

Туршлагажиж буй хүмүүс – Тулгарч буй асуудал, бэрхшээл, эсвэл сэдэвтэй холбоотой санал, санаачилгаа хуваалцдаг, байнгын харилцаатай байж энэ чиглэлээр мэдлэг, туршлагаа нэмэгдүүлж байдаг дадлагажигчдын бүлэг.

Байгаль хамгааллын хувьд анхаарах зүйл – Байгаль хамгааллын үнэт зүйлтэй ижил утгатай.

Байгаль хамгааллын практик Мэргэжилтнүүд тухайн нөхцөл байдалд хүссэн үр дүнг харилцан тохиролцож тодорхойлоод дараа нь эдгээр үр дүнд хүрэхэд чиглэсэн арга хэмжээ авахыг багтаасан үйл явц юм. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь хамтын ажиллагааны зарчим, нотолгоонд сууринсан байгаль хамгаалал, дасан зохицох менежментийн зарчмыг тусгасан нийтлэг цар хүрээ, багц "шилдэг" туршлагуудаар хангаж өгдөг. Өргөн утгаараа, дэлхий дээрх байгаль хамгааллын байгууллага, мэргэжилтнүүдийн мэдлэгийн багц.

Байгаль хамгааллын үнэт зүйл – Төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдал (зүйл, амьдрах орчин эсвэл экологийн систем). Төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйлүүд нь нийлээд тухайн газар нутгийн биологийн олон янз байдлыг бүрэн төлөөлж чадах ёстой. (Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдал, Байгаль хамгааллын хувьд анхаарах зүйл, Байгаль хамгааллын үнэ цэн гэсэн үргүүдтэй ижил утгатай.)

Байгаль хамгааллын үнэ цэн – Байгаль хамгааллын үнэт зүйлтэй ижил утгатай.

Ноцтой аюул, дарамт – Нэн тэргүүн шийдвэрлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн аюул, дарамт.

Шууд аюул дарамт – Нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлийг доройтуулж буй хүний үйл ажиллагаа (Жишээлбэл, хууль бус мод бэлтгэл, зохисгүй загас агуул). Мөн хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсэн байгалийн хүчин зүйл байж болно (Жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлтөөс болж хүчтэй аадар бороо орох нь ихсэх). Ихэнхдээ нэг буюу хэд хэдэн оролцогч талуудтай холбоотой байдаг. (Зарим тохиолдолд дарамт эсвэл сөрөг үр дагаварыг нөхцөлдүүлэгч хүчин зүйл, эх үүсвэр гэж нэрлэдэг. Шууд бус аюул дарамттай харьцуулан харна уу.)

Нөлөөлөх хүчин зүйл – Шууд бус аюул дарамттай ижил угтатай.

Экосистемийн үйлчилгээ – Хүмүүст ашиг тусаа өгч буй зүйл, амьдрах орчин, экосистемийн үйл ажиллагааны цогц үйлчилгээ.

Таатай нөхцөл – Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх үед тодорхойлогдсон өргөн хүрээний эсвэл өндөр түвшний боломж. Тухайлбал, тухайн улс орны бодлого, хууль эрх зүйн орчин.

Үнэлгээ – Төсөл, хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийн үнэлгээ. (Мониторинг хэсгийг харж, аудиттай харьцуулна уу.)

Нотолгоо – Сонирхол татах буй тухайн асуулттай холбоотой нэг буюу хэд хэдэн таамаглалыг шалгахад ашиглах мэдээлэл (өгөгдөл, судалгаа, дүн шинжилгээний нэгтгэл, онол).

Нотлох баримт – Дэвшүүлсэн таамаглалаа шалгахад ашиглах бүх мэдээ, баримт (өгөгдөл, судалгаа, дүн шинжилгээний нэгтгэл, онол).

Нотолгоонд суурилсан байгаль хамгаалал – Байгаль хамгааллын практикийн бүхий л ѿ шатанд хамаарах мэдээллийг бүрдүүлэх, ил тод ашиглах. Тодруулбал, мэргэжилтнүүд өөрсдийн болон дэлхийн өмнөх туршлагад хоёуланд системтэй дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулдаг. Мэргэжилтнүүд үр дүнгээ баримтжуулж, нотлох баримтын санд буцаагаад нэгтгэдэг. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудад нотолгоонд суурилсан байгаль хамгааллын зарчмуудыг тодорхой тусгасан байдаг.

Хүчин зүйл – Шууд болон шууд бус аюул дарамт, боломж зэрэг нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм дахь элементүүдийн ерөнхий нэр томъёо. Энэхүү ерөнхий нэр томъёог ашиглах нь давуу талтай байдаг – тухайлбал, аялал жуулчлал – энэ нь аюул дарамт бас боломж болдог.

(Үндсэн шалтгаан болон нөлөөлөх хүчин зүйл–ийг харна уу.)

Зорилго – Хамгаалах үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдал зэрэг төслийн хүссэн үр нөлөөг нарийвчилан томъёолсон тодорхойлолт. Зорилго нь тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, үр дүнд суурилсан, хугацаатай гэсэн шалгуурт нийцэж байх ёстой.

Хүний сайн сайхны төлөөх зорилт – Байгаль хамгааллын төслийн хувьд, хүний сайн сайхны төлөөх зорилт нь байгаль хамгааллын үнэт зүйлийн төлөв байдалд нөлөөлсөн хүний сайн сайхан байдлын бүрэлдэхүүн хэсэг юм. Тухайн газар дахь хүний сайн сайхны төлөөх зорилтууд нь байгаль хамгааллын үнэт зүйлээс хамааран хүний сайн сайхан байдлын хэрэгцээг төлөөлж байх ёстой.

Үр нөлөө – Байгаль хамгааллын үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдал. Зорилго нь хүрэхээр төлөвлөж буй үр дүнгийн тодорхойлолт юм.

Шалгуур үзүүлэлт – Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдал, аюул дарамтын өөрчлөлт, зорилгодоо хүрэх явц эсвэл нэг буюу хэд хэдэн хувьсагч хоорондын холбоо зэрэг тодорхой мэдээллийн хэрэгцээтэй холбоотой хэмжигдэхүйц үзүүлэлт. Сайн шалгуур үзүүлэлт нь хэмжигдэхүйц, нарийвчлалтай, тогтвортой, мэдрэг байх гэсэн шалгуурт нийцэж байх ёстой.

Шууд бус аюул дарамт – Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлж гаргасан шууд аюул дарамтыг нөхцөлдүүлж буй хүчин зүйл. Энэ нь ихэнхдээ байгаль хамгаалах арга хэмжээний гол цэг нь байдаг. Жишээлбэл, мод бэлтгэлийн талаарх бодлого эсвэл загасны хэрэгцээ. (Заримдаа үндсэн шалтгаан, суурь шалтгаан гэж нэрлэх тохиолдол бий. Шууд аюул дарамттай харьцуулна уу.)

Хэрэгцээт мэдээлэл – Төслийн баг болон бусад хүмүүсийн төслийн талаар мэдэх ёстой зүйл. Мониторингийн төлөвлөгөө боловсруулах үндэс суурь.

Завсарын үр дүн – Эцсийн зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцад гарсан тодорхой үр дүн (“завсарын” гэдэг нь цаг хугацааны хэмжигдэхүүн юм).

Цогц арга хэмжээ – Тодорхой нэг эсвэл зорилтот стратеги-тэй ижил утгаар хэрэглэнэ.

Чухал хүчин зүйл – Хамгаалах үнэт зүйлийн биологи, экологийн шинж чанарууд. Хэрэв байгаа бол хамгаалах үнэт зүйлийн эрүүл байгааг тодорхойлж, хэрэв алга болсон эсвэл өөрчлөгдсөн бол цаг хугацааны явцад тухайн хамгаалах үнэт зүйлийг шууд алдах эсвэл эрс доройтуулахад хүргэх болно. (Экологийн чухал хүчин зүйл ч гэж нэрлэдэг).

Экологийн чухал хүчин зүйл – Чухал хүчин зүйл-тэй ижил утгатай.

Гол арга хэмжээ – Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд тусгагсан багийн гишүүдийн зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тэргүүлэх хүчин зүйл (аюул дарамт, боломж, хамгаалах үнэт зүйлс).

Суралцах – Мэдээллийн хэрэгцээг хангах үйл явц.

Үйл ажиллагааны хүрээ – Төслийн зорилго, зорилт, шалгур үзүүлэлтийг хүснэгт хэлбэрт оруулж төслийн логик үялдаа харуулах зорилгоор гаргасан логик хүрээний шинжилгээний үр дүнд бий болсон матриц.

Мониторинг – Төслийн зорилго, зорилтод хамааралтай өгөгдлийг үе шаттайгаар цуглуулах, үнэлэх. (Мониторинг үнэлгээ эсвэл мониторинг, үнэлгээ, суралцах гэж нэрлэж болно.)

Мониторингийн төлөвлөгөө – Төслийн явц, үр дүнг хянах төлөвлөгөө. Энэ нь хэрэгцээт мэдээллийн төрөл, шалгур үзүүлэлт, арга зүй, цаг хугацаа, өгөгдөл цуглуулах хариуцах эзэн түүний үүрэг хариуцлага гэсэн хэсгээс бүрдэнэ.

Арга зүй – Шалгур үзүүлэлтийг хэмжихийн тулд өгөгдөл цуглуулахад ашигладаг тодорхой арга барил. Сайн арга зүй нь үнэн зөв, найдвартай, зардал багатай, хэрэглэх боломжтой, тохиromжтой байх гэсэн шалгуурыг хангах ёстой.

Зорилт – Аюул дарамтыг бууруулах төслийн хүрэх үр дүнг томъёолсон тодорхойлолт. Сайн зорилт нь тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, үр дүнд сууринсан, хугацаатай гэсэн шалгуурт нийцэж байх ёстой. Хэрэв төсөл нь сайн төлөвлөгдсөн бол төслийн зорилтыг хэрэгжүүлснээр төслийн зорилго, эцэст нь түүний алсын харааг хэрэгжүүлэхд хүргэх учиртай. Алсын хараа, зорилготой харьцуулна уу.

Гүйцэтгэлийн төлөвлөгөө – Шаардлагатай санхүүжилт, хүний нөөц чадавхи, үр чадвар, санхүүгийн бус бусад шаардлагатай нөөцийн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ, эрсдлийг бууруулах арга хэмжээ, төслийн хэрэгжих хугацаа, төсөл дуусахад хэрэгжүүлэх стратегийг багтаасан төлөвлөгөө юм.

Боломж – Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлогдсон шууд ба дам байдлаар нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлд эерэгээр нөлөөлж болзошгүй хүчин зүйл. Ихэндээ байгаль хамгаалах үйл ажиллагааны эхлэлийг тавих гол цэг - жишигэлбэл, тогтвортой арга замаар бэлтгэгдсэн модны эрэлт.(Зарим утгаараа аюул дарамтын эсрэг хүчин зүйл.)

Хүрэх үр дүн – Аюул дарамт эсвэл боломжит хүчин зүйлийн ирээдүйн төлөв байдал. Зорилт нь хүссэн үр дүнг илэрхийлж буй албан ёсны тодорхойлолт юм. (Үр дүн-тэй ижил утгаар хэрэглэнэ.)

Хэрэгжүүлэгч талууд – Байгаль хамгааллын төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, зохион байгуулалт, мониторингид оролцож байгаа бүх хүмүүс.

Дарамт – Шууд аюул дарамт-тай ижил утгаар хэрэглэнэ.

Анхдагч ашиг сонирхол – Оролцогч талууд юуг илүү их анхаарч, үнэлж үздэг вэ. Энэ нь оролцогч талуудын төрлөөс хамаарах ба нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм дахь хамгаалах үнэт зүйл эсвэл нөлөөлөгч хүчин зүйл (шууд бус аюул дарамт ба боломж) байж болно.

Хөтөлбөр – Нийтлэг, өргөн цар хүрээтэй алсын хараа, зорилгод хамтдаа хүрэхээр зорьж буй төслүүдийн нэгдэл. Хялбаршуулах үүднээс энэхүү гарын авлагад нь төсөл, хөтөлбөрийг хөүуланг нь төлөөлүүлэн "төсөл" гэсэн нэр томъёоны дор ашигласан бөгөөд байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь хоёуланд нь адил тэгш үйлчлэх буюу ашиглаж болохоор хийгдсэн байдаг.

Төсөл – Дэвшүүлсэн зорилго, зорилтодоо хүрэхийн тулд менежер, судлаачид, нутгийн иргэд, болон бусад оролцогч талуудын хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж буй багц үйл ажиллагаа. Энэ нь байгаль хамгааллын ажлын үндсэн нэгж юм. (Хөтөлбөр- тэй харьцуулна уу)

Төсөл хэрэгжих газар – Төслийн сонирхож буй биологийн олон янз байдлын оршин буй газар. Энэ нь эко бус нутгийн үнэлгээгээр тодорхойлогдсон нэг буюу хэд хэдэн хамгаалалтын бус эсвэл биологийн олон янз байдлын хувьд ач холбогдолтой газрыг багтааж болно. Зарим тохиолдолд төслийн үйл ажиллагаа нь сонгосон талбайгаас гадуур явагдаж болохыг анхаарна уу.

Төслийн баг – Төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий мэргэжилтнүүдээс бүрдсэн баг. Энэ багт менежер, судлаачид, туслах ажилтнууд болон бусад гол хэрэгжүүлэгчид эсвэл оролцогч талуудыг оруулж болно.

Үр дүн – Хамгаалах үнэт зүйл болон нөлөөлөгч хүчин зүйлийн ирээдүйн төлөв байдал. Үр дүн нь үр нөлөө/дагавар болон хүрэх үр дүнг багтаах ба үр нөлөө/дагавар нь хамгаалах үнэт зүйлтэй, хүрэх үр дүн нь аюул дарамт боломжтой шууд холбогдсон байдаг.

Үр дүнгийн хэлжээ – Өөрчлөлтийн онолыг хялбаршуулан харуулсан диаграмм. Үр дүнгийн хэлжээ нь таамаглал, төслийн стратегийг нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлтэй холбосон логик дарааллыг харуулдаг. Шинжлэх ухааны хэллэгээр энэ нь таамаглал болон хүсэн хүлээж буй өөрчлөлт хоорондын хамаарлыг гаргаж ирдэг.

Эрсдлийн хүчин зүйл – Төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хүсэж байвч хүндэрэл учруулж болзошгүй нөхцөл байдал. Ихэнх тохиолдолд төсөлт нь шууд хянадаггүй. Алуурчин эрсдэл гэдэг нь даван туулахгүй бол төслийн зорилго, зорилтын хэрэгжилтийг бүрэн зогсоо эрсдэл юм.

Үндсэн шалтгаан – Шууд бус аюул дарамт-тай ижил утгаар хэрэглэнэ.

Хамрах хүрээ – Төсөлт хэрэгжих газар нутаг, гол анхаарах агуулгын цар хүрээ.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ – Төслийн баг тухайн төслийн нөхцөл байдлын талаархи ерөнхий ойлголтыг олж авахад туслах үйл явц – үүнд хамгаалахыг хүсч буй байгаль хамгааллын үнэт зүйлд нөлөөлж байгаа засаглалын систем, оролцогч талууд болон улс төр, нийгэм-эдийн засаг, байгаль орчны нөхцөл байдал, тэдгээрийн хоорондоо холбоо хамаарал орно. Төслийн цар хүрээ, нөөц боломжоос хамааран нөхцөл байдлын дүн шинжилгээг одоо бэлэн байгаа баримт нотолгоонд суурилхаас гадна тухайн газар, хамаарах асуудлыг судлах эсвэл тухайн газар, асуудлыг сайн мэддэг хүмүүсийг оролцуулан тэдний мэдлэг, мэдээлэлд үндэслэн хийж болно.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаргамм – Нөхцөл байдлын дүн шинжилгээг харуулсан диаграмм. Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм нь нэг эсвэл хэд хэдэн байгаль хамгааллын үнэт зүйлд нөлөөлж эсвэл нөлөө үзүүлж болзошгүй хэмээн тодорхойлогдсон хүчин зүйл хоорондын хамаарлыг харуулдаг. Диаграмм нь хамгаалах үнэт зүйл, аюул дарамт, боломж, оролцогч талууд болон голлох үйл ажиллагааны оролтыг холбож өгсөн байх ёстой. (See also conceptual model.)

Оролцогч тал – Төсөлт хэрэгжих газарт байгалийн нөөц баялагийг ашиглах сонирхолтой эсвэл түүнд нөлөөлж болзошгүй, мөн төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй, нөхцөл байдал өөрчлөгддөх эсвэл өөрчлөгдөхгүй байх аль ч тохиолдолд ямар нэгэн олж авах, алдах зүйлтэй аливаа хувь хүн, бүлэг, байгууллага. Оролцогч талууд нь төслийн зорилгын хэрэгжилтийг анхаарч үздэг, оролцоо, дэмжлэг нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бүх хүмүүс юм.

Стратегийн төлөвлөгөө – Төслийн ерөнхий төлөвлөгөө. Стратегийн төлөвлөгөө нь төслийн хамрах хүрээ, алсын хараа, хамгаалах үнэт зүйлс, нөхцөл байдлын дүн шинжилгээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

Стратеги – Гол арга хэмжээг чиглүүлэн, боломжуудыг оновчтой ашиглаж, хязгаарлалтыг тооцон тодорхой зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн нийтлэг, төвлөрсөн үйл ажиллагааны багц. Стратеги нь

хамааралтай, төвлөрсөн, хэрэгжих боломжтой, тохиромжтой гэсэн шалгуурыг хангасан байх ёстой (Цогц үйл ажиллагаа-г үзнэ үү.)

Сөрөг үр дагавар – Хүний үйл ажиллагаанаас шууд ба дам байдлаар байгаль хамгааллын үнэт зүйлийн төлөв байдал буурсан эсвэл муудсан байх нөхцөл. Жишээлбэл, амьтны тоо толгойн бууралт, гол мөрний урсац багасах, тунамал ихсэх буюу бохирдох, газрын доорхи усны түвшин буурсан. Ерөнхийдөө амьдрах чадварыг илэрхийлэх гол хүчин зүйлийн доройтол(жишээлбэл, амьдрах орчны хомсдол)-тай ижил утгатай.

Хамгаалах үнэт зүйл – Байгаль хамгааллын үнэт зүйлийн товчилсон хувилбар.

Зорилтот бүлэг – Төслийн зүгээс нөлөөлөхийг зорьж буй тодорхой бүлэг хүмүүс. Зорилтот бүлэг нь шууд аюул дарамтыг үүсгэх эсвэл түүнд хувь нэмэр оруулдаг хүмүүс байж болно (жишээлбэл, хууль бус загасчид, фермер, бодлого боловсруулагчид). Эсвэл төслийг дэмжих хувь нэмэр оруулж буй хүмүүс байж болно (жишээлбэл, түншүүд, хандивлагчид, олон нийт).

Даалгавар – Үйл ажиллагаа, мониторингийн төлөвлөгөө, эсвэл стратегийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой арга хэмжээ.

Өөрчлөлтийн онол –Хүний сайн сайхны төлөөх зорилт, байгаль хамгааллын урт хугацааны зорилго, түүнд хүрэх завсарын үр дүнд хүрэхэд нь тусална хэмээн төсөөлж буй уялдаа холбоо бүхий хэд хэдэн таамаглал. Таамаглалыг багийн гишигдүүд шалтгаан дээр үндэслэн дэвшүүлдэг. Өөрчлөлтийн онолыг текст, диаграмм (жишээлбэл, үр дүнгийн хэлхээ) эсвэл бусад хэлбэрээр илэрхийлж болно.

Аюул дарамт – Нэг ба хэд хэдэн хамгаалах үнэт зүйлд шууд ба дам байдлаар нөлөөлж тэдгээрийг доройтулахад хүргэж буй хүний үйл ажиллагаа. Ихэнхдээ нэг буюу хэд хэдэн оролцогч талуудтай холбоотой байдаг.(Шууд аюул дарамт, шууд бус аюул дарамт хэсгийг харна уу.)

Алсын хараа – Төслийг хэрэгжүүлсэнээр хүрэхээр зорьж буй ирээдүйн төлөв буюу эцсийн нөхцөл байдал. Алсын хараа нь тухайн газар нутгийн биологийн олон янз байдлын нөхцөл байдал болон газрын зураг, алсын харааг товч томъёолсон тодорхойлолтыг агуулсан байж болно.

Ажлын төлөвлөгөө – Үйл ажиллагааг хэрэгжүүлэх богино хугацааны ажлын хуваары/төлөвлөгөө ба мониторингийн төлөвлөгөө. Ажлын төлөвлөгөө нь ихэвчлэн хийх шаардлагатай ажлын жагсаалт, даалгавар, хариуцах эзэн, үйл ажиллагаа эсвэл даалгаврыг хэрэгжүүлэх цаг хугацааг багтаасан байдаг. Мөн ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгө, нөөцийг тусгасан байдаг.

ХАВСРАЛТ 2. ГОЛЛОХ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР, ШАЛГУУР

Алсын хараа: Төслийн ирээдүйн хүссэн төлөв буюу эцсийн нөхцөл байдлыг илэрхийлсэн ерөнхий тодорхойлолт

- **Харьцаангуй ерөнхий** – Төслийн бүхий л үйл ажиллагааг хамран өргөн хүрээнд тодорхойлсон байх
- **Алсын хараатай** – Хамгаалах үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдлын өөрчлөлт нь итгэл найдвэр төрүүлэхүйц байх
- **Төвч** – Төслийн бүх оролцогчид санаж байхаар энгийн бөгөөд төвч байх

Зорилго: Хамгаалахаар сонгосон үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдал буюу төслийн үр нөлөөг нарийвчилан томъёолсон тодорхойлолт

Зорилт: Төслийн заварын үр дүнг нарийвчилан томъёолсон тодорхойлолт

Зорилго, зорилтууд нь дараах шалгуурт нийцсэн байх ёстой:

- **Тодорхой** – Төсөлд оролцогч бүх хүн дэвшүүлж буй зорилго, зорилт нь яг юу гэсэн утгыг илэрхийлж байгаа талаар ижил түвшиний ойлголт авахуйц тодорхой томъёолсон байх
- **Хэмжигдэхүйц** – Зарим стандарт хэмжигдэхүүнээр тодорхойлогдсон байх (тоо хэмжээ, хувь, эсвэл төлөв байдал)
- **Хэрэгжихүйц** – Төсөл хэрэгжих газрын онцлогт тохирсон, улс төр, нийгэм, санхүүгийн нөхцөл байдалд нийцсэн байх (энэ нь ялангуяа дэвшүүлж буй зорилтод хамаарах ба зорилго нь илүү их хүсэл эрмэлзэлтэй байж болно)
- **Үр дүнд сууринсан** – Зорилтот хүрэх түвшин, аюул дарамтын буураалт болон бусад хүлээгдэж буй гол үр дүнгийн өөрчлөлтийг илэрхийлсэн байх
- **Цаг хугацаатай** – Тодорхой хугацааны дотор хүрэх боломжтой байх. Ерөнхийдөө, зорилгоо 10-20, зорилтоо 1-10 жилийн дотор хүрэхээр тооцож төлөвлөлдөг

Стратеги: Гол арга зам, боломж, хязгаарлагч хүчин зүйлийг харгалзан, дэвшүүлсэн зорилго, зорилтод хүргэх нийтлэг зүйлд төвлөрсөн багц үйл ажиллагаа

- **Холбоо хамааралтай** – Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлогдсон нэг эсвэл хэд хэдэн чухал хүчин зүйлд шууд нөлөөлдөг байх

- **Төвлөрсөн** – Гүйцэтгэх шаардлагатай үйл ажиллагааны гол чиглэлийг тодорхойлсон байх
- **Хэрэгжихүйц** – Төслийн нөөц боломж, хязгаарлалтыг харгалзсан ба хэрэгжих боломжтой байх
- **Тохиромжтой** – Тухайн газар нутгийн соёл, нийгэм, биологийн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч нийцүүлсэн байх (төслийн үйл ажиллагаанаас нийгэм, хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй эрдэл, аюулгүй байдлыг анхаарсан байх)

Шалгүүр үзүүлэлт: Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдал, аюул дарамтын өөрчлөлт, зорилгодоо хүрэх явц эсвэл нэг буюу хэд хэдэн хувьсагч хоорондын холбоо зэрэг тодорхой мэдээллийн хэрэгцээтэй холбоотой хэмжигдэхүйц үзүүлэлт

- **Хэмжигдэхүйц** – Тоо болон чанарын үзүүлэлтийг тэмдэглэж, түүнд дүн шинжилгээ хийх боломжтой байх
- **Тодорхой** – Бүх хүн ижил арга замаар тодорхойлох боломжтой байх
- **Тогтвортай** – Цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөхгүй бөгөөд ингэснээр ижил зүйлийг тогтмол хэмжих боломжтой байх
- **Мэдрэг** – Орчны нөхцөл байдлын бодит өөрчлөлтийн хариуд пропорциональ байдлаар өөрчлөгддөг байх

Арга зүй: Шалгүүр үзүүлэлтийг хэмжихийн тулд өгөгдөл цуглуулахад ашигладаг тодорхой нэг арга барил

- **Үнэн зөв** – Өгөгдөл цуглуулах арга зүй нь алдаа бага эсвэл огт алдаагүй байх
- **Найдвартай** – Үр дүн нь тогтмол давтагдах боломжтой - аргыг ашиглах бүрт ижил үр дүн гардаг байх
- **Зардал багатай** – Арга зүй нь өгөгдөл цуглуулах, боловсруулахад хэм их зардал шаарддаггүй, төслийн төсвийн нөөц боломжид нийцсэн байх
- **Хэрэгжихүйц** – Арга зүйг төслийн багийн гишүүд ч ашиглах боломжтой байх
- **Тохиромжтой** - Тухайн газар нутгийн соёл, нийгэм, биологийн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч нийцүүлсэн байх

ХАВСРАЛТ 3. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, АНХААРАХ АСУУДАЛ

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын бүх үе шатанд хамааралтай зайлшгүй анхаарах шаардлагатай зарчмууд байдаг. Тэдгээрийг энд нэгтгэн тайлбарлав.

Ерөнхий зарчмууд

- **Түншүүдтэйгээ хамтран ажиллах – Байгаль хамгааллын нэг байгууллага төслийн шаардлагатай бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод нөөц боломж, туршлага хангалтгүй, хязгаарлагдмал байж болох юм. Түүнчлэн, төсөл дууссаны дараа төслийн явцад эхлүүлсэн ажлыг үргэлжлүүлэн хийх нь бас чухал. Тиймээс, төслийн багт тунш байгууллагуудаас төлөөлөл сонгон ажиллуулах, эсвэл эдгээр байгууллагуудтай албан ба албан бус харилцаа холбоо тогтоох байдлаар төслийг хэрэгжүүлэхэд оролцогч гол түншүүдийг тодорхойлон хамтран ажиллах хэрэгтэй. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт нь түншүүдийн хооронд үр дүнтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжийг олгох нийтлэг, ил тод байх цар хүрээг тодорхой зааж өгдөг.**
- **Талуудыг оролцуулах – Төслийн нөхцөл байдалд нийцсэн оролцогч талуудыг тодорхойлж, төлөвлөлтийн алхам бүрт оролцуулж байх нь мөн чухал байдаг. Төслийн үйл ажиллагаанд оролцох сонирхолтой, үйл ажиллагаа, үр дүнд нөлөөлөх, эсвэл нөлөөлж болзошгүй, шаардлагатай нотлох баримт гаргаж өгөх боломжтой хувь хүн, бүлэг, эсвэл байгууллагууд оролцогч тал болно. Түүнчлэн, төслийн багийн үндсэн гишүүдээс гадна төслийн зүгээс мэдлэг хандлагад нь нөлөөлөхийг хүсч буй, эсвэл төслөөс дэмжлэг авах шаардлагатай, багийн ажлыг эсэргүүцэж болзошгүй, төслийн стратегид нөлөөлж болзошгүй хүмүүсийг оруулж болно. Түүнээс гадна төслийн стратеги, эсвэл санхүүгийн эх үүсвэрт нөлөөлж чадах гол шийдвэр гаргагчид байж болно. Төслийн явцад оролцогч талуудын үүрэг өөрчлөгдөж магадгүй. Төслийн баг нь оролцогч талуудын төлөөллийн оролцоог хангахын тулд төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад холбогдох оролцогч талуудтай харилцаж, оролцуулж байх ёстой. (Оролцогч талуудын дүн шинжилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 1D алхамаас үзнэ үү). Талуудыг оролцуулах арга хэлбэр нь оролцогч талуудын онцлогоос хамаарч өөр өөр байх боловч орон зайн зураглал, нарийвчилсан дүн шинжилгээ хийх, хяналтын тайлан гаргах, видео бичлэг, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах зэрэг байж болно.**
- **Нотлох баримт бүрдүүлж зохих ёсоор ашиглах – Төслийн нөхцөл байдал, үйл ажиллагаатай холбоотой гол асуултад хариулахын тулд боломж байвал орон нутгийн болон дэлхийн хэмжээнд байгаа бүх нотолгоог ашиглах хэрэгтэй. Энэ нотолгоо нь тодорхой зүйл амьтны төллөдөг чухал газрын талаархи нутгийн уугуул иргэдийн мэдлэг, мэдээллээс авахуулад төлөвлөж буй байгаль хамгаалах үйл ажиллагааны үр дүнгийн талаархи дэлхийн хэмжээний системчилсэн тойм мэдээлэл хүртэл байж болно. Төслийнхөө талаар илүү их зүйлийг мэдэж авсанаар та өөрөө бусад хүмүүст нотолгоогоо хуваалцаж, үр шимийг хүртээхэд хувь нэмэр оруулах хэрэгтэй ([Дэлгэрэнгүй мэдээллийг СМР-ийн Байгаль хамгааллын практикт нотлох баримтыг бүрдүүлэх, ашиглах заавраас үзнэ үү](#)).**
- **Тодорхойгүй эсвэл гэнэтийн ямар нэгэн асуудал тулгарвал дасан зохицох менежментийн зарчмыг ашиглах – Хэдийгээр та бүхэн нөхцөл байдлын дүн шинжилгээ, бодит нотолгоонд үндэслэсэн үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэхийг хүсч байгаа боловч ихэнх тохиолдолд хангалттай мэдээлэлгүйгээр ямар нэгэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай тулгардаг. Энэ тохиолдолд, та бүхэн тухайн асуудлын хүрээнд эхлээд таамаглал дэвшүүлэх нь чухал бөгөөд дараа нь тэдгээрийг шалгахад шаардлагатай мэдээллийг системтэйгээр (гэхдээ үр дүнтэй байх) цуглүүлж, үнэлэх замаар дасан зохицож, суралцах боломжтой.**
- **Шийдвэрээ баримтжуулах – Нотолгоонд сууринсан байгаль хамгаалал болон дасан зохицох менежментийн аль алиных нь гол зарчим бол алхам тутамд гаргасан шийдвэр түүний үндэслэл, нотолгоог зохих ёсоор баримтжуулж байх явдал юм. Баримт нь ягаад энэ ажил хийсэн, бас хийгээгүйд дүн шинжилгээ хийхэд тусалдаг төдийгүй бусад хүмүүс таны шийдвэрийн үндэслэл, уялдаа холбоог ойлгож, шалгаж, дүгнэлт өгөх үндэс суурь болдог. Шийдвэрийг баримтжуулж, таамаглалаа нотлох**

баримт бүрдүүлж өгөх нь ажлын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлдэг. Та бүхэн бүх нарийн ширийн зүйлийг бүгдийг баримтжуулахад их цаг зарцуулахыг хүсэхгүй байгаа. Гэхдээ, ерөнхий зарчмын хувьд танай хамт олны ажлыг зохих ёсоор үнэлэх, суралцах, бусадтай хуваалцахад туслах хамгийн бага тооны баримт бүрдүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Суралцах орчныг дэмжих – Нотолгоонд сууринсан байгаль хамгаалал ба дасан зохицох менежментийн аль алиных нь бас нэг гол зарчим бол үр дүнгээсээ суралцах явдал бөгөөд ингэснээр та болон танай баг цаг хугацаа өнгөрөх тусам илүү хөгжиж байдаг. Энэ зорилгын үүднээс сурч мэдсэн зүйлээ ойлгон, алдаа оногоо хүлээн зөвшөөрч, амжилттаа тодорхойлж, яагаад зарим нь амжилттай болж, зарим нь амжилтад хүрээгүйг ойлгохын тулд ажиллах нь нэн чухал юм. Суралцахуйг эрхэмлэдэг төсөл, байгууллагын соёл нь аюулгүй сургалтын орчинг бүрдүүлэхэд тусалдаг. Энэхүү соёлыг бий болгохын тулд төсөлд оролцогч бүх түвшний түнш байгууллагуудаас хичээл зүтгэл, тууштай байдал шаардагдана.

Анхаарах асуудлууд

Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудыг хэрэгжүүлэхдээ дараах зүйлүүдийг анхаарна уу.

- **Эдгээр стандартууд нь тодорхой орон зай, цаг хугацаанд хэрэгжих төслүүдэд хамаарна** - Төслүүд нь жижиг хэмжээний газарт хэрэгжүүлэх менежментээс авахуулаад томоохон хэмжээний эко бүс нутаг, ландшафт эсвэл коридор нутаг зэрэг янз бүрийн хэмжээтэй газарт хэрэгжиж байж болно. Эдгээр нь томоохон үр дүнд хүрэхийн тулд жижиг газруудыг нэгэн зэрэг удирдах ажлыг хамарч болно. Хугацааны хувьд хэдэн өдрөөс эхлүүлээд хэдэн арван жилээр ч үргэлжилэхээр байж болно. Үүний нэгэн адил, агуулгын хувьд илүү сэдэвчилсэн шинжтэй байж болно. Жишээлбэл, бодлогод сууринсан аюул дарамтыг бууруулах эсвэл тодорхой нэг төрөл зүйлд чиглэсэн санаачлагууд гэх мэт. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь дээрх бүх нөхцөлд хамааралтай бөгөөд ашиглах боломжтой. Үүнээс гадна, эдгээрийг санхүүжилтийн хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн зорилго, тэтгэлэг хоорондын хамаарлыг тодруулахад бас ашиглаж болно.
- **Эдгээр стандартууд цаг хугацааны явцад өөрчлөгдөх болно** - Эдгээр стандартууд нь байгаль орчныг хэрхэн үр дүнтэй хамгаалах талаархи сүүлийн уг байхаар бичигдээгүй. Тэдгээр нь байгаль хамгааллын ажлыг янз бүрийн нөхцөлд сайн хийж гүйцэтгэхэд шаардлагатай зүйлсийн талаархи мэргэн


arga ухааныг олж авах зорилготой юм. Иймээс SMP нь олон талуудын оролцоотойгоор байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудыг тухайн газар дээр нь хэрэгжүүлж, туршиж үзээд юу нь болдог, юу нь болдоггүй талаар мэдлэгээ нэмэгдүүлсний үндсэн дээр үе шаттайгаар сайжруулах ажлыг хийдэг. Ирээдүйн өөрчлөлт, шинэчлэлд оролцохын тулд CMPIinfo@conservationmeasures.org хаягаар имэйл илгээнэ үү.

- **Эдгээр стандартууд нь “хамгийн тохиромжтой байдал”-г илрэхийлдэг** - Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь төслийн дизайн буюу төлөвлөлт, менежмент, хяналт шинжилгээний сайн туршлагуудыг багтаасан цогц ойлголтыг өгөхийг зорьж байна. Янз бүрийн шалтгааны улмаас байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудын бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг хэрэглэх боломжгүй байж болохыг хүлээн зөвшөөрөх нь чухал. Гэхдээ хамгийн чухал зүйл бол тэдгээрийг системтэй, логик дараалалтайгаар ашиглах явдал юм. Жишээлбэл, та хамгаалах үнэт зүйлээ сонгохоосоо (Алхам 1B) өмнө шалгуур үзүүлэлтээ (2B алхам) тодорхойлох ёсгүй. Үүний нэгэн адил, хэрэв та тодорхой нэг бүрэлдэхүүн хэсгийг хэрэглэх боломжгүй бол энэ нь таны бусад ажилд хэрхэн нөлөөлөх талаар тодорхой ойлголттой байх ёстой.
- **Зарим тэргүүлэх чиглэлүүдийг аль хэдийн тодорхойлсон** - Хаана ажиллахаа сонгох, эсвэл илүү өргөн сэдвийг хөндөх зэрэг нь ихэвчлэн төслийн төлөвлөлтийн үйл явцаас тусдаа арай өндөр түвшинд шийдэгдсэн байдаг. Эдгээр стандартууд нь та эсвэл танай байгууллага танай баг хаана, ямар асуудлаар ажиллахыг тодорхойлохын (ойролцоогоор)тулд зарим тэргүүлэх чиглэлийг тогтоох дасгал хийсэн байх гэж үздэг. Байгаль хамгааллын стандартуудыг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдлэг нь ирээдүйн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох дасгал болох боломжтой.
- **Цөөн төсөл төлөвлөлтийнхөө эхний үеэс Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудыг хэрэгжүүлж эхлэх болно** - Хэрэв та шинэ төсөл санаачилах талаар дөнгөж бодож эхэлж байгаа бол байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд таныг эхнээс нь арга барилаа цогцоор нь хараад туслах болно. Гэсэн хэдий ч байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартын ашиг тус хүртэх боломжтой олон төслүүд аль хэдийнэ хэрэгжиж эхлээд байна. Эдгээр стандартуудыг та хэрэгжиж эхэлсэн төсөл дээрээ ашигласан нөхцөлд төслийн хувьд таны анхаарч шийдэх шаардлагатай асуудал буюу орхигдлыг тодорхойлж, төслийг сайжруулахад туслах болно.

- Төсөл бүр өөр байдаг учраас байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудыг ашиглахдаа**
тохируулах шаардлагатай – Төслийн багийн гишүүд тухайн нөхцөл байдалдаа тохируулан өөрчлөх, өөрчлөхөд шаардлагатай уян хатан байдлыг хангахын тулд бид байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудыг ерөнхий байдлаар бичсэн. Энд тодорхойлсон алхамууд нь ерөнхийдөө байгаль хамгааллын төслүүдэд хамаатай боловч баг тус бүр төслийнхөө нарийн төвөгтэй байдал, хөрөнгө оруулалтын нөхцөл байдалдаа тохируулан илүү нарийн түвшинд орж ажиллах ёстой. Түүнчлэн, төслийн зарим багууд тодорхой алхамууд нь тэдэнд тохирохгүй байгааг олж мэдээд өдгээр алхамуудыг уялдуулан өөрчлөх шаардлагатай болж магадгүй юм.
- Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь байгаль хамгааллыг гол зорилгоо болгон анхаардаг боловч зохицуулах боломжтой** - Эдгээр стандартуудыг биологийн олон янз байдал болон байгалийн нөөцийг хамгаалах зорилго бүхий байгууллага, агентлагуудад зориулж боловсруулсан. Олон баг хүний сайн сайхны төлөөх байдалд хувь нэмрээ оруулахаар ажиллаж байгаа ч, зарим тохиолдолд хүний сайн сайхны төлөөх зорилтууд нь ижил бөгөөд хамгийн дээд зорилго болдог. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь багийн үндсэн зорилгын хувьд төвийг сахисан байр суурьтай байдаг. Энэ нь менежментийн шийдвэр бөгөөд багийн гишүүд төлөвлөлтийн үйл явцын эхний алхамд тодруулах шаардлагатай. Гэсэн хэдий ч байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартуудын хэд хэдэн үйл явц, арга хэрэгслүүд нь төслийн туршид өөр өөр зорилгуудыг тэргүүлэх байдлаар нь эрэмбэлэх, боломжит тохиролцоо хийх хэлэлцүүлгийг дэмжиж өгдөг.
- Эдгээр стандартуудыг янз бүрийн арга хэрэгсэл, зааварчилгаатай хослуулан ашиглах байдлаар хэрэгжүүлж болно** - Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь байгаль хамгаалах төслүүдийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг хянах үйл явцын талаар байгаль

хамгааллын мэргэжилтнүүдийн хуримтлуулсан мэдлэгт сууринсан орчин үеийн арга технологийг илрхийлэхийн зэрэгцээ сурталчилах зорилготой. Тэд байгалийг хэрхэн хамгаалах талаар зааварчилгаа өгдөг. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд нь хэрэгжүүлэхэд тустай болох нь батлагдсан тодорхой хэрэгслүүдийг багтаасан байдаг. Гэсэн хэдий ч багууд байгаль хамгааллын төлөвлөлтийн энгийн стандартуудыг бусад нөхцөл байдалд тохирсон хэрэгслүүдээр (жишээ нь: spatial prioritization tools, such as MARXAN, scenario planning, and consequence tables) баяжуулж өгөхийг хүсч магадгүй юм.

- Эдгээр стандартууд нь нэр томъёог тодорхой томъёолж, туштай ашиглахыг эрмэлздэг** - Зорилго, зорилт, үйл ажиллагаа, хамгаалах үнэт зүйл, үе шат, үйл ажиллагааны үр дүн, хүрэх үр дүн гэх мэт нэр томъёоны талаар байгаль хамгааллын төлөвлөлтийн мэргэжилтнүүдийн дунд эцэс төгсгөлгүй маргаан байсаар байна. Энэ нь байгууллага, төсөл, хувь хүн бүр өөрийн гэсэн нэр томъёоны тайлбар ашиглах байгаатай холбоотой. Энд зөв хариулт гэж байхгүй. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд төслийн багийн гишүүд болон хамт ажилладаг хүмүүс сонгосон нэр томъёоны талаар тодорхой бөгөөд нийтлэг ойлголттой байх нь маш чухал гэж үздэг. Үүнийг харгалзан энэхүү гарын авлагад тусгагдсан голлох нэр томъёог анхааралтайгаар сонгож, анх удаа ашигласан бол доогуур нь зурж, туштай ашиглаж, эцэст нь нэр томъёоны тайлбар хэсэгт тодорхойлолтыг оруулж өгсөн. Төлөвлөлт, хяналт, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрөл бүрийн мэргэжлийн мэргэжилтнүүдийн өнөөгийн хэрэглээнд сууринлан тухайн нэр томъёоны сонголтыг хийж тайлбар, тодорхойлолтыг оруулсан. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандартууд шинэчлэгдэхийн хирээр мэдээлэл харилцааг сайжруулах, үндсэн зарчим, алхмуудыг батлахын тулд шинэчлэх шаардлагатай зарим нэр томъёог олж магадгүй юм (Энэ хувилбарын шинэчлэлтийг хүснэгт 1-ээс үзнэ үү).



ХАВСРАЛТ 4. БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙН ТОЙМ, ГАРАХ ҮР ДҮН

Дугаар алхам ба дэд алхамыг, (◊) тэмдэглэгээ нь тухайн алхамын хүрээнд гарах үр дүнг илэрхийлнэ. Бүх алхам, гарах үр дүн нь бүх нөхцөлд эсвэл бүх төслүүдэд тохиорхгүй байх магадлалтай бөгөөд шаардлагатай тохиолдолд нөхцөл байдалтайгаа уялдуулан өөрчилж болно.

1. Тодорхойлох

1a. Зорилгоо тодорхойлж, төслийн баг бүрдүүлэх

- ◊ Төлөвлөлтийн зорилго, шийдвэр гаргагчид тодорхой болж, төлөвлөлтийн ажлыг дэмжихэд шаардлагатай шийдвэрүүд гаргах
- ◊ Төслийн багийн ахлагч, голлох болон зөвлөх гишүүдийг сонгох
- ◊ Багийн гишүүдийн үр чадвар, чадавхижуулах хэрэгцээг тодорхойлох
- ◊ Багийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгож томилох

1b. Хамрах хүрээ, алсын хараа, байгаль хамгааллын үнэт зүйлсийг тодорхойлох

- ◊ Төслийн хамрах хүрээг товч тайлбарлах, боломжтой бол газрын зураг оруулах
- ◊ Төслийн алсын харааг тодорхойлох
- ◊ Байгаль хамгааллын үнэт зүйлсийг сонгож сонгосон үндэслэлийг товч бичих, боломжтой бол хамгаалах үнэт зүйл тус бүрийн байршилыг харуулсан газрын зураг хийж тайлбар оруулах
- ◊ Хамгаалахаа сонгосон үнэт зүйл тус бүрийн амьдрах чадварыг тодорхойлох
- ◊ Хэрэв хамааралтай бол хүний сайн сайхны төлөөх зорилт, экосистемийн үйлчилгээг тодорхойлж, үндэслэл бичих

1c. Ноцтой аюул дарамтыг тодорхойлох

- ◊ Шууд аюул дарамтыг тодорхойлж, шаардлагатай бол аюул дарамт тус бүрийн орон зайн үл мөрийг харуулсан газрын зураг оруулах
- ◊ Үүр амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг байдлыг тухайн боломжит нөхцөлд тохирсон түвшингээр нь үнэлэх
- ◊ Ноцтой аюул дарамтыг тодорхойлохын тулд аюул дарамтуудаа үнэлж, эрэмбэлэх

1d. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

- ◊ Шууд бус аюул дарамт болон боломжийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх
- ◊ Оролцогч талууд, тэдгээрийн анхдагч сонирхлыг тодорхойлж үнэлэх
- ◊ Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммын эхний хувилбарыг гаргаж дэлгэрэнгүй тайлбарлах, төслийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйл хоорондын бусад шалтгаан ба үр дагаврын хамаарлыг харуулах
- ◊ Диаграмм дээр ажиллаж засаж сайжруулах

2. Төлөвлөх

2a. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах: Зорилго, Стратеги, Таамаглал, Зорилт

- ◊ Байгаль хамгааллын үнэт зүйл тус бүрт зорилго тодорхойлох, хэрэв боломжтой бол хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг тодорхойлсон байх
- ◊ Хийх шаардлагатай гол арга хэмжээ болон стратеги тодорхойлох
- ◊ Стартегиудийг тэргүүлэх байдлаар нь эрэмбэлэх
- ◊ Өөрчлөлтийн онолын дагуу гол стратегийн хүрээнд багийн гишүүдийн дэвшүүлж буй таамаглал, хэрэжкүлэх үндсэн үйл ажиллагааг тодорхой болгох
- ◊ Завсарын үр дүнгүүдэд чиглэсэн зорилтоо тодорхойлох
- ◊ Үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэх

2b. Монитоинг, үнэлгээ, суралцах төлөвлөгөө боловсруулах

- ◊ Олон нийт, тэдгээрийн мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл харилцааны арга замыг тодорхойлох
- ◊ Шалгур үзүүлэлт, арга зүйг тодорхойлох
- ◊ Монитоинг, үнэлгээ, суралцах төлөвлөгөөг эцэслэх

2c. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах

- ◊ Хүн, санхүү болон бусад нөөцийн үнэлгээ хийх
- ◊ Эрсдлийн үнэлгээ, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- ◊ Төслийн оршин тогтоно хугацаа, дуусгах стратегийг тодорхойлох

3. Хэрэгжүүлэх

За. Богино хугацааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, хугацааг төлөвлөх

- ◊ Нарийвчилсан даалгавар, үйл ажиллагаа, хариуцах эзэн бүхий ажлын төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө хийх
- ◊ Цаг хугацааг төлөвлөх

3b. Төслийн төсөв боловсруулах, боловсронгуй болгох

- ◊ Төслийн төсөв тооцох
- ◊ Боломжит санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох
- ◊ Санхүүжилтийн санал боловсруулан өргөн барих
- ◊ Санхүүгийн эх үүсвэрийг олох

3c. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх

- ◊ Стратегийн (үйл ажиллагаа, мониторинг, гүйцэтгэлийн төлөвлөгөө) болон ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төслийн төсөв, хуваарь хийх
- ◊ Өгөгдөл цугуулах, хадгалах нэгдсэн системийг хөгжүүлэх
- ◊ Явцын тайлан гаргаж байгууллага, санхүүжүүлэгчид болон бусад оролцогч талуудад хүргэх
- ◊ Нэгдсэн системд хадгалагдаж буй мониторингийн өгөгдлийг хянах

4. Үр дүнг үнэлэх, төлөвлөлтийг уялдуулах

4a. Дүн шинжилгээнд зориулан өгөгдөл бэлдэх

- ◊ Төслийн шаардлагатай өгөгдлийг тогтмол цуглувуулж, бүртгэж, хадгалж, боловсруулах

4b. Үр дүнд дүн шинжилгээ хийх, тусгах

- ◊ Төслийн хүрээнд дэвшиүүлсэн таамаглал, үр дүнд дүн шинжилгээ хийх
- ◊ Үйл ажиллагааны мэдээлэл, санхүүгийн өгөгдөл дүн шинжилгээ хийх
- ◊ Хэлэлцүүлэг, шийдвэрийг баримтжуулах

4c. Стратегийн төлөвлөгөөг уялдуулах

- ◊ Үйл ажиллагааны төлөвлөгөө (жишээлбэл, хамгаалах үнэт зүйл, амьдрах чадвар, аюул дарамтын үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дүнгийн хэлхээ), мониторингийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын төлөвлөгөө, төсөв зэргийг багтаасан төслийн шинэчилэн боловсруулсан баримт бичгүүд
- ◊ Нотолгоо, хэлэлцүүлэг, шийдвэрийг баримтжуулах

5. Хуваалцах

5a. Сурсан зүйлээ баримтжуулах

- ◊ Гол үр дүн, хуримтлуулсан мэдлэгээ баримтжуулах

5b. Сурсанаа хуваалцах

- ◊ Шаардлагатай бол гол оролцогч талуудын мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл, харилцааны арга хэлбэрийг сайжруулах
- ◊ Төслийн багийн гишүүд болон гол оролцогч талууд тогтмол харилцаа холбоотой байх
- ◊ Нотлох баримт бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах
- ◊ Тохиromжтой сурталчилгааны материал боловсруулан гаргах, түгээх

5c. Суралцах орчныг дэмжих

- ◊ Албан ба албан бус байдлаар санал, хүсэлтээ тогтмол хуваалцах
- ◊ Аудит, шаардлагатай бол байгаль хамгааллын сайн туршлагаа үнэлэх
- ◊ Demonstrated commitment from leaders & staff to learning & innovation
- ◊ A safe environment for encouraging experimentation & questioning the status quo
- ◊ Амжилт, алдаа оноогоо дэлхийн бусад мэргэжлийн түүдтэй хуваалцах

Төлөвлөлтийн алхамуудыг зангидах нь

"Нээлттэй стандарт" байгаль хамгааллын төлөвлөлтийн арга зүй нь хамгааллын ажилд илүү сайн үр дүн гаргахын тулд нэгдсэн нэг үг хэллэг, арга зүйгээр хангахад тусална (Conservation Measures Partnership хөгжүүлэн боловсруулсан).

СМР-ийн гишүүд:

